

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2014 ОНЫ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ
/2014 оны жилийн эцсийн байдлаар/

2014-12-02

Д/д	Дүүргийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн явц	Хувь
Нэг. Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ. 1.1. Бизнес эрхлэгчдийг дэмжих талаар				
1	1.1.1. Зээлийн барьцаа, батлан даалтын хуулийг хэрэгжүүлэхэд дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн үйл ажиллагааг чиглүүлнэ.	Жижиг дунд үйлдвэрлэл, эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид урт хугацаатай, бага хүүтэй зээл олгоход дэмжлэг үзүүлж ажиллана.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг 2013 онд авсан 13 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ажлын явц, зээлийн зориулалтанд хяналт хийхэд төслийн хэрэгжилт 80%-тай байна. Жижиг дунд үйлдвэрлэлийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтэд 1,5 тэрбум төгрөг хуваарилагдсан бөгөөд нийт 113 төслийг хүлээн авснаас 39 төслийг шалгаруулан холбогдох банк санхүүгийн байгууллагад шилжүүлсэн. “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”, “Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сан”-гийн журам тус тус батлагдсантай холбогдуулан хороо бүрт 100,0 сая төгрөг буюу 3,2 тэрбум төгрөг хуваарилагдсан бөгөөд одоогоор 5 хороо хадгаламж зээлийн хоршоо байгуулан, тусгай зөвшөөрлөө авч, 4 хороо Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох материалаа хүргүүлэн тус хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна. Дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг 8 аж ахуйн нэгж байгууллагын жижиг дунд үйлвэрлэлийн зээлд /100.0 сая төгрөгөөс дээш санхүүжилт шаардлагатай/ хамрагдах хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлан ажиллаа.	90.0
2		Дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн чуулга уулзалт, зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны А/37 дугаар тушаалаар хороодын өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдтэй хийх уулзалтын хуваарийг батлан, 30 хорооны 487 үйлдвэрлэгчид оролцсон уулзалт, зөвлөгөөнийг 03-р сарын 19-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн нэмэгдүүлэх талаар “Нэгдэж бүтээцгээе” хэлэлцүүлгийг 04-р сарын 23-ны өдөр Соёмбо кино театрт 350 гаруй өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан төр	100.0

			болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Ажил олгогчдын нэгдсэн зөвлөлгөөн, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян”-ы нээлтийн ажиллагааг Соёмбо кино театрт зохион байгуулж 200 гаруй ажил олгогч оролцлоо. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/354 дүгээр захирамжаар жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлгөөнийг 10-р сарын 15-ны өдөр дүүргийн иргэний танхимд зохион байгуулж, 89 үйлдвэрлэл эрхлэгч нарыг хамруулсан. Зөвлөгөөнд Жижиг дунд үйлдвэрийн дэмжих төв НӨҮГ, Зээлийн батлан даалтын сан, дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвүүд, Дэлхийн зөн олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагууд хамтран оролцлоо.	
3	1.1.2. Аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалт, бизнес инкубаци болон төсөл хөтөлбөр боловсруулах зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ.	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бизнесийн сургалтанд хамруулж, инкубатор төв байгуулна.	Мэргэжлийн болон бизнесийн шат дараалсан сургалтад нийт 1165 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан. БНХАУ-ын Эрээн хотын Олон улсын дээд сургуультай хамтран модон эдлэлийн үйлдвэрийн дадлага хичээлд 7 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулав. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих “Сонгинохайрхан” төвд аж ахуйн болон бизнес хөгжүүлэх, жижиг зээлийн төсөл боловсруулах сургалтад 285 иргэн хамрагдсан бөгөөд тус төвд 13 үйлдвэр түрээсийн хөнгөлттэй нөхцлөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн “Би Жи Сервис” ХХК-д 5, “Хүний эрх, хүний хөгжил” ТББ-д 2, “Технож” бизнес инкубатор төвд 4, нийт 11 бойжигч бойжуулан ажиллаж байна. 31-р хорооны нутаг дэвсгэрт “Шинэ зуун гэр хороолол” ТББ-ын байранд бойжуулах төвийг байгуулан 3 ээлжээр 24 үйлдвэрлэгчийг /73,5 м2 талбай бүхий/ түрээсийн хөнгөлттэй байраар ханган ажилласан.	90.0
4		Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын цэг бий болгоно.	Хөдөлмөрийн яам, салбарын Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран түрээсийн хөнгөлттэй гэрээг байгуулан үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний байнгын ажиллагаатай худалдааг зохион байгуулж байгаа бөгөөд дүүргийн Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоогоор дамжуулан 2 лангуу, Түмэн плаза худалдааны төвд 4 павилионд 10 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. Түүнчлэн БНХАУ-ын Эрээн хотын 158м2 талбай бүхий худалдааны танхимд 3 иргэн, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын чөлөөт бүсэд 64м2 талбай бүхий худалдааны цэгт 2 иргэн, нийт 5 үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ худалдаалж байна. Дүүргийн ИТХ-ын	90.0

			Тэргүүлэгчдийн А/102 дугаар тогтоолоор дүүргийн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Сонгинохайрханд үйлдвэрлэв” борлуулалтыг дэмжих улирлын чанартай төвийг нээн ажиллуулж, 8-р сарын 16-аас 10-р сарын 15-ны хооронд 9 үйлдвэрлэгч бараа бүтээгдэхүүнээ борлуулсан.	
5	1.1.3. Дүүргийн эдийн засгийн тэргүүлэх 5 чиглэл болох сүү, мах, барилгын материал, сүлжмэл, оёдол, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг дээрх салбарт чиглүүлж, дүүргийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно	Сүлжмэл, оёдол, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгч иргэн, зорилтот бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	“Сонгинохайрханд үйлдвэрлэв-2014” үзэсгэлэн худалдааг Макс-21 худалдааны төвд 01-р сарын 25-28-ны хооронд зохион байгуулав. Тус үзэсгэлэнд 30 гаруй өрхийн үйлдвэрлэгчид 3 хоног оролцож, 3,0 сая орчим төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан. Дүнжингарав, Мишээл экспо төвд зохион байгуулагдсан “Цагаан сар 2014” үзэсгэлэн худалдаанд нийт 8 иргэн, 1 хоршоо, 2 бүлэг оролцуулж 2,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Инноваци хөгжлийн төвөөс гаргаж буй үндэсний үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний каталогт гар урлал, сийлбэр, оёдол, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дүүргийн Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн 4 нэр төрлийн 20 гаруй бүтээгдэхүүний загвар зургийг оруулсан. 02-р сарын 25-ны өдөр оёдол, сүлжмэл, гар урлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 16 өрхийн үйлдвэр эрхлэгчийг санал солилцуулах, дэвшилтэд технологитой танилцуулах зорилгоор бизнес аялал зохион байгуулсан. Хөдөлмөрийн яам, Мишээл групптэй хамтран 07-р сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулсан “Бүтээлч Монгол-2014” үзэсгэлэн худалдаанд дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгч 26 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг оролцуулан 24,1 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүн борлуулсан. Тус үзэсгэлэнгээс 31-р хорооны өрхийн үйлдвэрлэгч иргэн Д.Алтантуяа “Шилдэг жижиг дунд үйдвэр эрхлэгч”-ээр шалгарлаа. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих “Сонгинохайрхан”төвд бойжиж буй 4 үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж 5,3 сая төгрөгийн өртөг бүхий 4 оёдлын машиныг 100 хувийн хөнгөлттэйгээр олгов.	90.0
6		Экологийн цэвэр бүтээгдэхүүн шалгаруулах уралдааныг зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнүүдийг сурталчлах ажлыг зохион байгуулна.	Дүүргийн экологийн цэвэр бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг Драгон төвд 10-р сарын 14-ний өдөр зохион байгуулав. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй 40 гаруй иргэн, аж ахуйн нэгж үзэсгэлэнд оролцож, бүтээгдэхүүнээ сурталчилж, худалдааллаа. Талх чихэр ХК, Тэсо ХХК, Монсүү ХХК, Их тайга ХХК, Мон жүүс ХХК зэрэг томоохон үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний амталгаат худалдааг зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр ажлын хэсгийн бүрэлдэхүүн “Шилдэгийн шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр “Их	90.0

			тайга” ХХК, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр “Ховор угалз”, “Оюунлаг мандах ТББ”, “Сионы жүүс” ХХК-иудыг шалгаруулсан. Тус үзэсгэлэн худалдааг зохион байгуулах талаар зар мэдээлэл, шилдгээр шалгарсан аж ахуй нэгжүүдийг хороодын Засаг дарга нарын шуурхай хурал болон дүүргийн вэб сайтаар мэдээлэн ажиллалаа.	
7		Сүү, махны эрчимжсэн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх цогц, фермер байгуулах боломжтой 8 байршлыг тогтоон Засаг даргын 2/3135 тоот албан бичгээр Нийслэлийн үйлдвэр хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд сүүний чиглэлийн “50 үнээний цогцолбор барилга”-ын техник эдийн засгийн үндэслэлийг Улаанбаатар хотын Ерөнхий архитектороор батлуулж, нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газартай хамтран Жаргалант тосгоны фермүүдийн макет хийлгэхээр Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.0 сая төгрөг гаргаж тендер зарлахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 10 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 395,0 сая төгрөгийн өртөг бүхий төслийг дэмжин холбогдох байгууллагад уламжлав. “Эзэнтэй монгол” хөтөлбөрийн хүрээнд Сүүн сувилал амралтын газарт 30 хүнийг түр ажлын байраар хангасан.	100.0
8	1.1.4. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.	21 дүгээр хороо 361-ийн гарам орчим “Дүүргийн жижиг дунд үйлдвэрийн парк” байгуулах боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангана.	“Сонгинохайрхан-361” жижиг дунд үйлдвэрийн бүсийг 21-р хорооны нутаг дэвсгэр 361-ийн гармын орчимд байгуулах саналыг нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтод тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1020 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Тус үйлдвэрийн бүсийн урьдчилсан төсөөлөл, төсвийг цаасан болон шторк хэлбэрээр хийлгэсэн бөгөөд гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулан ажиллаж байна.	50.0
9	1.1.5. Газар тариалан, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулна.	Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнийг нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газартай хамтран 04-р сарын 18-ны өдөр 21-р хороо 361-ийн гармын “Их булгийн тохой” ХХК-ий тариалангийн талбайд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны дэд сайд, нийслэлийн Засаг даргын Экологи байгаль орчин хариуцсан орлогч, нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын дарга, 154 иргэд, 17 аж ахуйн нэгж байгууллага оролцлоо. Уг зөвлөгөөнөөр хүлэмж, зоорины аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого, бага, дунд оврын техник, тракторын ашиглалт, арчилгаа, хамгаалалт, төмс, хүнсний ногоо,	100.0

			жимс, жимсгэнэ, таримал ургамлуудад түгээмэл хэрэглэгдэж буй усалгааны системийг хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.	
10		Төмс, хүнсний ногоо худалдаалах цэгүүд байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулна.	Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааг Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоотой хамтран 5 цэгт зохион байгууллаа. 5 цэгт 70 иргэн төмс 55,8 тн, хүнсний ногоо 96,2 тн-г худалдаалж нийт 148.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төмс 169 га-д тарьж 2551,9 тн, хүнсний ногоо 166 га-д тарьж 3154 тн ургац тус тус хураан авсан.	100.0
11		Газар тариалан, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар олгож, өмнөх онуудад дээрх зориулалтаар олгосон газруудын ашиглалтад хяналт тавьж ажиллана.	21-р хороонд хөдөө аж ахуйн зориулалтаар газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүсэлт тавьж төсөл сонгон шалгаруулах тухай тогтоол гаргуулахаар бэлтгээд байна. 21-р хорооны Тарвагатай амны 100 га газарт 100 иргэнийг 5 бүлэгт хуваан төмс, хүнсний ногоо, нарийн ногоог тариулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэх хүсэлтэй 7 иргэнд 7.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээд байна. Дүүргийн хэмжээнд газар тариалан, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах чиглэлээр газар эзэмшиж буй 991 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж газар зохион байгуулалтын бүсчилсэн төлөвлөгөө гаргаж ARCGIS программ дээр бүртгэл хөтөлж танилцуулга бэлтгээд байна. Мөн газраа зориулалтын дагуу ашиглаагүй, 2 ба түүнээс дээш жил ашиглаагүй, олгогдсон талбайгаас илүү хашсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зөрчлийг арилгах талаар мэдэгдэл хүргүүлж ажиллалаа.	90.0
12		Хүлэмж, зоорины аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр аж ахуй эрхлэх талаар үзүүлэх сургуулийг 2-с доошгүй удаа зохион байгуулна.	Хүлэмж, зоорины чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг 171 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг гаргасан. Хүлэмж, зоорины аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэх, бага, дунд оврын техник тракторын ашиглалт, арчилгаа, хамгаалалтын практик сургалт, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамлуудад түгээмэл хэрэглэгдэж буй усалгааны системийг хэрхэн ашиглах, сонгох талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслах аж ахуйн үзүүлэх сургалтуудыг нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газартай хамтран 04-р сарын 17-18, 09-р сарын 26-ны өдрүүдэд 21-р хороо 361 гармын “Их	100.0

			булгийн тохой”, Түмэн сүйх ХХК-ий тариалангийн талбайд 2 удаа зохион байгуулсан. Тус сургалтуудад нийт 139 иргэн, 26 аж ахуйн нэгж байгууллага оролцсон.	
13	1.1.6. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Малыг ээмэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулна.	Нийт 11400 бод ээмэгжүүлэхээс 11180 бод, 8000 бог ээмэгжүүлэхээс 100 хувь тус тус ээмэгжүүлэн нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын мэдээллийн санд оруулсан.	100.0
14		Мал, амьтдын вакцинжуулалтын ажлыг зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн мал, амьтдын хавар, намрын вакцинжуулалтын ажлыг мал эмнэлэг үржлийн 3 нэгжээр дамжуулан гүйцэтгэв. Хавар, намрын вакцинжуулалтад 94,1 мянган толгой малыг хамруулж, 90 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Хаврын вакцинжуулалтын зардалд 15,9 сая төгрөг зарцуулсан.	90.0
15		Туслах аж ахуй хөгжүүлэх чиглэлээр сургалтууд зохион байгуулж, шинээр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Нийслэлийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газартай хамтран “Гахайн аж ахуйн эрхлэхүй” сэдэвт чадваржуулах сургалт, зөгийн аж ахуй эрхлэгчдийн дунд мэргэшүүлэх 3 хоногийн сургалт, “Туслах аж ахуйг хэрхэн хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад 75 иргэн, 12 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 10 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 395,0 сая төгрөгийн өртөг бүхий төслийг дэмжин холбогдох байгууллагад уламжлав.	90.0
16		Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтыг сайжруулж, Эмээлт дэх түүхий эдийн захуудын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг тогтмолжуулна.	Эмээлт түүхий эдийн захын орчимд зөвшөөрөлгүйгээр мал худалдаалж буй байдалд хяналт шалгалтыг өдөр тутам хийж нийт 53 иргэн, 29 машинтай худалдаа, 4 хуушуурын цэг, 13 нядалгааны гэрт хяналт шалгалт хийлээ. Баруун аймгуудаас орж ирсэн 621 хонь, 333 ямаа, 38 үхрийг Эмээлт түүхий эдийн захын урд хэсэг суварганы орчим байрлуулж ажилласан ба хяналт шалгалтыг тасралтгүй явуулж байна.	90.0
17	1.1.7. Худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч	Худалдаа, нийтийн хоолны газруудын цагийн хуваарийг мөрдүүлж, хяналтын системийг боловсронгуй болгон камержуулалтыг 80 хувьд хүргэнэ.	Шинэ жил, сар шинэ нэгдсэн арга хэмжээний үеэр болон Засаг даргын 2014 оны А/49 дүгээр захирамж, ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт зохион байгуулж, давхардсан тоогоор худалдааны 470 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулсан. Хяналт шалгалтаар цаг хэтрүүлэн ажилласан 2-р хорооны Зүлэгт трейд, 27-р хорооны Тайхарын хүрээ ХХК-ийг 500.0 мян төгрөгөөр торгон, 14-р хорооны “Баясах оюу” ХХК-ны Рокси баарны архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож ажилласан. Хяналтын системийг эрчимжүүлэх ажлын хүрээнд нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудад Сорс	90.0

	ажиллана.		армар ХХК-ий камер, дохиоллын талаарх танилцуулга, мэдээллийг хүргэн хамтарч ажилласнаар худалдааны 609 аж ахуйн нэгж байгууллагын 76,1, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний согтууруулах ундаа, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 198 аж ахуйн нэгжийн 80,3 хувь нь хяналтын камер суурилуулсан байна.	
18		Орон сууцны нэг болон суурийн давхарт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгохгүй байх чиглэл баримтлан ажиллана.	Тайлант онд орон сууцны нэг давхарт үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгж согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл хүссэн ба ойролцоох /15, 18-р хороодын 40-р байр, Залуус хорооллын байрны/ оршин суугчдаас санал авахад дийлэнх хувь нь татгалзсан тул зөвшөөрөл олгоогүй болно.	100.0
19		Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт зохион байгуулж, аттестатчилал явуулж, худалдаалах цэгийн тоог бууруулна.	Согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацаа 2014 онд дуусах худалдааны 139, нийтийн хоолны 52 газруудыг аттестатчиллаа. Аттестатчилалаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 63, 61, 07 дугаар тогтоолууд, “Худалдааны газар, түүний үйлчилгээ” MNS 5021:2007 стандартын шаардлагыг хангасан худалдааны 92, нийтийн хоолны 49 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, худалдааны 3 байгууллагын эрх сэргээх, 3 аж ахуйн нэгжийн нэр шилжүүлэх, худалдааны 25, нийтийн хоолны 3 аж ахуйн нэгжийн эрхийг цуцлах санал, дүгнэлтийг нийслэлийн ЗАА-нд уламжлан шийдвэрлүүлж, хүнсний аюулгүй байдал, хяналтын систем, камержуулах ажлыг эрчимжүүлэх, орчны 50м талбайн ногоон байгууламж, тохижилтыг сайжруулах, бизнесийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгоход хуулийн хүрээнд хамтран ажиллах, мэргэжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллаа.	100.0
20		Худалдаа үйлчилгээний салбарт мөрдөгдөх хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр ААНБ-дад сурталчилж, эмхэтгэл байдлаар хэвлүүлэн тараах ажлыг зохион байгуулна.	“Архигүй баасан гараг” дүүргийн дэд хөтөлбөр, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”-ын шинэчилсэн өөрчлөлт, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 63, 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Хот тохижилтын талаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас дагаж мөрдөх журам”, Тамхины хяналтын тухай хуулийг /Хууль, нийслэлийн журам, дүүргийн хөтөлбөр гэсэн дараалалд оруулах/ хэрэгжүүлэх, сурталчлах ажлын хүрээнд дүүргийн ГХУСАЗЗөвлөл, Гэр хороолол дахь Захирагчийн ажлын албадтай хамтран худалдааны 750 гаруй аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан сургалт зохион байгуулж, эмхэтгэл ном 500ш, боршур 1000ш-ийг тус тус хэвлүүлэн тараалаа.	100.0

21		Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, дэн буудлын үйлчилгээний ажилтнуудын дунд холбогдох хууль тогтоомж стандартын чиглэлээр сургалт зохион байгуулна.	Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 6 томоохон зочид буудлын 16 ажилчдыг хамруулан “Гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг Худалдаа аж үйлдвэрийн танхимд 5-р сарын 20-нд зохион байгуулсан. Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын зочид буудлуудын холбоотой хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр “Найрсаг улаанбаатар” аялал жуулчлалын сургалтыг “UB city” зочид буудал дээр 6-р сарын 12-ны өдөр зохион байгуулж 22 зочид буудлын эзэд болон үйлчилгээний ажилчдыг хамруулсан.	100.0
22		Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Худалдаа, нийтийн хоолны 35 аж ахуйн нэгж байгууллагын 120 ажилтан албан хаагчдыг оролцуулан 2 удаа сургалт зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын А/49 дүгээр захирамжийн дагуу холбогдох хэлтэс албад дүүргийн ГХУСА33-тэй хамтран хяналт шалгалтыг 2 удаа зохион байгууллаа. Хяналт шалгалтанд /давхардсан тоогоор/ худалдааны 319, зочид буудал, дэн буудал 17, нийтийн хоолны 67 аж ахуйн нэгж хамрагдсан. Тус шалгалтаар зохих зөвшөөрөлгүй архи согтууруулах ундаа худалдсан, стандартын шаардлага хангаагүй, хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүн болон ЕБС-с 500м-ийн тойрогт тамхи худалдаалсан, тусгай зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн, тусгай зөвшөөрөлгүй согтууруулах ундаа худалдаалж, үйлчилсэн зэрэг нийт 308 зөрчил илрүүлэн, худалдааны 21 аж ахуйн нэгж, иргэнээс 1153ш тамхи, 54 шил архийг тус тус хурааж, захиргааны журмаар хураагдсан эд зүйлийг улсын орлого болгох, устгах орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. Нийт 57 аж ахуйн нэгж, иргэнд хууль, хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад 7,5 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулан, 49 заалт бүхий 8 албан шаардлага өгч зөрчлийг арилгуулж ажиллалаа.	90.0
23		Хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газруудад дотоод хяналтын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Давхардсан тоогоор 42 аж ахуйн нэгжийн удирдлагад дотоодын хяналт шалгалтыг чанар, үр дүнтэй зохион байгуулах талаар 3 удаагийн сургалт зохион байгуулж, гарын авлага, зөвлөмж тараасан ба төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдаж буй газруудад дотоод хяналтыг нэвтрүүлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.	100.0

24		Худалдаа, нийтийн хоолны газруудад төлөвлөгөөний дагуу хяналтын хуудсаар шалгалт хийж эрсдэлийг тогтоож зөрчлийг арилгуулна.	Худалдаа, нийтийн хоолны 58 аж ахуйн нэгжид хяналтын хуудсаар хяналт шалгалт явуулав. Шалгалтын явцад 290 зөрчил илрүүлэн 73-ийг газар дээр нь арилгуулан, эрсдэл өндөртэй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулж байсан 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоон, 21 аж ахуйн нэгжид 96 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн тодорхой ажил зохион байгуулж эрсдлийг бууруулан ажилласан. 8 аж ахуйн нэгжид нийт 4.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулав.	90.0
25		Халуун ус сауны газруудад орчны эрүүл ахуй, байгаль орчны хяналтын чиглэлээр хяналт шалгалт зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана	“Саун, халуун усны газруудад тандалт судалгаа хийх” удирдамжийн дагуу 05-р сарын 26-ны өдөр хяналт шалгалт явуулсан. Тус шалгалтанд эрсдэлтэй 12 халуун ус, сауны газар хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарсан зөрчлийг арилгуулах тухай албан шаардлага хүргүүлсэн. 19-р хорооны иргэдээс ирсэн гомдлын дагуу 8-р байрны өргөтгөлд үйл ажиллагаа явуулж байсан “21” нэртэй халуун усны үйл ажиллагааг түр зогсоогоод байна.	90.0
26		Аялал, жуулчлалын байгууллагуудад стандартыг мөрдүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын А/449 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудад стандартын үзлэг, шалгалт зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран 6-р сарын 16-20-ны өдрүүдэд 8 амралт, жуулчны бааз, гэр буудалд стандартын үзлэг шалгалтыг явуулахад стандартын шаардлага хангасан-3, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн-3, шаардлага хангаагүй-2 аж ахуйн нэгж байна. Ажлын хэсгийн дүгнэлт, санал, стандартын биелэлтийг гарган нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүлсэн. Зөвшөөрөлгүй зочид буудал, дэн буудлуудын талаар авах арга хэмжээний тухай нийслэлийн Засаг даргын А/448 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран 13-р хорооны нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 9 дэн буудлын цахилгаан, дулааныг таслан үйл ажиллагааг албадан зогсоосон.	90.0
27	1.1.8. Толгойт, Баянхошуу, Өнөр бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны	Байршлыг тогтоон, газрын үнийг судлан, одоо байгаа үйлчилгээний цэг, салбараа өргөтгөхөөр ирүүлсэн иргэд ААН-ийн санал санаачлагыг дэмжиж ажиллана.	Үүрт гоулд ХХК Хүнс трейдийн ард байрлалтай өөрийн эзэмшлийн газарт Толгойт бүсийн ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээг ойртуулах зорилгоор худалдааны цогцолбор барих хүсэлт ирүүлснийг судлан, нийслэлийн Өмчийн харилцааны албанд хандаж, хот төлөвлөлтийн судалгаанд хамрагдаж зөвшөөрөл авах тухай	90.0

	худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулах санаачлагыг дэмжинэ.		зөвлөлөө. 1-р хороонд Алтан жолоо импекс ХХК худалдааны цогцолбор ложистик төв, 7-р хорооны Цэнгэл таван ихэр ХХК-ий Сувдан худалдааны төв, 9-р хорооны Шар нуурын мандал ХХК-ий Жи Эм Жи төв, 20-р хороонд Бишрэлт трейд ХХК, 32-р хорооны нутаг дэвсгэрт Макс хүнс ХХК, Номин тав трейд ХХК-иуд 30-70 гаруй хүний ажлын байр бий болгож, цэг салбараа өргөтгөсөн үйл ажиллагааг дэмжин холбогдох гэрээ байгуулан, зөвшөөрөл олгож ажилласан.	
28	1.1.9. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.	Эрүүл аюулгүй хүнс, зохистой хооллолт, хүнсний аюулгүй байдлын талаар дүүргийн нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тогооч нарын дунд сургалт зохион байгуулна.	НЭМГ, ШУТИС, ЗАА-тай хамтран “Эрүүл аюулгүй хүнс, зөв зохистой хооллолт” сургалтыг 3-р сарын 21-нд ЗАА-ны “Хангарьд” байрны хурлын танхимд зохион байгууллаа. Сургалтад нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 60 аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулав. “Эрүүл хүнс, зөв зохистой хооллолт, тэжээлийн дутлаас урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт сургалт, хоолны өдөрлөгийг 79, 156-р цэцэрлэгийн тогооч, багш нартай хамтран 2 удаа зохион байгуулсан. Тус өдөрлөгүүдэд 110 эцэг, эхчүүдийг оролцуулав “Эрүүл, зөв хоолыг эрхэмлэгч ресторан” шалгаруулах ажлын хүрээнд “Эрүүл зөв хооллолт, аюулгүй хүнсний хэрэглээ сэдэвт сургалтыг дүүргийн ЭМТ-ийн хоол, шим тэжээлийн төвд зохион байгууллаа. Сургалтанд нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан.	100.0
29		Нөөцийн махны худалдааг зохион байгуулна.	Стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон 32 хорооны 92 дэлгүүрээр дамжуулан нийт 1197,1 тн нөөцийн мах борлуулсан байна. “Өрх бүрт нэг гулууз” нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 7 хоног бүрийн Баасан, Бямба, Ням гарагуудад МАКС худалдааны төвийн урд талбай болон “21 шөнийн зах”-ын хажууд зохион байгуулсан.	100.0
30	1.1.10. Архи, тамхины болон эрүүл бус хүнсний хэрэглээг бууруулах бүх нийтийн аян өрнүүлэх замаар эрүүл, соёлтой үйлчилгээ үзүүлдэг бизнесийн байгууллагыг дэмжинэ.	24 цагийн ажиллагаатай нийтийн хоолны газрууд бий болгох боломж нөхцлийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	Нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Шөлөндөө” сүлжээ хоолны газрын 24 цагаар үйл ажиллагаа явуулах хүсэлтийг Захирагчийн ажлын албанд 3/2696 дугаар албан тоотой уламжилсан боловч нийслэлийн Засаг даргын А/548 дугаар захирамжийн дагуу 24 цагаар ажиллах зөвшөөрөл олгох боломжгүй гэсэн хариу ирсэн. Зуны улиралд гадна задгай талбайгаа тохижуулан уртасгасан цагаар үйлчилгээ явуулах хүсэлт гаргасан 9 аж ахуйн нэгж, байгууллагын худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлтийг ЗАА-нд ЗДТГ-ын 3/1075 албан тоотой уламжилснаар тус аж ахуйн нэгжүүдэд ЗАА-аас шөнийн 03 цаг хүртэл ажиллах улирлын тусгай зөвшөөрлийн эрх олголоо.	90.0

31		Согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн дунд “Сүүтэй, бялуутай үдэш” үйлчилгээг нэвтрүүлнэ.	“Архигүй Баасан гараг” дэд хөтөлбөрийн хүрээнд архи, тамхины хор хөнөөлийг олон нийт, залуучуудад ойлгуулан таниулах, эрүүл зөв хооллолт, аюулгүй хүнсний хэрэглээг хүн амын дунд төлөвшүүлэх зорилгоор “Сүүтэй бялуутай үдэш” аяны нээлтийн ажиллагааг 10-р сарын 22-нд Цамбагаравын Рокси диско бааранд зохион байгууллаа. Нээлтийн ажиллагаанд дүүргийн удирдлага, Мандах бүртгэл дээд сургуулийн 63 оюутан, багш нар оролцлоо. Тус аяны санаачлагын тугийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 4 аж ахуйн нэгжээр аялуулаад байна.	90.0
32	1.1.11. Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэн өмчилсөн газраа эдийн засгийн эргэлтэнд оруулахад дэмжлэг үзүүлнэ.	Иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын 16 удаагийн захирамжаар 5036 иргэний шинээр газар өмчлөх, 1122 иргэний хамтран өмчлөгч хасуулсан болон кадастрын зураг өөрчлөгдсөн, 10 иргэний 0.55 га-аас илүү гарсан талбайгаа үнээр худалдан авсан, нийт 6168 иргэний хүсэлтийг шийдвэрлүүлсэнээс зөрчилтэй 58 иргэний газар дээр очиж асуудлыг шийдвэрлэсэн болно. Газар өмчлөх ажлыг эрчимжүүлэх зорилгоор алслагдсан хороо болох 21-р хороонд 1 сарын хугацаанд 7 хоног болгоны 4 дэх өдөр хороо хариуцсан газар зохион байгуулагч иргэдийг мэдээллээр ханган, өргөдөл авч ажилласан. Ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын захирамжаар 28 иргэнд газар өмчлүүлэх тухай шийдвэрийг гардуулсан.	100.0
33		СХД-ийн 24 дүгээр хороо Баруун салаа, 25 дугаар хороо Зүүн салаанд зуслангийн зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эхлүүлнэ.	24-р хороо Баруун салааны зуслан, 25-р хороо Зүүн салааны зусланд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг эхлүүлэхээр нийслэлийн Өмчийн харилцааны газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгүүлэх талаар санал хүргүүлсэн.	90.0
34	1.1.12. Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг ойртуулна.	Монголын үсчин гоо засалчдын холбоотой хамтран мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, дүүргийн аварга үсчин, гоо засалч шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	Нийслэлийн ЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран үсчин, гоо засалчид болон бизнес эрхлэгч нарт зориулсан сургалтыг 3 сарын 28-нд зохион байгуулж 20 гаруй үсчин, гоо засалчдийг хамрууллаа. Монголын үсчин гоо засалчдын холбооны дэргэдэх залуусын “Polaris” клубтэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулж буй 22 үсчинг хамруулан үзүүлэх сургалтыг дүүргийн Иргэний танхимд 5-р сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Нийслэлийн ЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Schwarzkopf professional брэндийн монгол дахь албан ёсны дистрибьютор “Дождь” ХХК-тай хамтран “Мэргэжлийн бүтээгдэхүүний хэрэглээ, үс арчилгаа” сэдэвт сургалт 11-р сарын 19-ны өдөр зохион	100.0

			байгууллаа. Сургалтад 20 үсчин хамрагдсан. Дүүргийн 2014 оны аварга үсчин, гоо засалчдыг шалгаруулах ажил мэргэжлийн уралдааныг дүүргийн Засаг даргын А/127 дугаар захирамжийн дагуу 04-р сарын 25-ны өдөр 82-р сургуулийн урлагийн зааланд 25 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулж 2014 оны шилдгийн шилдэг үсчнээр “Жавхлант” мастер салоны үсчин Д.Пүрэвдэлгэр шалгарлаа.	
35		Дүүргийн нутаг дэвсгэрт ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт гоо сайхан, хими цэвэрлэгээний чиглэлээр үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалт явуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Шалгалтанд гоо сайхны 9, хими цэвэрлэгээний 1, захиалга хүлээн авах 10 цэг хамрагдан, бүтээгдэхүүний шинжилгээний бичиг баталгаагүй, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангахгүй, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй зэрэг нийтлэг зөрчлүүдийг арилгуулав. Стандартчилал хэмжил зүйн газартай хамтран үнэт металл, алт мөнгөний дарханы үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд 5-р сарын 28, 30-ны өдрүүдэд хяналт шалгалт явуулсан. Эдгээрээс үйлдвэрийн шинж чанартай 3, иргэдэд шууд үйлчилгээ үзүүлж буй 6 иргэн, аж ахуйн нэгж хамрагдан илэрсэн зөрчлийг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.	100.0
1.2. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын талаар				
36	1.2.1. Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, дүүргийн эдийн засгийн хөгжлийг сайжруулна.	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.	2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр: Улсын төсөвт 32467.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 31387.9 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 96.6 хувь Нийслэлийн төсөвт 22317.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 21825.1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 97,7 хувь Орон нутгийн төсөвт 6805.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 6908.2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 101,5 хувиар тус тус биелүүлэхээр байна.	100.0
37		Улсын төсвийн болон орон нутгийн байгууллагуудын төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулан оновчтой хуваарилах замаар зардлын гүйцэтгэлд тавих	Дүүргийн төсвийн 2014 оны орлого, зарлагын хуваарийг батлуулан, нийт төсвийн 128 байгууллагад хүргүүлэв. 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 37 төрийн, 38 төрийн бус цэцэрлэгт нийт 17494990.2 мянган төгрөг, 17 төрийн, 8 төрийн бус сургуульд нийт 28369193.4 мянган төгрөг, 26 өрхийн эмнэлэгт 3136084.5 мянган төгрөг, 14 орон	100.0

		<p>хяналтыг сайжруулан төсвөөс төлөх өргүй ажиллах чиглэл баримтлан ажиллана.</p>	<p>нутгийн байгууллагад 16218989.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор байна. Нийт 98 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэж нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр хүүхдийн цэцэрлэгүүд 416365,9 мянган төгрөгийн өглөгтэй гарахаар байна. Үүний 93,4 хувь нь хүүхдийн хоол, 6,6 хувь нь тогтмол зардлын өр гарахаар байна. Ерөнхий боловсролын сургуулийн 2013 оны жилийн эцсийн үлдэгдэл өглөг болох 215251,5 мянган төгрөг, эхний хагас жилд үүссэн цалин болон тогтмол зардлын өглөг 156965,2 мянган төгрөг нийт 372216,7 мянган төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулж ажиллаа. Өрийн судалгаа гаргаж, өглөгтэй гарсан байгууллагуудад нийслэлийн ЗДТГ-ын СТСХ болон нийслэлийн Боловсролын газартай хамтарсан шалгалт хийж өр үүссэн нөхцөл байдалд дүгнэлт өгөн ажиллаж байна. 2014 оны төсвийг хэмнэн ажиллаж урьд оны өрийг барагдуулах зорилгоор төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Дүүргийн Дотоод аудитаас хийсэн шалгалтын дагуу хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарын цалин тогтоолт болон үр дүнгийн урамшууллын тушаал, шийдвэрт хяналт тавьж 5316,5 мянган төгрөгийг хэмнэж ажиллалаа. Мөн хүүхдийн цэцэрлэгийн өрийг барагдуулах талаар тооцоо судалгааг гарган нэгтгэж нийслэлийн ЗДТГ-ийн СТСХ болон нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Үүний дагуу сургуулийн төсвөөс 679077,9 мянган төгрөгийг цэцэрлэгийн төсөв рүү шилжүүлэн зарцуулах хүсэлт тавиад байна. Энэ асуудал шийдвэрлэгдвэл хүүхдийн цэцэрлэг өргүй гарахаар байна. Төсөвт байгууллагуудын төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд хамт олны оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн санхүүгийн мэдлэгийг сайжруулах зорилгоор байгууллагуудад нээлттэй самбар ажиллуулж, мэдээллийг байнга шинэчлэх ажлыг хэвшүүлсэн. Төсөвт байгууллагын хандив тусламжаар авсан хөрөнгийг цаг тухай бүрт нь бүртгэлжүүлэхээр нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран ажиллаж, хандив тусламжаар ирж байгаа үндсэн хөрөнгийн жагсаалтыг цаг тухай бүрт гаргуулан авч бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. 3-р улирлын байдлаар хандив тусламжаар ирсэн 1689,6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаж ажиллаа. Мөн салбарын яамдаас ирж байгаа бараа материал болон үндсэн хөрөнгийн жагсаалтыг холбогдох газруудаас гаргуулан авч санхүүгийн тайланд</p>	
--	--	---	--	--

			<p>тусгах ажлыг хийж хэвшээд байна. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг дууссан цаг тухай бүрт нь бүртгэлжүүлэх ажил үргэлжилж байна. Төрийн сангийн нийт 122 байгууллагын 145 дансаар төрийн сангийн үйлчилгээг үзүүлж ямар нэгэн чирэгдэл гаргахгүй байхаар ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд өдөрт дунджаар 130 төлбөр тооцооны гүйлгээ хийгдэж нийт гүйлгээний тоо 17888, үнийн дүн 158,9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тус төрийн сан банкинд байршиж буй дүүргийн төсөвтэй харьцдаг улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын талаарх мэдээллийг хавсралтаар нийслэлийн Аудитын газарт хүргүүллээ. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/578 дугаар захирамжийн дагуу улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын бэлэн мөнгөний картын дансыг Улаанбаатар банкинд байршуулж, төлбөр тооцооны нэгдсэн байдлыг хангаж, хяналт тавин ажиллаж байна.</p>	
38	Дүүргийн төсөвт байгууллага болон аж ахуйн нэгжийн санхүүгийн ажилтнуудад шат дараатай сургалтууд зохион байгуулна.	<p>Нийслэлийн Аудитын газартай хамтран жилийн эцсийн тайлан бэлтгэх, түүнд залруулга хийх, интернетээр тайлан шивэх талаар сургалт зохион байгуулж төсвийн байгууллагын 58 нягтлан бодогчийг хамруулав. Сангийн сайдын 2013 оны 122 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь, хавсран гүйцэтгэж буй ажлын судалгааг гарган хавсралтаар Сангийн яаманд хүргүүлэн ажиллаа. Өмчийн программ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран бүх байгууллагуудын баазыг шинэчлэн сургалт зохион байгууллаа. 4-р сарын 23-наас 5-р сарын 5-ны өдрүүдэд ММНБИ-тэй хамтран мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтанд бэлтгэх сургалт зохион байгуулав. Уг сургалтад 21 хүн хамрагдаж, мэргэшсэн нягтлан бодогчийн сорил шалгалтанд 25 хүн оролцов. БНХАУ-ын Манжуур хотноо зохион байгуулагдсан Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн сургалтад төсвийн байгууллагын 30 нягтлан бодогчийг хамруулав. Мөн СТСХ-ийн 6 мэргэжилтэн нийслэлийн СТСХ болон Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан байна. 7-р сарын 3-нд нийслэлийн Аудитын газартай хамтарсан сургалт зохион байгуулж нийт 140 орчим хүн оролцсон. Мөн Төрийн сангийн</p>	90.0	

			удирдах ажилтаны Улсын 9-р зөвөлгөөнд Санхүү төрийн сангийн хэлтсийн ажилтнууд бүрэн бүрэлдэхүүнээр оролцсон болно. Дэлхийн нягтлан бодогчдын 19-р чуулга уулзалтанд 1 хүн оролцов.	
39	1.2.2. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, цаашдаа төсвөөс авах татаасыг бууруулах чиглэлд бодлогыг уялдуулна.	“Дүүргийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг холбогдох газруудаас санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд: <ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд эд хөрөнгө худалдан борлуулсны тэмдэгтийн хураамжийг Сүхбаатар дүүргийн татварын албанд төвлөрүүлдэг байсныг дүүргийн татварын хэлтэст төвлөрүүлдэг болсон. 2. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/194 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аж ахуйн нэгжүүдээр 08-р сарын 01 хүртэлх хугацаанд явж, ус, рашаан ашигласны гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан байна. 3. Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс үзүүлдэг болсонтой холбогдуулан Төсвийн тухай хуулийн 23, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг уг бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй нутаг дэвсгэрийн татварын байгууллагын дансанд 5-р сараас эхлэн төвлөрүүлдэг болсон. 4. Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлдөг аж ахуйн нэгж байгууллагуудад үзлэг шалгалт хийж төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа. 	70.0
40	1.2.3. Төсвийн болон Татварын хууль тогтоомжийг сурталчлах, байгууллага, иргэнийг татварт бүрэн хамруулах, татварын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, өр барагдуулах	Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил төлбөрт тогтоосон актыг барагдуулах, шаардлагатай тохиолдолд энэ талаар олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулж “Шилдэг татвар төлөгч Аж ахуйн нэгж, иргэн” шалгаруулж сурталчилна.	624 аж ахуйн нэгж, 35 хувь хүнтэй холбоотой шалгалт хийж 309237.1 сая төгрөгийн зөрчил илрүүлэн ажилласан ба 2401.3 сая төгрөгийн төлбөр ногдуулан төлүүлэхээр акт тогтоож 860.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна. Татвар төлөгчдийн өдрүүдээр тус дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй, үйл ажиллагаа нь тогтмолжсон, иргэнийхээ үүргийг биелүүлж улс, нийслэл, орон нутгийн төсөв бүрдүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулдаг татвар төлөгчдийг шалгаруулж урамшуулав.	90.0

	менежментийг боловсронгуй болгоно.		<p>Шилдэг аж ахуй нэгж</p> <ol style="list-style-type: none"> 1. Тэсо ХК- Шилдэг татвар төлөгч өргөмжлөл, татварын албаны дээд шагнал “Хөх дэвтэр” 2. Смарт торх ХХК Шилдэг татвар төлөгч өргөмжлөл, татварын албаны дээд шагнал “Хөх дэвтэр” 3. Талх чихэр ХК Шилдэг татвар төлөгч өргөмжлөл, татварын албаны дээд шагнал “Хөх дэвтэр” 4. Дэлгэр улаан булаг ХХК Шилдэг татвар төлөгч өргөмжлөл, татварын албаны дээд шагнал “Хөх дэвтэр” 5. Илч хангай ХХК Шилдэг татвар төлөгч өргөмжлөл, татварын албаны дээд шагнал “Хөх дэвтэр” шагналаар шагнагдав. <p>Шилдэг иргэн</p> <ol style="list-style-type: none"> 1. Ж.Баттулга - 27 -р хорооны иргэн 2. О.Дамжин - 24-р хорооны иргэн <p>Мөн 32 хорооны самбар, үзүүлэнг шинэчлэн, татвар төлөгч аж ахуйн нэгж болон төсөвт байгууллага иргэдэд цахим тайлангийн системийн сургалт зохион байгуулж ажиллалаа.</p>	
41		Татварын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, татварт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авна.	Татвар төлөгчдийн өдрүүдийг “Татвар төлөгч танд баярлалаа” уриан дор зохион байгуулан шилдэг татвар төлөгчдөө шагнаж урамшуулан, шилдэг татвар төлөгчдийн дунд сагсан бөмбөг, гарбөмбөг, боулингийн тэмцээн зохион байгуулан, ирээдүйн татвар төлөгчдийн дунд гар зураг, зохион бичлэгийн уралдаан зохион байгуулж, 32 хорооны самбарыг шинэчлэн гаргаж, оюутан залуусын дунд илтгэх урлаг, АСТ тэмцээн зохион байгуулан, төрийн болон төсөвт байгууллага, татвар төлөгч аж ахуйн нэгж, иргэдэд цахим тайлангийн системийн талаар сургалт зохион байгууллаа. Нийт 29 удаагийн сургалт сурталчилгаа зохион байгуулж утсаар болон бичгээр 17401 иргэн, аж ахуйн нэгжид сурталчилгаа хийж, 18 602 иргэн, аж ахуйн нэгжид зөвлөгөө өгсөн байна.	90.0
42	1.2.4. Аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан тушаалт, тендерийн сонгон шалгаруулалт, үр дүн зэрэгт хүний	Байгууллага, аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан гаргах, мэдээлэх ажлыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ.	Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулан ажилласан. Дүүргийн хэмжээнд нийт 10827 аж ахуйн нэгж, байгууллага тайлан тушаахаас 8013 байгууллага тайлангаа цаасаар болон цахимаар тушаасан нь нийт тайлан өгвөл зохих аж ахуйн нэгжийн 78.8 хувь байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр	90.0

	оролцоог багасгаж, 100 хувь цахим тогтолцоог нэвтрүүлнэ.		557 аж ахуйн нэгж 53 иргэнийг шинээр бүртгэн, тоон гарын үсгийг шинээр 2046 аж ахуйн нэгж байгууллагад олгосон. Санхүүгийн тайлан хугацаа хоцроож тушаасан шалтгаанаар эхний 10-р сарын байдлаар нийт 305 байгууллагаар 29760,0 мянган төгрөгийн торгууль төлүүлсэн байна.	
43		Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, цахим худалдан авалтын хэмжээг нийслэлийн дундаж түвшинд хүргэнэ.	Цахим худалдан авалтыг дүүрэгт хэрэгжүүлэхээр Засгийн газрын Худалдан авах ажиллагааны агентлагт цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх олгох хүсэлт явуулсны үндсэн дээр эрх нээлгүүлсэн. Мөн албаны мэргэжилтэн, албан хаагчдыг цахим худалдан авалтын сургалтанд хамруулах хүсэлт гарган ажилласан боловч цахим худалдан авалтын мэдээллийн сан, нэгдсэн сүлжээг системийн хэмжээнд шинэчилж байгаатай холбогдуулан сургалт зохион байгуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. Худалдан авах ажиллагааны албаны дотоод сүлжээний хурд, тоног төхөөрөмжийн хүчин чадал цахим худалдан авалтаар тендер сонгон шалгаруулалт хэрэгжүүлэх шаардлагад нийцэхгүй, мөн дүүрэгт холбогдох байгууллагуудаас тендер зохион байгуулахтай холбогдсон мэдээлэл авах нэгдсэн мэдээллийн сан байхгүй тул цахим худалдан авалтыг зохион байгуулах боломж бүрдээгүй байна. Тендер шалгаруулалтын урилга, явц болон үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны газрын www.e-procurement.mn , дүүргийн www.shd.mn сайтуудаар нээлттэй мэдээлэн цахимаар зарлах, тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70.0
44		Зориулалтын өрөө тасалгаа, техник хэрэгсэлээр хангаж үнэлгээний хороодын хуралдааныг ил тод, нээлттэй явуулах нөхцлийг бүрдүүлнэ.	Үнэлгээний хороодын хуралдааныг ил тод, нээлттэй явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Тамгын газрын байрны өргөтгөлийн 3-р давхрын 30 м2 талбай бүхий өрөөг 9.6 сая төгрөгөөр “Агаар салхивч” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тохижуулав.	100.0
45	1.2.5. Орон нутгийг хөгжүүлэх сангийн орлогыг нэмэгдүүлэх менежментийг боловсронгуй болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжинэ	Иргэдийн дунд “Нээлттэй төсөв-2015” хэлэлцүүлэг зохион байгуулна.	Нийслэлийн нийгэм эдийн засгийн 2015 оны зорилт, төсөв, улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын саналыг Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс албад, ЕБС, цэцэрлэгүүдээс авч нэгтгэн Засаг даргын 1/1020, 1/1026 тоот албан бичгээр нийслэлийн ЗДТГ-т хүргүүлсэн болно.	100.0
46		Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хийх хөрөнгө	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны хөрөнгөөр хийгдэх ажлын талаар иргэдээс авах санал асуулгыг зохион	100.0

		<p>оруулалтын ажилд иргэдийн саналыг авч, орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан нэгдсэн жагсаалт боловсруулна.</p>	<p>байгуулахтай холбогдуулан Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 244, 43 дугаар тушаалыг хороодын Засаг дарга нарт танилцуулан сургалт, семинарыг зохион байгуулж, гарын авлага, зааварчилгааг цахим хуудсанд байрлуулсан. Иргэдээс авах асуулгын маягтыг хороо тус бүрээр 2013, 2014 онд хийгдсэн болон хийгдэх гэж буй ажлын талаарх мэдээллийг багтаан боловсруулж, 71.8 мянган ширхэг хэвлүүлэн хороодын өрх, хүн амын тоонд харьцуулан тарааж асуулгыг зохион байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжих төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлоготой уялдуулан иргэдээс ирүүлсэн саналыг үндэслэн төлөвлөх үүрэг бүхий ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын А/172 дугаар захирамжаар байгуулан ажиллаж нийт 6030.0 сая төгрөгийн төсөв бүхий 120 ажлын урьдчилсан жагсаалтыг дүүргийн Засаг даргын А/333 дугаар захирамжаар баталсан. Уг жагсаалтыг Төсвийн төсөл боловсруулах журмын дагуу дүүргийн Засаг даргын 1/2789 дүгээр албан тоотоор нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нэгдсэн жагсаалтад орсон ажлуудын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан зураг, төсвийн зөвлөх үйлчилгээний тендер зарласан. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хийгдэх ажлын зураг төсвийн үнэ 360.0 сая төгрөгийг нийслэлийн 2014 оны төсвийн тодотголоор батлуулсан болно.</p>	
47		<p>20.0 саяас доош төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын ажилд иргэдийн бүлгийг оролцуулах чиглэл баримтлана.</p>	<p>Нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2014 онд хийгдэх 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, хамтран ажиллах гэрээний загвар, бүртгүүлэх хүсэлтийн маягтыг хороодын Засаг дарга, 117 иргэнд өгч сурталчилсан ба тайлант хугацаанд материалаа бүрдүүлэн хүсэлтээ гаргасан 93 иргэдийн бүлгийг жагсаалтад бүртгэж, дүүргийн цахим хуудсанд байршуулсан. Худалдан авах ажиллагааны албатай хамтран 50 иргэдийн бүлгийн төлөөллийг хамруулан сургалт, ярилцлагыг 5-р сарын 8-ны өдөр Иргэний танхимд зохион байгуулав. Нийслэл, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих 19 ажилд тендер зарлахад давхардсан тоогоор 120 бүлэг тендерийн</p>	100.0

			баримт бичиг авснаас 61 нь тендер ирүүлэн 16 нь шалгарч нийт 346.1 сая төгрөгийн ажлыг 329.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажлаа дуусгаад байна. Дээрх ажлын хүрээнд 111 хүнийг түр ажлын байраар хангасан.	
48		Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг иргэд олон нийтэд мэдээлнэ.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 4922,7 сая төгрөгийн хөрөнгөөр 116 багц ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 3888,4 сая төгрөгийн 76 ажлын гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулснаас 12-р сарын 1-ний байдлаар 100%-тай 42, 90%-тай 4, 80%-тай 4, 70%-тай 9, 60%-тай 3, 50%-тай 5, 30%-тай 4, 10%-тай 5 ажил байна. Үүнээс 51 ажилд 2015,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын явцад хяналт тавих, хүлээж авах журмын төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны А/84 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг журмын дагуу дүүргийн Засаг даргын 2014 оны А/272 дугаар захирамжаар дээрх ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээж авах комиссуудыг байгуулан мэргэжлийн инженерүүдтэй гэрээ байгуулж хөрөнгө оруулалтын ажилд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Хяналт тавих явцад 88 зөрчил /ажлын тоо хэмжээ зөрүүлсэн, техникийн нөхцөл зөрчсөн г.м/ илрүүлэн хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцон ажилласан. Мөн тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын ажлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг тухайд нь шинэчлэн www.shd.mn цахим хуудсанд байрлуулан олон нийтэд нээлттэй сурталчилсан.	90.0

49	1.2.6. Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн болон газрын гэсэн ангиллаар явуулж, нийслэлийн өмчийн харилцааны газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулна.	Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын үр дүнг баталгаажуулж, бүртгэлгүй болон хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг цаг тухайд нь бүртгэлжүүлнэ.	Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны Б/210 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2014 оны жилийн эцсийн тооллогыг хийн, дүнг боловсруулах, нэгтгэх ажлуудыг хийж дуусгахаар ажиллаж байна. 2013 онд хийгдсэн тооллогоор 24-р хороонд олон улсын тусламжаар баригдаад 3 жил болсон халуун усны барилга бүртгэлгүй байсныг илрүүлэн дүүргийн ЗДТГ-ын комисс актаар хүлээн авсан байна. Тус халуун усыг анх ашиглалтад оруулахдаа зургийг нь өөрчилж барьсанаас улсын комисс хүлээн аваагүй бөгөөд дахин үнэлгээ хийлгэж бүртгэлд авахаар ажиллаж байна. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд өмчийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой 5 журмын төслийг өргөн барьж батлуулсан. Тус журмууд хэрэгжсэнээр шинээр бий болсон хөрөнгийг цаг алдалгүй тухай бүрт нь бүртгэлжүүлж эзэнжүүлэхэд ахиц гарах юм.	90.0
Хоёр. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ. 2.1 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлыг бууруулах талаар				
50	2.1.1. Хороодын хөдөлмөрийн цахим биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.	Хороо бүрт ажиллах цахим биржийн талаар сурталчилж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Дүүргийн хэмжээнд 32 хорооноос 28 хороонд, дүүргийн нэг цэгийн үйлчилгээ, ЗДТГ-ын байр, татварын хэлтсийн байр, Хөдөлмөрийн хэлтсийн байранд тус тус киоск машинууд байрлуулан хэвийн үйл ажиллагаатай ажиллаж байна. Цахим машины үйл ажиллагааг ханган, гэмтэл гарсан тухай бүрт засаж, программыг шинэчлэн, хөдөлмөрийн зах зээлийн талаарх шинэчилсэн мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж байна. Киоск машины үйл ажиллагааг тогтмолжуулахын тулд хороо тус бүрийн ажилтанд зааварчилгаа өгч, байнгын асаалттай байлган иргэдэд мэдээлэл авахад туслалцаа үзүүлэх зорилгоор Е-бирж ажиллуулах дэлгэрэнгүй зааврыг машин тус бүрт байрлуулсан. 2014 онд нийт 8602 иргэн киоск машинаас хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр тавигдсан мэдээ мэдээлэл авч үйлчлүүлсэн байна.	100.0
51		Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх “Хөдөлгөөнт бирж” ажиллуулна.	Хөдөлгөөнт биржийг хороо бүрт хуваарийн дагуу Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүд, хороодын Засаг дарга нар, нийгмийн ажилтан, зохион байгуулагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулан ажилласан. Биржийн үйл ажиллагаанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудаас	100.0

			хамруулан оролцуулж иргэдэд сул чөлөөтэй байгаа ажлын байрны талаар зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажилласан. Хөдөлгөөнт биржээр иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн талаархи мэдээ мэдээлэл, сул чөлөөтэй ажлын байрны захиалга, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрүүд, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг сурталчилан, ажилд зуучлах үйлчилгээг тухай бүрт хүргэж ажилласан. Хөдөлгөөнт биржийг 2014 онд 32 хороонд нийт 53 удаа ажиллуулан 3200 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж 152 иргэнийг ажилд зуучлан оруулж байнгын болон түр ажлын байраар хангасан.	
52	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	Абука ХХК-ий Барилгын технологийн коллежтой хамтран ажиллах санамж бичэг байгуулж 6-р сард тус байгууллагын харьяа Барилгын технологийн коллежийн салбар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг 4-р хороонд байгуулан үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Сургалтын төв нь барилгын болон, нийтийн хоол хүнс, ахуйн үйлчилгээ гэсэн төрөл бүрийн чиглэлээр мэргэжлийн сургалтууд явуулж байна. БНСУ-ын хөрөнгө оруулалттай Самдун интернейшнел төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хамтран ажиллах гэрээний дагуу тус төрийн бус байгууллага нь 2-р хороонд Барилгын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулсан ба тус төв нь дүүргийн амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 181 иргэнийг барилгын засал чимэглэлчин, гагнуурчны мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулж мэргэжил эзэмшүүлсэн. Дээрх мэргэжил эзэмшиж төгссөн иргэдээс судалгаа авахад 100 иргэн эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажил хөдөлмөр эрхэлж байна.	100.0	
53	Халамж, асрамжийн төвүүдэд хүмүүжсэн залуучуудыг хөдөлмөрт бэлтгэн, мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулна.	Нийгмийн халамж, дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхүүдийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдэд чиглэсэн “Хөдөлмөрт бэлтгэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд ажилгүй, ажил идэвхитэй хайж байгаа, насанд хүрээд асрамжийн газраас гарсан хөдөлмөрийн насны иргэд болон хорих ангиас суллагдсан ажилгүй иргэдийн судалгаа гарган бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Судалгаагаар хорихоос суллагдсан болон насанд хүрээд асрамжийн төвөөс	100.0	

			гарсан нийт 200 гаруй иргэн бүртгэгдсэн. Тус зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн дагуу гарсан хөтөлбөрүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, сургалт явууллаа. Бүртгэгдсэн иргэдээс 130 иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох болон, хөдөлмөрийн харилцааны анхан шатны зөвлөгөө, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалтад хамруулсан. 2014 оны 4 дүгээр сард хорихоос суллагдсан 60 иргэнийг хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбоотой хууль тогтоомжийн талаархи сургалтад хамруулав.	
54		Гадаадад ажиллаж байгаад буцаж ирсэн иргэдийг мэргэжлийн давтан сургалтанд хамруулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийн талаарх санал санаачлагыг дэмжинэ	Ажилд зуучлагдан орохоор хүсэлт гаргаж бүртгүүлсэн 3400 иргэнээс судалгаагаар гадаадад ажиллаж байгаад ирсэн 113 иргэн байна. Тэдгээр иргэдийн эзэмшсэн мэргэжил, эрхэлж байсан ажлын туршлагын талаархи дэлгэрэнгүй судалгааг авч, мэргэжлийн бэлтгэгдсэн ажилтан шаардлагатай байгаа аж ахуй нэгжүүдэд мэдээллийг хүргүүлж ажилд зуучлан оруулж байна. Судалгаанд хамрагдсан нийт 113 иргэнийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулан, мэргэжил эзэмшүүлэх давтан сургалтуудад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгосон. 2014 оны жилийн эцсийн байдлаар судалгаанд хамрагдсан, гадаадад ажиллаж байсан ажлын туршлагатай, мэргэшсэн 19 иргэнийг мэргэшсэн ажилтан шаардлагатай байгаа аж ахуй нэгжүүдэд ажилд зуучлан оруулсан.	100.0
55	2.1.2. Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэгцээний дарааллаар гарган ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжил олгох болон мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулан тэдгээрийн 60-аас доошгүй хувийг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүлгийн зохион байгуулалтанд оруулан ажлын байр бий болгох, зээл тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.	Хөтөлбөрийн сургалтын арга хэмжээний хүрээнд мэргэжил олгох сургалтын байгууллагуудад нийт 34 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулж, 31 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангав. Тус Хөтөлбөрийн хүрээнд аж ахуй эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгуулсан бүлгүүдийн санаачилсан төслүүдийг сонгон шалгаруулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажил зохион байгуулсан. Төсөл сонгон шалгаруулалтын зарыг 04-р сарын 01-15-ны хооронд хороодоор дамжуулан иргэдэд хүргэж, 140 бүлгийн төслийг хүлээн авсан. Төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэг 04-р сарын 29-нд дэмжлэг хүссэн нийт 140 төсөлтэй танилцаж, аж ахуй эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 94	100.0

	байнгын ажлын байраар хангана.		бүлгийн шаардлага хангасан төсөлд нийт 105.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Санхүүгийн дэмжлэг авсан бүлгүүдийн хэрэгжүүлж байгаа төслүүдийн үр дүнд 110 хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр шинээр бий болсон.	
56		Ахмад настны болон, нийгмийн эмзэг бүлгийн иргэд, өрх толгойлсон эхчүүдийг амьдрах орчноо сайжруулах, нөхөн сэргээх, ногоон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэн, түр ажлын байраар хангана.	Ахмад настан ба 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 100 ахмад настанг бүртгэж бүлгийн зохион байгуулалтанд оруулан, төмс, хүнсний ногоо тариалах сургалтад хамруулсан. Бүртгэгдсэн иргэдийг Монголын Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд Хөдөлмөр эрхлэлт үйлчилгээний төвөөс зохион байгуулсан 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн арга хэмжээнд оролцуулсан. Бүртгүүлсэн 100 иргэнийг тус бүр 20 хүнтэй 5 бүлэг болгон ногоон ажлын байранд хамруулсан. Бүлэг тус бүрт чиглэсэн уулзалт сургалтыг зохион байгуулсан. Ахмад настан ба 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүлгүүдийн төслийг хүлээн авч сонгон шалгаруулсан. Нийт 50 төслийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 50 бүлгийн 150 ахмад мэргэжилтэн иргэдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллав. Сонгон шалгаруулалтаар шалгарсан ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний сургалт зөвлөгөөнүүдэд нийт 1428 иргэн хамрагдсан. Тус зөвлөх үйлчилгээний санхүүжилтэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 50.0 сая төгрөг зарцуулагдсан. Нийт 2317 ажилгүй иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласнаас 1458 иргэн нийтийг хамарсан ажилд, 859 иргэн ногоон ажлын байраар хангагдсан байна. Дээрх нийт ажилгүй иргэдийн 1359 иргэн нь өрх толгойлсон эмэгтэй байна. “Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн бүлгүүдээс нийт 79 төсөл ирүүлснээс хамтран ажиллах гэрээ байгуулсан 71 төсөл байгаагаас 22 нь ногоон ажлын байр нэмэгдүүлэх, 47 нь нийтийг хамарсан ажлын төсөл, дэд бүтэц тохижилтын 2 төсөл байна.	100.0
57	2.1.3. Дүүргийн нутаг дэвсгэрт ажлын байр шинээр бий болгох	Ажил, мэргэжилгүй иргэдийг аж ахуй нэгж байгууллагын хэрэгцээнд тулгуурлан ажлын байран дах	Ажлын байран дээрх сургалтад 54 иргэн хамрагдсанаас жилийн эцсийн байдлаар 54 иргэн тухайн байгууллагадаа байнгын ажлын байраар хангагдан ажиллаж байна. Ажлын байран дах	100.0

	асуудлыг шаттайгаар хэрэгжүүлнэ.	үе	сургалтанд хамруулан, ажлын байраар хангана.	сургалтыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Цахилгаан тээвэр, Хасу цамхаг ххк, Тайгам алтай ххк, Женерал алтай ХХК зэрэг аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулан явуулж байна. Дүүргийн хэмжээнд 577 ажил олгогч байгууллагаас авсан 2195 сул чөлөөтэй ажлын байр бүртгэгдсэн. Дээрх ажлын байрны захиалгын дагуу ажилгүй иргэдийг бүртгэлжүүлж, нийт 1421 иргэнийг шинээр хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 2013-2014 онд ажилд орохоор бүртгэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй нийт иргэдээс жилийн эцсийн байдлаар 1801 иргэнийг ажилд зуучлан оруулсан. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдийн хэрэгцээнд тулгуурлан ажлын байр бий болгоход зориулж аж ахуйн болон бизнес хөгжүүлэх сургалт, жижиг зээлийн төсөл боловсруулах сургалтуудыг явуулж нийт 285 иргэн суралцаж төгссөн. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 242 төсөл хүлээн авч төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр 61 төслийг сонгон шалгаруулж 90.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Тус санхүүгийн дэмжлэгээр 90 ажлын байр шинээр бий болсон.	
58	2.1.4. Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрах хөгжүүлэх төвийг 21-р хороо Жаргалант тосгоны Сүүж амралтын дэргэд байгуулахаар дүүргийн Засаг даргын захирамжаар газар олгосон. Нийслэлийн дүүргүүдэд баригдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрах хөгжүүлэх төвийн нэг ижил загварын барилгын зураг төсвийг нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалан хийлгэсэн. 789,0 сая төгрөгийн төсөв батлагдаад байна.	30.0
59			Хороодын амьжиргааг дэмжих зөвлөлийн ажлыг ил тод нээлттэй болгож, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Нийт 32 хороонд 224 гишүүнтэй 32 амьжиргааг дэмжих зөвлөл ажиллаж байна. АДЗ-ийн гишүүдэд Нийгмийн халамжийн тухай хуулийн талаар 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Жил бүрийн 10-р сард зөвлөлийн гишүүдийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, туршлага солилцуулан шилдэг амьжиргааг дэмжих зөвлөлийг шалгаруулан урамшуулж хэвшүүлээд байна. Хороодод Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны талаарх тусгайлсан самбар байршуулан тус зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэлийг ил тод	100.0

			<p>тавьж хэвшүүлсэн. Зөвлөл нь сардаа 2 удаа тогтмол хуралдаж иргэдийн гаргасан хүсэлтийг хуулийн дагуу бүрэн шийдвэрлэж байна. Зөвлөлийн гишүүд хуваарь гарган хүсэлт гаргасан айл өрхүүдтэй биечлэн танилцаж иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонсдог болсон. Жилийн эцсийн байдлаар 32 хорооны амьжиргааг дэмжих зөвлөлүүд нийт 450 удаа хуралдаж, иргэдээс 4689 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, хурлаараа хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Зөвлөлийн хурлын шийдвэрээр Нийгмийн халамжийн үйлчилгээнд 3493 өрх, иргэнийг хамруулсан байна. Асаргааны тэтгэмжийг 861 хүнд, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 826 хүнд, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийг 268 өрх, иргэнд шинээр тогтоож, байнгын асаргааны болон улирлын мөнгөн тэтгэмжийн сунгалтыг 1986 иргэнд хийж өгсөн байна. Мөн хүнсний эрхийн бичигт хамрагдах 940 өрхийн нэрсийг хэлэлцүүлж батлуулсан.</p>	
60		<p>Нийгмийн халамжийн үйлчилгээнд хувийн хэвшил төрийн бус байгууллагын оролцоо түншлэлийг нэмэгдүүлж, гэрээгээр гүйцэтгүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулна.</p>	<p>Иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхээр Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас зарласан тендерт оролцож халамжийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан сэргээн засах, өдрийн үйлчилгээ үзүүлэх 9, түр байрлуулан асрамжлах үйлчилгээ үзүүлдэг 1, сургалтын 1, тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх, түр хоноглох үйлчилгээ үзүүлдэг 2, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг 1, тэнэмэл иргэдэд халуун хоол цайгаар үйлчлэх үйлчилгээг үзүүлдэг 4, нийт 18 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага ажиллаж байна. Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх гэрээ байгуулсан 16 дэлгүүрт нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн хяналтын мэргэжилтэн, хүнс тэжээлийн дэмжлэг тусалцаа хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран хяналт шалгалт хийсэн. Сэргээн засах үйлчилгээг үзүүлж байгаа 10 байгууллагад 3, 7, 10-р саруудад нийгмийн халамжийн хэлтсээс гаргасан удирдамжийн дагуу явцын хяналт шалгалт явуулсан. Мөн хороо хариуцсан халамжийн мэргэжилтнүүдээр сард 2-3 удаа тухайн байгууллагуудад хяналт тавиулан ажиллуулж байна. Иргэдээс үйлчилгээний талаархи чанар хүртээмжийн талаар судалгаа авахад нийт 346 иргэн хамрагдаж, судалгаагаар үйлчилгээнд сэтгэл хангалуун, үр дүн сайн гэж дүгнэгдсэн. Дээрхи байгууллагуудаас сар бүр үйл ажиллагааны тайланг авч, хяналт</p>	100.0

			<p>үнэлгээ хийж, зөвлөмжүүдийг тухай бүрт нь өгч ажилласан. 2014 оны жилийн эцсийн байдлаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болох, сэргээн засах өдрийн үйлчилгээ, гэрийн асрамж халамжийн үйлчилгээнүүдэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өрх толгойлсон эх болон зорилтот бүлгийн иргэд зэрэг нийт 5300 иргэнийг хамруулсан. Тус үйлчилгээнд 965,8 сая төгрөг халамжийн сангаас зарцуулагдсан. Орон гэргүй, тэнэмэл, архины хамааралтай 60 иргэнийг түр хоноглуулах байранд байлгаж хооллож ундлан, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээнд хамруулж, хувцас тараан нийгэмшүүлэх үйлчилгээнд хамруулсан. Тус үйлчилгээнд халамжийн сангаас 56,7 сая төгрөг зарцуулсан. “Халуун хоол” хөтөлбөрийг халамжийн сангаас 197,1 сая төгрөгийг зарцуулан хэрэгжүүлсэн. Жилийн эцсийн байдлаар нийт 480 тэнэмэл иргэдийг суурин болон явуулын цэгээр хооллосон. Мөн гэрийн асрамж халамжийн үйлчилгээг “Гэгээлэг буянтай үйлс” төрийн бус байгууллага гэрээлэн үзүүлдэг бөгөөд энэ оны жилийн эцсийн байдлаар 215 байнгын асаргаа шаардлагатай иргэн хамрагдсан.</p>	
61		<p>Нийгмийн халамжийн үйлчилгээг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгүүдэд чиглүүлэн, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран бага орлоготой 700–аас доошгүй өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.</p>	<p>Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран 2014-2016 онд хэрэгжүүлж буй иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх Төгсөлтийн аргачлал төсөлд амьжиргааны түвшнээс доогуур орлоготой Толгойт, Баянхошуу бүсийн 16 хорооны 700 өрхийг сонгож хамруулсан. Соёмбо кино театрт төсөлд хамрагдахаар сонгон шалгарсан 700 өрхийн төлөөлөл 350 өрхийг оролцуулан төслийн нээлтийн арга хэмжээ, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сонгогдсон өрхүүдтэй ажиллахын тулд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэд, ажилгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрүүл мэндийн даатгалгүй иргэд, хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан иргэд, өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 1-10-р түвшний өрхүүд, 11-20-р түвшний өрхүүдийн судалгааг гаргаж өрх тус бүрт чиглэсэн өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан төслийн 2-р шатны ажлыг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийг хэрэгжүүлэхээр дүүргийн Засаг даргын захирамжаар дүүрэг, хороодод ажлын хэсэг тус тус байгуулагдан ажиллаж байна. 2014 оны 9-р сард сонгогдсон өрхүүдээс өрхийн хэрэгцээний нарийвчилсан судалгааг гаргасан.</p>	100.0

			<p>2014 оны жилийн эцсийн байдлаар төсөлд хамрагдаж байгаа иргэдээс 19 иргэн ажилд зуучлагдан орж, 35 иргэн мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдаад байна. Бизнесийн хөгжлийн талаар 222 өрх, эрүүл мэндийн чиглэлээр 173 өрх, хүнс ногоо тариалах чиглэлээр 68 өрхийг тус тус сургалтанд хамруулсан. Мөн таваас доош насны 45 хүүхдийг хоол тэжээлийн дутагдал нөхөх Гал голомт хөтөлбөрт хамруулж, 45 өрхөд нэг удааг нэг бүр нь 180.0 мянган төгрөгийн өртөгтэй хүнсний тусламж үзүүлээд байна. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш орон гэргүй 7 өрхөд гэр, 18 өрхөд жилийн хэрэгцээний нүүрс олгосон. Төрийн болон хувийн 25 цэцэрлэгт 46 хүүхдийг шинээр оруулсан. Нийгмийн халамжийн тухай хуулийн 68 төрлийн зүйл, заалтад тусгагдсан халамжийн үйлчилгээнд төсөлд хамрагдсан 700 өрхийн 3500 гаруй иргэдээс шаардлага хангасан 1100 иргэн нийгмийн халамжийн үйлчилгээ авч хамрагдаад байна.</p>	
62	<p>2.1.5. Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн ажилтнуудын ажлын арга барилыг шинэчлэж, нийгмийн халамж шаардлагатай өрх иргэдэд хүрч үйлчилнэ.</p>	<p>Нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах зорилтын хүрээнд 2013 оны 10-р сараас орон даяар өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг явуулж, энэ оны 4-р сард мэдээллийн сан бүрдүүлэх ажил дууссан. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд хамрагдаж байгаа өрх, иргэдэд чиглэсэн “Хаалга тогшоё” аяныг зохион байгуулж, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн бодит нөхцөл байдлыг газар дээр нь судлан, төрөөс авч байгаа халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж, нийгмийн халамжийн үйлчилгээ шаардлагатай иргэндээ хүрч байгаа эсэхэд судалгаа, шинжилгээ хийж ажилласан. Соёмбо кино театрын гадна талбайд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж Нийгмийн даатгал, халамж үйлчилгээний хэлтсийн ажлыг иргэдэд сурталчлан, даатгалын болон халамжийн үйлчилгээг үзүүлсэн. Хүүхэд гэр бүл хөгжлийн төвөөс иргэдэд Гэр бүлийн хуулийн дагуу зөвөлгөө, мэдээлэл хүргэж төвийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан. 5-р сард “Гэр бүлийн хөгжлийг дэмжье”, 6-р сард “Алслагдсан хороодын иргэддээ очиж үйлчилье” аяныг тус тус зохион байгуулж 21, 32-р хорооны иргэдэд халамжийн үйлчилгээг үзүүлсэн. Нээлттэй хаалганы өдөрлөг нэгдсэн арга хэмжээнүүдээр Нийгмийн</p>	100.0

			халамжийн хууль, тогтоомжийг нийт 196,000 орчим иргэнд сурталчлан, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн хэмжээнд энэ онд нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 63172 хүн хамрагдаж 28,3 тэр бум төгрөг нийгмийн халамжийн сангаас болон улсын төсвөөс зарцуулагдсан.	
63		Нийгмийн халамжийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн иргэдийг хамруулна.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болох сэргээн засах өдрийн үйлчилгээ, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өрх толгойлсон эх болон зорилтот бүлгийн 5300 иргэнийг хамруулсан. Тус үйлчилгээнд 965,8 сая төгрөг халамжийн сангаас зарцуулсан. Орон гэргүй, тэнэмэл, архины хамааралтай 60 иргэнийг түр хоноглуулах байранд хооллон, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээнд хамруулав. Тус үйлчилгээнд халамжийн сангаас 56,7 сая төгрөг зарцуулсан. “Халуун хоол” хөтөлбөрийг халамжийн сангаас 197,1 сая төгрөгийг зарцуулан хэрэгжүүлсэн. Нийт 480 тэнэмэл иргэдийг суурин болон явуулын цэгээр хооллосон. “Гэгээлэг буянтай үйлс” төрийн бус байгууллагаас гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд 215 байнгын асаргаа шаардлагатай иргэн хамрагдсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч зохицуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлгийн ахлагч нарыг олон улсын сертификаттай чадавхижуулах 2 өдрийн сургалтанд хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн НҮБ-ийн конвенцийг 2014-2016 онд хэрэгжүүлэх дүүргийн нэгдсэн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна. Сэргээн засалт үндэсний төвөөс санаачлан зохион байгуулж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн аяныг 04-р сард зохион байгуулсан. Аян зохион байгуулахтай холбогдуулан Сэргээн засалт үндэсний төвтэй хамтарсан ажлын төлөвлөгөөг боловсруулан дүүргийн нутаг дэвсгэрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох хуулиудаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ХБИ-н холбоодод сургалт явуулсан.	100.0
64		Зорилтот бүлгийн өрх, иргэнийг нийгэмшүүлэн, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй	Адил хэрэгцээ, сонирхол, шаардлага бүхий 2 ба түүнээс дээш өрх, иргэдийг өөрсдийнх нь санаачлагаар бүлэг болгон өрхийн жижиг үйлдвэрлэл эрхлэж амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор төсөл	100.0

		болоход чиглүүлж, төсөл хөтөлбөрт хамруулна.	хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж /1 сая хүртэлх төгрөг/ олгох үйлчилгээг үзүүлдэг. 2014 онд шаардлага хангасан зорилтот 33 бүлгийн өрх, иргэдийн байгуулсан төслийг дэмжин гэрээ байгуулж нийгмийн халамжийн сангаас 31,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Санхүүжилт авсан төсөл хэрэгжүүлэгч бүлгүүдийн үйл ажиллагаа болон төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төсөлд хамрагдсан тухайн өрхийн амьжиргаанд хэр ахиц гарч буйг дүгнэж, санхүүжилт авсан бүлгүүдээс улирал бүр үйл ажиллагааны тайлан авч, бүлгийн үйл ажиллагааг газар дээр нь очиж үзэн хяналт тавьж ажилласан.	
65	2.1.6. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар ажил зохион байгуулж, тэтгэврийн даатгалыг нөхөн авах иргэдэд мэдээлэл өгч хамруулна.	Иргэдэд нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчлан, сайн дурын нийгмийн даатгалд хамрагдагсдын хүрээг өргөтгөнө.	4958 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулан нийт 16033 иргэнд сайн дурын даатгалын үйлчилгээг үзүүлж 3.1 тэрбум төгрөг хуримтлуулсан. Дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг томоохон худалдааны төвүүд болох Сутайн буянт, Хангай зах, Хархорин зах болон ажил олгогч байгууллагуудад сургалт сурталчилгааг улирал бүр хийж, Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар иргэдэд зөвлөгөө өгч, гарын авлага, тараах материал тараасан. 05-р сард Жаргалант тосгонд нийгмийн даатгалын хяналтын байцаагчид ажиллаж тус хорооны 120 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан, зөвлөгөө өгч ажилласан. 11-р сард Хаан банкны ажилчдад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалт явуулсан. “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж нийт 42086 иргэдээс материал хүлээн авч бүртгэсэн. 29471 иргэнд ажилласан жил нөхөн тооцох батламжийн хуудас олгосон. Хөнгөлөлттэй нөхцлөөр 1991-1994 онд тэтгэвэр тогтоолгосон иргэдийн ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд нийт 2030 хүн нөхөн даатгалд хамрагдсан.	100.0
66		Аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэдийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.	Эхний 11 сарын байдлаар нийгмийн даатгалын хэлтэст бүртгэлтэй 3546 ажил олгогч байгууллагын 51.818 даатгуулагчийн 153.2 тэрбум төгрөгийн цалингийн санг нийгмийн даатгалын мэдээллийн санд баталгаажуулан оруулсан. 325 аж ахуй нэгж байгууллагад шалгалт хийж 200.0 сая төгрөгийн шимтгэлийн	100.0

			<p>төлбөр, зөрчил илэрсэн. Илэрсэн төлбөр, зөрчилд 113.0 сая төгрөгийн алданги тооцож нийт 313.0 сая төгрөгийн төлбөр барагдуулж, аж ахуй нэгж байгууллагад ажилладаг нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэдийг нийгмийн даатгалд хамруулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 4 их, дээд сургуулийн 4693 оюутныг эрүүл мэндийн даатгалд хамруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцдаг 130,474 иргэдийн ногдуулалтыг хийж 374,6 сая төгрөгийн санхүүжилтийг санд бүрэн төвлөрүүлсэн. Татварын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн даатгалд хамрагддаггүй аж ахуй нэгж байгууллагуудын судалгааг гаргаж нийгмийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--

2.2 Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр

67	<p>2.2.1. Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгож, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж материаллаг баазыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэн, эрүүл мэндийн салбарын эмчилгээ оношлогооны багаж хэрэгслүүдийн судалгааг гарган шинэчлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэн “Архи тамхины хор уршиг”, “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”, “ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх нь”, “Гэр бүл төлөвлөлт”, “Эх хүүхдийн эрүүл мэнд”, “Жирэмслэлт, “Жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл”, “Стресс”, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Осол гэмтэл”, “Дэлгэцийн донтолт” зэрэг 40 гаруй сэдвүүдээр нийт 12.450 иргэнд сургалт, давхардсан тоогоор 32.600 гаруй хүнд сурталчилгаа явуулж эрүүл мэндийн боловсрол олгон ажиллаж байна. Үүнээс “Амны хөндийн эрүүл ахуй видео сургалт”, “Шүд угаах арга” сургалтанд 11.693 сурагчийг хамрууллаа. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 230 гаруй сайн дурын идэвхтнүүд ажиллаж иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг тогтмол зохион байгуулж хэвшээд байгаа бөгөөд сургалт зөвлөгөө өгөх өрөөнүүд тогтмол үйл ажиллагаа явуулж, мэдээллийн самбараар зөвлөгөө, мэдээлэл түгээн ажиллаж байна. 2014 оны байдлаар сурталчилгааны материал 44.782 ширхэгийг иргэдэд тарааж мэдээлэл түгээх ажлыг тогтмолжуулаад байна. Эрүүл мэндийн Яам болон нийслэлийн Эрүүл мэндийн газраас зарласан “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар”, нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний дөрөв дэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Жирэмслэлтээс сэргийлэх эм,</p>	100.0
----	---	---	---	-------

			<p>хэрэгслийн дэлхийн өдөр"-ийн үйл ажиллагаануудыг зохион байгуулж 3455 оюутан залуус, иргэд, ажилтан, албан хаагчдыг хамруулан ажиллаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэй “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Усны аюулгүй байдлын төлөвлөлт хийх” сургалтыг дүүргийн 10 хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн 40 ажилтанд зохион байгуулж 2015 оноос усны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Дүүргийн эрүүл мэндийн төвд 293.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн ба дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс амьсгалын аппарат шинэчлэхэд 2.9 сая, эхо аппарат авахад шаардагдах 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 22-р хорооны “Одонт манал” өрхийн эрүүл мэндийн төвд 13 төрлийн үзүүлэлт үзэх, 23-р хорооны “Гурван жаргал Хайрхан” өрхийн эрүүл мэндийн төвд 6 төрлийн үзүүлэлт үзэх лабораторийн тоног төхөөрөмжийг тус тус олгоод байна.</p>	
68		<p>БЗДХ, ДОХ/ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх талаар иргэд, өсвөр насныханд сургалт таниулга явуулна.</p>	<p>Засаг даргын 2014 оны А/258 дугаар захирамжаар “Залуучууд, хөдөлгөөнт болон өндөр эрсдэлт бүлгийн хүн амыг “БЗДХ/ДОХ-аас урьдчилан сэргийлэх нь” төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж давхардсан тоогоор 60 гаруй өндөр эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдэд 10, ААНБ, бар, рестораны 100 гаруй ажилтнуудад 2 удаагийн сургалт тус тус зохион байгуулаад байна. Сэтгэл Амар төв, Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгтэй хамтран эрсдэлт бүлгийн 20 гаруй эмэгтэйчүүдэд 2 удаа бүлгийн ярилцлагыг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Амьдрах ухаан сургалтын төвийн байнгын болон түр хоноглогч нарыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд тогтмол хамруулан ажиллаж байна. “БЗДХ/ХДХВ-ын тандалт судалгаа”-нд 152 эрсдэлт бүлгийн хүнийг хамрууллаа. 2014 онд БЗДХ/ДОХ/ХДХВ-ын диспансерын кабинетаар үйлчлүүлсэн иргэдийг насны байдлаар авч үзвэл 15 нас 0,5%, 15-24 насныхан 34,6%, 25-34 насныхан 51,4 %, 35-44 насныхан 11%, 45-аас дээш насныхан 2,5%-ийг эзэлж байна. Ерөнхий боловсролын 12-р сургуулийн 10, 11-р ангийн 250 сурагч, Монос, Ач, Мандах бүртгэл дээд сургуулийн 779 оюутанд БЗДХ/ХДХВ/ДОХ-ын сургалт зохион байгуулан ажиллалаа. Эхний</p>	100.0

			<p>11 сарын байдлаар давхардсан тоогоор 6000 гаруй хүүхэд, залуучуудад сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулаад байна. “100% бэлгэвч” хөтөлбөрийн хүрээнд “ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг ААНБ, бар, цэнгээний газар, зочид буудлын эзэд, ажилтнуудын дунд 2 удаа зохион байгуулж 200 гаруй хүнийг хамруулаад байна.</p>																					
69		<p>Дүүргийн нийт хүн амын дунд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Дүүргийн нийт хүн амын дунд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үндэсний хөтөлбөр”, 6 дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөн ажиллалаа. Хүн амын дунд гарч байгаа халдварт өвчний гаралтыг бууруулахад чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулснаар халдварт өвчний гаралт 2013 онд 2690 байсан бол 2014 онд 2088 тохиолдол бүртгэгдэж, 602 тохиолдлоор буюу өмнөх оноос 23 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Зарим халдварт өвчний буурсан үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:</p> <table border="1" data-bbox="999 784 1856 948"> <thead> <tr> <th>Халдварт өвчний төрлүүд</th> <th>2013 он</th> <th>2014 он</th> <th>Буурсан зөрүү</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Вируст гепатит</td> <td>295</td> <td>85</td> <td>210</td> </tr> <tr> <td>Салхин цэцэг</td> <td>374</td> <td>270</td> <td>104</td> </tr> <tr> <td>Гахайн хавдар</td> <td>236</td> <td>19</td> <td>217</td> </tr> <tr> <td>Тэмбүү</td> <td>558</td> <td>430</td> <td>128</td> </tr> </tbody> </table> <p>Дүүргийн хэмжээнд 8316 эмэгтэй жирэмсний хяналтад орж шинжилгээнд хамрагдсаны 225 буюу 2.7% нь тэмбүү өвчтэй гэж оношлогдон эмчилгээнд хамрагдаад байна. Сүрьеэ өвчний тархалтыг бууруулах, илрүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2014 оны А/257 дугаар захирамж гарган “Сүрьеэгийн тархалтын судалгаа”-ны ажлыг 9 хороонд зохион байгуулж нийт 4984 иргэнийг үзлэг, шинжилгээнд хамруулан өвчтэй илэрсэн 12 иргэнийг эмчилгээнд хамруулаад байна. “Сүрьеэтэй хүн бүрт хүрч үйлчилье” сэдэвт сургалтыг 32 хорооны Засаг дарга нарт, “Сүрьеэ өвчин хүүхдийн хувьд” сэдэвт сургалтыг сургууль, цэцэрлэгийн 60 гаруй эмч нарын дунд явуулав.</p> <p><u>Голомтын арга хэмжээ:</u> Нийт 131 халдварт өвчний голомтод үзлэг тандалт зохион байгуулан 238 иргэнийг хамруулж, 3400м² талбайд ариутгал, халдваргүйтгэл хийлээ.</p>	Халдварт өвчний төрлүүд	2013 он	2014 он	Буурсан зөрүү	Вируст гепатит	295	85	210	Салхин цэцэг	374	270	104	Гахайн хавдар	236	19	217	Тэмбүү	558	430	128	100.0
Халдварт өвчний төрлүүд	2013 он	2014 он	Буурсан зөрүү																					
Вируст гепатит	295	85	210																					
Салхин цэцэг	374	270	104																					
Гахайн хавдар	236	19	217																					
Тэмбүү	558	430	128																					

		<p>Халдварт шар өвчний шаргүй далд хэлбэрийг илрүүлэх үзлэгт 26.892 иргэнийг, назофарингитийг илрүүлэх үзлэгт 36.482 хүнийг тус тус хамруулаад байна.</p> <p><u>Сургалт сурталчилгаа:</u> Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг 2176 хүнд явуулж, 3500 гарын авлага, материалыг олон нийтэд түгээн ажиллалаа.</p> <p>2013 оны 10 сараас томуу, томуу төст өвчний гаралт ихэссэнтэй холбогдуулан тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон гэрээр эмчлэх, цэгэн эмчилгээний санамж 1500 ширхэг, өрхийн эрүүл мэндийн төв, амбулаторуудаар үйлчлүүлж байгаа 31101 иргэнд болон сургууль цэцэрлэгийн 12.000 хүүхдүүдэд “Халдварт шар өвчнөөс сэргийлье”, “Халдварт шар өвчний халдвараас хэрхэн сэргийлэх вэ?”, “Гар бол нян хадгалагч, халдварт өвчнийг дамжуулагч мөн”, “Гараа зөв угаах арга техник”, “Хэдийд ямар үед гараа угаах ёстой вэ” гэх мэт сэдвүүдээр сургалт, сурталчилгаа явуулж 33.356 ширхэг гарын авлага, зөвлөмж хүргээд байна. Дархлаажуулалтын ач холбогдлыг иргэдэд ойлгуулах зөв мэдээллээр хангах зорилгоор Like телевизийн эрүүл мэндийн хөтөлбөр, “Энх мэнд” нэвтрүүлэгтэй тогтмол хамтран ажиллаж байна. МҮОНТелевиз, ХӨСҮТөвтэй хамтран дархлаажуулалтын кабинетын үйл ажиллагаа, вакцин тарих арга техник, бүртгэл мэдээлэл, вакцины өмнөх хүүхдийн үзлэгийн талаарх мэдээллийг “Дархлаажуулалтын тухай үнэн” сэдэвт баримтад киног бүтээж олон нийтэд үзүүлэн сурталчлаад байна.</p>	
70	Эрүүл мэндийн нэгдлийн барилгын чанар байдлыг сайжруулах, засварлах талаар судалгаа хийж холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Эрүүл мэндийн төвийн мэдээлэл технологийн алба, хурлын зааланд их засвар, яаралтай тусламжийн тасгийн өргөтгөл, хүлээн авах тасгийн үүдний хэсгийг тохижуулах барилга засварын ажил, өвөлжилтийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд өрөөнүүдийн урсгал засваруудыг хийж дуусган 5.9 сая төгрөгийг зарцуулж ашиглалтад оруулаад байна. Байгууллагын гадна талбайг засаж тэгшлэн автомашины зогсоолын зориулалтаар тохижуулаад байна.	90.0
71	Хороодын чийрэгжүүлэлтийн танхимыг тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.	4, 11, 12, 15, 16, 18, 22, 31-р хороодын чийрэгжүүлэлтийн танхимд 115.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олголоо.	100.0

72	2.2.2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах”, “Эрүүл хүн-эрүүл дүүрэг” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	<p>Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны А/62 дугаар тогтоолоор “Эрүүл хүн”, “Эрүүл орчин-Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:</p> <p>“Эрүүл хүн” дэд хөтөлбөрийн 1-р зорилт “Хүүхэд багачуудыг өвчнөөс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгийн 4269 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс амьсгалын замын өвчтэй 461, зүрх судасны өвчтэй 37, чих хамар хоолойн өвчлөлтэй 194, арьс харшлын өвчтэй 237, мэдрэлийн өвчлөлтэй 52 хүүхэд илэрснийг эрүүлжүүлэх арга хэмжээнд хамруулан ажиллаж байна. БНСУ-ын Сөүл хотын Эрүүл мэндийн төв, Чү-Ян ОУ-ын шүдний эмч нартай хамтран 7-р сарын 21-25 өдрүүдэд 895 хүнд үзлэг эмчилгээг хийлээ. Тархины саа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засах кабинет байгуулах ажлын хүрээнд мэдрэлийн зөвлөх эмчийг орон тоогоор ажиллуулж, төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, сурталчилгааны ажлуудыг үе шаттай, хуваарийн дагуу хийж, үр дүнг тооцон, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар анхааран ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Засаг даргын А/310 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилон “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх, иргэн шалгаруулах” ажлыг зохион байгуулснаар “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-аар 106, 156-р цэцэрлэг, 5 иргэн, 5 өрх “Эрүүл мэндийг дэмжигч өрх, иргэн”-ээр тус тус шалгарлаа. “Эрүүл хүн”, “Эрүүл орчин-Эрүүл дүүрэг” хөтөлбөрүүдийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад танилцуулснаар Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөрийн “Орчны эрүүл мэнд” стратегийн төлөвлөлтөнд тусгагдсан ба 10 хороонд “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх” сургалт зохион байгуулж хороо бүрт усны төлөвлөлт хийгээд байна.</p>	90.0
73		Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт 45 – дээш насны иргэдийн 50-с доошгүй хувийг хамруулж урьдчилан сэргийлэх ажлыг хүртээмжтэй болгоно.	Дүүргийн нийт хүн амын 22.7% буюу 63.184 нь 40-64 насны /зорилтот бүлэг/ хүн ам байна. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн 34.8% буюу 21.890 хүнийг хамруулснаас цусны даралт ихсэх өвчтэй 615, чихрийн шижин өвчний 2-р хэв шинжтэй 91, умайн хүзүүний хавдрын урьдал өвчтэй 47 хүн оношлогдож эмчилгээнд хамрагдаад байна. Умайн хүзүүний хорт хавдрыг илрүүлэх шинжилгээг Өрхийн эрүүл	70.0

			мэндийн төвүүдэд зохион байгуулж зорилтот бүлгийн 12.418 эмэгтэйгээс 19.7% буюу 2932 эмэгтэйг хамруулан 77 хавдрын урьдал эмгэгийн сэжигтэй, 11 умайн хүзүүний хавдрын сэжигтэй тохиолдлыг илрүүлж дараагийн шатлалын эмнэлэгт илгээн 47 оношийг баталгаажуулж эмчилгээнд хамруулаад байна. Хөхний хавдрын эрт илрүүлэлтийн үзлэгт нийт 1787 иргэнийг хамруулаад байна.	
74	Өсвөр үе, хүүхэд залуучуудыг архи, тамхи, мансуурах донд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулна.	Эрүүл мэндийн төвийн Сэтгэл зүй, нөхөн үржихүйн кабинетаар дамжуулан стресс, архи тамхины хор уршиг сургалтыг 6 их дээд сургуулийн 1092 оюутанд, дэлгэцийн донтолт, архи тамхины хор уршиг сэдвүүдээр ерөнхий боловсролын 8 сургуулийн 980, мансууруулах бодисын хор уршиг сэдвээр 8 сургуулийн 256 сурагчдад сургалт явуулж, сурталчилгааны материал тараан, нийт 350 орчим хүүхдэд зөвлөгөө өгөн ажиллаж байна.	100.0	
75	Чихрийн шижин, хорт хавдрын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, тандалтын ажлуудыг зохион байгуулна.	Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд “Заавал хэвшүүлэх 21 дадал”-ын нэг дадал “Зохистой зөв хооллолт “ уриан дор дүүргийн хэмжээнд өдөрлөг зохион байгуулж нийт 458 иргэнийг хамруулан ажиллаа. Өдөрлөгийн үеэр зөв зохистой хооллолтын үзэсгэлэн гаргаж “Чихрийн шижин өвчин”, “Цусанд өөх тос ихсэх нь”, “Цусны даралт ихсэх өвчин”-үүдийн гарын авлагыг 5000 гаруй иргэнд хүргэж, иргэдийн цусан дахь сахар, цусны даралтыг үзэж мэргэжлийн эмчийн зөвлөгөө өглөө. “Чихрийн шижин ба эмчилгээний хоол шим тэжээл” сэдэвт багц сургалт, “Таргалалт ба эмчилгээний хоол, шим тэжээл” сэдэвт багц сургалт, “Жирэмсэн эхчүүдийн хоол тэжээл” багц сургалтуудыг зохион явуулж нийт 420 хүнийг хамрууллаа. Эхний 11 сарын байдлаар ЭМТ-ийн “Хоол, шим тэжээлийн боловсрол олгох” төв /ХШТБОТөв/ нь өндөр жин хэмжих, биеийн найрлага тодорхойлох, цусны даралт , цусны сахар хэмжих аппаратуудаар бүрэн хангагдсан ба 564 иргэнд тус бүрт хэмжилтүүдийг хийн ганцаарчилсан зөвлөгөө өгөн ажиллаж байна. “Цусны даралт ихсэх өвчин ба эмчилгээний хоол, шим тэжээл” 4 удаагийн цуврал сургалтанд 109, “Таргалалт ба эмчилгээний хоол, шим тэжээл” 8 удаагийн цуврал сургалтанд 67 иргэнийг, “Цусанд өөх тос ихсэх өвчин ба эмчилгээний хоол, шим тэжээл” 3 удаагийн багийн цуврал сургалтанд 186 иргэнийг, жирэмсэн эхийн хооллолт” 3	100.0	

			сургалтанд 68 иргэнийг, “Зохистой хооллолт” 4 удаагийн сургалтад 157 хүнийг хамруулав.	
76	2.2.3. Цахим бүртгэлийг хэрэгжүүлэн, хүн амд чирэгдэлгүй, товлот үйлчилгээг нэвтрүүлнэ.	Поликлиник, амбулаториудын программ болон техник хангамж, дотоод сүлжээг сайжруулна.	Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах, даатгал, статистикийн мэдээг дамжуулах зорилготой health info 2 программ шинэчлэгдэж Health info 3 программ хангамж нэвтэрч байгаатай холбоотойгоор ЭМХТөв болон уг программыг хөгжүүлэгч Кредо Терра ХХК-ны төлөөлөлтэй хамтран Эрүүл мэндийн төвийн эрхийг үүсгүүлж, эхний ээлжинд даатгал, статистикийн албаны ажилчдад Health Info 3 программыг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна. Эрүүл мэндийн төв, салбар амбулаториуд товлот үйлчилгээ болон хүлээгдлийг багасгах зорилгоор 49 кабинетын үзлэгийг цахимаар бүртгэн, эмч нарын үзлэг, шинжилгээний бүртгэлийг цахим санд шилжүүлээд байна. Өрхийн эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн төв болон салбар амбулаториудад цаг авах тогтолцоог хэрэгжүүлж өрхийн эрүүл мэндийн төвөөс шинжилгээний дугаарыг шууд тараах, хариуг цахимаар харах боломжтой болсон.	100.0
77		Амбулаториудыг автомат дугаар тараагч машинаар хангах ажлыг эхлүүлнэ.	Цахим бүртгэлийн хэсэгт дараалал тогтоох машин суурилуулж үйлчлүүлэгчид дугаарын дагуу цахим бүртгэлээс үзлэгийн дугаар авах нөхцлийг бүрдүүлсэн.	100.0
78	2.2.4. Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	Эмч, сувилагч нарыг мэргэшүүлэх, ажлын байран дах болон давтан сургалтад хамруулж, туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.	“Эрүүл мэндийн суварга” байгууллагатай хамтран БНСУ-ын Чунь - Ань их сургуулийн эмнэлэг, Чейл эмэгтэйчүүдийн эмнэлэгт мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хүүхэд, дотор болон эмэгтэйчүүдийн 20 эмчийг хамруулав. Эмч нарын мэргэжил дээшлүүлэх ажилд дүүргийн Засаг даргын зүгээс 40.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.	100.0
79		Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнуудтай ёс зүйн гэрээ байгуулж мөрдүүлэн ажиллана.	Дүүргийн Засаг даргын 2014 оны А/185 дугаар захирамж эрүүл мэндийн төвүүдтэй гурвалсан гүйцэтгэлийн гэрээг байгуулсан бөгөөд гэрээний 4.5.11-т эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахих, мэргэжлийн үүргийг чанд биелүүлэх заалтыг тусган ажиллаж байна.	50.0
80	2.2.5. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийн хөгжил-4”	Жишиг эмнэлгийн барилгыг эхлүүлнэ.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийн хашаанд дүүргийн Жишиг эмнэлэг барих “Эрүүл мэндийн салбар хөгжил -4” төслийн хүрээнд эмнэлгийн барилгатай холбоотой асуудлаар ЭМЯ, НЭМГ, Голландын Си-Мед компаний зөвлөх баг	50.0

	төслийн хүрээнд дүүргийн жишиг эмнэлэг байгуулна.		болон бусад байгууллагууд оролцсон зөвлөлдөх уулзалт 14 удаа зохион байгуулагдлаа. Голландын Си-Мед компаний зөвлөх багийн боловсруулсан зураг архитекторын ажлыг дуусгаж нээлттэй тендер зарлагдаад байна.	
81	2.2.6. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэн бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Иргэдийн усан спортоор хичээллэх боломжийг бүрдүүлнэ.	2014 оны 01-р сард Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаа эхэлсэн ба үндсэн ажиллагаа тогтмол хэвийн явагдаж 1950 гаруй үйлчлүүлэгчтэй болоод байна. Нийт үйлчлүүлэгчийн 0.7% буюу 15 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд усан спортоор хичээллэж байна. Усан спорт сургалтын төв нь “Сэлэм загас” нэртэй клубыг /10 хүний бүрэлдэхүүнтэй/ байгуулан Эрдэнэт үйлдвэр ХХК-ий нэрэмжит 23 дахь усанд сэлэлтийн “Өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга” шалгаруулах тэмцээн, “Улсын аварга” шалгаруулах тэмцээнүүдэд оролцож алт-25, мөнгө-25, хүрэл-21 медаль хүртсэн амжилтыг үзүүллээ. Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааг сурталчлах 2 удаагийн арга хэмжээг дүүргийн дэргэдэх хэлтэс, албадуудыг хамруулан зохион байгуулаад байна. Усан спорт, сургалтын төвийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд FM 101,7 болон Olloo, Sport box, TV5, 3a, Eagle телевизүүдтэй хамтран ажиллаж байна.	100.0
82		Дүүргийн спортын ордонг ашиглалтанд оруулна.	Дүүргийн 700 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлыг “Боорчи” ХХК гүйцэтгэж байна. Одоогоор: Барилга угсралтын ажил - 98% Дотор заслын ажил - 80% Гадна инженерийн шугам сүлжээний ажил - 70% - Гадна цэвэр ус – 100% - Гадна бохир ус – 100% - Уурын зуух – 60% - ТП цахилгаан – 60%-тай явагдаж байгаа болно. Спорт цогцолборын барилгын нэмэгдэл 1.08 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2015 оны төсөвт тусгаад байна.	70.0
83		Монголын бүх ард түмний спортын XIV их наадмыг дүүрэгт зохион байгуулна.	Монголын бүх ард түмний спортын XIV их наадам улсын хэмжээнд зохион байгуулагдаагүй бөгөөд дүүргийн Засаг даргын 2014 оны А/171 дүгээр захирамжаар “Иргэдийн спортын III наадам”-ыг спортын 8 төрлөөр нийт 5080 гаруй иргэнийг хамруулан зохион байгуулж, нийслэлийн шигшээ тэмцээнд оролцуулснаар Ү байр	100.0

			ээлсэн. Дүүргийн Засаг даргын захирамжаар 11.8 сая төгрөгийг наадмын арга хэмжээг зохион байгуулахад зарцууллаа. Дүүргийн хэмжээнд эхний 3 байрыг 6, 9, 13 дугаар хороод эзэллээ. Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2014 онд бүх нийтийн спорт өдөрлөг, сургалт семинарыг 62 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 846 байгууллагын 58.178 хүнийг хамруулан ажилласан дүнтэй байна.	
84		Хүүхэд, залуучуудын дунд “999 шатарчин” хөдөлгөөн өрнүүлнэ.	Ерөнхий боловсролын 13 сургууль “ 999 шатарчин” хөдөлгөөний хүрээнд шатрын дугуйлан ажиллуулж байна. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/26 дугаар захирамжаар “Өсвөрийн 999 шатарчин” анхдугаар тэмцээнийг дүүргийн Засаг даргын нэрэмжит болгон зохион байгуулж 5 насны ангилалаар 15 сургуулийн 180 гаруй тамирчдыг хамрууллаа.	100.0
85		Дүүрэгт биеийн тамир спортын байгууллага үүссэний 20 жилийн ойн нэрэмжит арга хэмжээ зохион байгуулна	Биеийн тамир спорт хороо үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг угтан “Спортлог Сонгинохайрханчууд” арга хэмжээг “Буянт Ухаа” спорт ордонд 11-р сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд 85 байгууллагын 500 тамирчин оролцож, “Их спорт ирээдүйг дуудаж байна” гала тоглолтонд нийт спортын 20 төрлийн тоглолтыг 3058 тамирчид үзүүллээ.	100.0
86		Хороодод хийн дасгалын клуб байгуулахыг дэмжинэ.	Ахмад настны хийн дасгалыг тогтмол 4 ээлжээр хичээллүүлж өдөрт 40-60 ахмад настан байнга хамрагдаж байна. Хороодын чийрэгжүүлэлтийн танхимд ахмадууд хийн дасгалаар тогтмол хичээллэж байгаа16 хороонд нийт 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй 640 иргэн тогтмол хийн дасгалаар хичээллэж байна. 2014 онд сургагч багш бэлтгэх 5 өдрийн сургалтыг Эрүүл мэндийн төвд зохион байгуулж 30 сургагч багш бэлтгээд байна. Дүүргийн Засаг даргын 2014 оны 171 дугаар захирамжийн дагуу “Хийн дасгалын тэмцээн”-ийг зохион байгуулж 16 хорооны 256 тамирчдыг хамрууллаа.	100.0
2.3 Боловсролын талаар				
127	3.1.2. Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг үе шаттайгаар засварлаж шинэчилнэ.	Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг засварлаж шинэчлэх ажлыг үргэлжүүлнэ. /19-р хорооны 4а, 3-58, Геологийн 5-30-р байрны дээврийг шинэчлэх, 8а /1, 3-р орц/, 8в /1, 5-р/, 7в байрны цахилгаан шатыг солих/	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19-р хорооны “Тохилго- 21” СӨХ-ны 3-р 58, 4а байр, “Дэлгэр-21” СӨХ-ны геологийн 5-30-р байр зэрэг насжилт өндөртэй орон сууцны 24 байрны дээврийг засварлах ажил /1,25 тэрбум төгрөг/, нийслэлийн хөрөнгө оруулалтаар “Өнөр-11” СӨХ-ны 3-р орц, “Их Мандал” СӨХ-ны 5-р байр, “Есөн-Эрдэнэ” СӨХ-ны 9-р орц, “Өнөр бүл” СӨХ-ны 22-р байрны 3-р орцны дээврийн засварын ажлууд тус тус хийгдсэн. 19-р хорооны “Сүрлэг-21” СӨХ-ны 8а байрны 1-р орц, 8в байрны 1, 5-р орцны цахилгаан шат зэрэг дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны байруудын 104 цахилгаан шатыг шинэчлэх ажилд “Тотруссоюуз” ХХК шалгаран гэрээ байгуулан ажил эхлүүлээд байна.	90.0
128	3.1.3. Замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор авто замуудыг шинээр барих, авто замын өргөтгөл хийх ажлыг зохион байгуулах, зам	Нийтийн эзэмшлийн болон орон сууц, гэр хорооллын доторх авто зам, гүүрийг шинээр тавих, засварлах ажлыг үргэлжлүүлнэ.	Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хорооллын доторх автозамын засварын ажлыг 20 байршилд төлөвлөн, 5,9 км автозамыг шинэчлэн сайжруулахаар нэгдсэн жагсаалт гаргаж, саналаа нийслэлийн Авто замын газарт дүүргийн ЗДТГ-ын 3/173 дугаар албан бичгээр хүргүүлснээс 4 байршилд 570.0 сая төгрөгөөр засвар хийгдэхээр шийдвэрлэгдсэн. Үүнд: - 29-р хорооны нутаг дэвсгэр Драгон төв орчмын хороолол дунд 750 у/м авто замын шинэчлэлтийг “Саруул харгуй” ХХК хийж	100.0

	засварын ажлын чанарыг сайжруулна.	гүйцэтгэсэн. /318.0 сая төгрөг/ - 29-р хорооны Москва хорооллын орчмын 100 у/м авто замын шинэчлэлтийг “Хөвчийн зам” ХХК гүйцэтгэсэн. /55.0 сая төгрөг/ - 15-р хорооны 23-р байрны өмнөх 160 у/м авто замын шинэчлэлтийг “Монгол сата интернэшнл” ХХК гүйцэтгэсэн. /71.0 сая төгрөг/ - 15-р хорооны 26-р байрны өмнөх 180 у/м авто замын шинэчлэлтийг “Роут трейд” ХХК гүйцэтгэсэн. /75.0 сая төгрөг/ Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар: - 3-р хорооны Бага нарангийн 22-р гудамжны шороон замыг сайжруулж тэгшлэх ажлыг “Хайрхан 25” иргэдийн бүлэг /15,8 сая төгрөг/ - 3-р хорооны Бага нарангийн 32-р гудамжны шороон замыг сайжруулж тэгшлэх ажлыг “Хөгжил бидний ирээдүй” иргэдийн бүлэг /14.0 сая төгрөг/ - 8-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай засах, гудамжны автомашины замыг сайжруулах, явган хүний зам тавих ажлыг “Хөвчийн зам” ХХК / 47,1 сая төгрөг/ - 23-р хорооны нутаг дэвсгэр 1-р хороолоос дээш өгсдөг шороон замыг сайжруулан засаж тэгшлэх ажлыг “Эвт уул” ХХК /49,5 сая төгрөг/ 31-р хорооны нутаг дэвсгэр, гэр хорооллын дундах авто замыг асфальтан хучилт хийж засах ажлыг “Бэюс” ХХК /79.0 сая/ тус тус хийж гүйцэтгэсэн.	
129	Хувьсгалчдын гудамж, Зурагтын шинэ эцсийн буудлаас Баянхошууны уулзвар хүртэлх авто замыг өргөтгөн шинэчилнэ.	Зурагтын шинэ эцсийн буудлаас Баянхошууны тойрог хүртэлх Хувьсгалчдын гудамжны 4,9 км авто замын иж бүрэн шинэчлэлтийн ажлыг “Экспресс зам” ХХК /7.0 тэрбум/ хийж гүйцэтгэсэн.	100.0
130	1-р хорооллын 34-р байрны арын гүүрнээс Хамбын овоо хүртэл 2,5 км замыг засаж сайжруулах	Нийслэлийн 2014 оны төсвийн тодотголд тусгуулах талаар нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч Т.Болдбаатарт Засаг даргын 06-р сарын 24-ний өдрийн 1/1189 дугаар албан бичгээр уламжлан санал хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй.	30.0
131	Дүүргийн арын замаас Баруун салааны хар замтай холбох 3,5 км замыг барихад шаардагдах хөрөнгийн асуудлыг улс, нийслэлийн төсөвт шат	Нийслэлийн 2014 оны төсвийн тодотголд тусгуулах талаар нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч нарт Засаг даргын 06-р сарын 24-ний өдрийн 1/1187, 1/1190 дугаар албан бичгүүдээр уламжлан санал хүргүүлсэн.	50.0

		дараатайгаар тусгуулах ажлыг зохион байгуулна.		
132		9-р хороо Жанцангийн тойрог, Хуучин эцсийн тойрогт нүхэн гарц, уулзварууд байгуулах нөхцөл, боломжийг судлан холбогдох байгууллагуудад уламжлах	Нийслэлийн 2014 оны төсвийн тодотголд тусгуулах саналаа нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч нарт 06-р сарын 24-ний өдрийн 1/1187, 1/1188 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн. Мөн нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилт, 2015-2017 оны хөрөнгө оруулалтын ажлын саналд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1020, 1/1026 тоот албан бичгээр нийслэлийн Засаг дарга, ЗДТГ-т хүргүүлэн уламжилсан. 9, 10-р хороодын иргэдээс гаргасан саналын дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Жанцангийн буудлаас Баянхошууны эцсийн буудал хүртэлх 160 метр авто замын засварын ажлыг “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн.	90.0
133	3.1.4. Ард Аюушийн гудамжийг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3.1 км замыг гүүрийн хамт барина	Ард Аюушийн гудамжийг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3.1км замыг гүүрийн хамт барих ажлыг эхлүүлнэ.	Баянгол дүүргийн 3-р хорооллын Ард Аюушийн гудамжийг дүүргийн 23, 30, 31-р хороодын нутаг дэвсгэрээр дамжуулан 19, 27-р хороодын нутаг дэвсгэр дэх Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3,1 км авто зам, 6 гүүрийн хамт баригдах авто замын трасст орсон 229 нэгж талбар, 100 байшингийн хөрөнгийн үнэлгээ, хөрөнгийн бүтэц, ангилалд судалгаа, үнэлгээ хийх ажлууд урд жилүүдэд хийгдсэн. 2015 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гудамж” төслийн хүрээнд авто замын ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна. Нийслэлийн 2014 оны төсвийн тодотголд тусгуулах талаар Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч Т.Болдбаатарт 06-р сарын 24-ний өдрийн 1/1189 дугаар албан тоотоор хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/312 дугаар захирамжаар байгуулагдсан Ард Аюушийн гудамжийг Толгойтын замтай холбох 3.1 км автозам байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн трасст орсон 23, 30-р хорооны иргэдтэй уулзалт, хэлэлцүүлгийг 10-р сарын 25-ны өдөр ИТХ-ын Ажлын албатай хамтран хорооны иргэний танхимд зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үеэр иргэдийн сонирхсон асуултад хариулж, газрын үнэлгээний маягтыг тараасан. Дээрх хороодын замын трасст орсон 111 иргэнээс санал асуулга авахад 44.1 хувь нь газраа байраар солих, 41.4 хувь нь мөнгөөр, 9,9 хувь	50.0

			нь чөлөөлөх боломжгүй, 3.7 хувь нь тухайн үед шийдвэрээ гаргах, 0,9 хувь нь өөр байршилд газраар солино гэсэн судалгаа гарсан байна.	
134	3.1.5.Ашиглалтын шаардлага хангахгүй хуучин орон сууцны барилгуудын газрын эрхийг бүртгэлжүүлж, оршин суугчдын оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг	20-р хорооны Хуучин цэргийн хотхон, Хангамж, 1, 5-р баазын ажилчдын байр, Төмөр замын дан байруудыг “Цэргийн хотхон” орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажлыг үргэлжлүүлнэ.	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу “Цэргийн хотхон” орчмыг орон сууцжуулах ажилд “Чогсэрд” ХХК шалгаран батлагдсан зураг төсвийн дагуу барилгын ажлаа эхлүүлээд байна. 1, 2, 20-р хорооны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд багтаж байгаа Хангамж, 1, 5-р баазын ажилчдын байр, төмөр замын дан байруудын оршин суугчдын дунд гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулахад Хас харш ХХК шалгарч Төслийн удирдах хорооноос батламжлагдан оршин суугчидтай 2 тал гэрээг 90 хувь, 3 талт гэрээг 50 хувь орчим байгуулан ажиллаж байна.	70.0
135	концессын гэрээгээр хийж гүйцэтгэнэ.	Дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороололд инженерийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр нийслэлийн Захирагчийн албаны дүүрэг дэх албадтай хамтран ажиллана.	Нийслэлийн захирагчийн дүүрэг дэх албадтай хамтран иргэдтэй 10 удаагийн сургалт зохион байгуулж судалгаа гарган ажиллаа. 30-р хорооны Хилчин хотхон орчмын иргэдтэй уулзалт зохион байгуулан, төсөл хэрэгжүүлэгч “Монгол дайван” ХХК-ний гүйцэтгэлийн явцтай танилцахад төсөл хэрэгжүүлэгч нь зураг төсөл, гүйцэтгэлийг графикийн дагуу гүйцэтгэж байгаа болно. Дүүргийн 5-р хороонд төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан “Жиди” ХХК-ний инженерийн дэд бүтцийг бий болгох, барилгажилтын ажлыг эхлүүлэхэд эхний ээлжинд газар чөлөөлөх шаардлагатай газар эзэмших, өмчлөх эрхийн зөрчилтэй 40 айлын зөрчлийг нийслэлийн Засаг даргын А/405 дугаар захирамжийн дагуу шийдвэрлүүлсэн. Мөн 2014 оны 4-р улиралд хэрэгжиж эхлэх эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний ажил болон барилгажилтын ажил тухайн талбайд 10 гаруй гидрогеологийн өрөмдлөг хийхэд 70-150см намгархаг хөрс илэрсэн тул барилгажилт, инженерийн дэд бүтцийн зураг шинээр хийлгэх шаардлагатай болж 2015 оны хавар дээрх ажлыг эхлүүлэхээр болсон. Иймд нийслэлийн захирагчийн Наран дахь ажлын албатай хамтран гүйцэтгэгч компаний ажил хойшилсон талаар тухайн байршилд хамрагдсан иргэдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтад ирсэн 100 гаруй иргэдэд зөвлөгөө өглөө. Мөн 6-р хороонд төсөл хэрэгжүүлэгч “Хера Пропертийз” ХХК нь цахилгааны дэд бүтцийн 1 комплектийг байгуулах 24-3 тоот айлтай гэрээ хийн газрыг чөлөөлөх шаардлагатай тул газар	70.0

			өмчлөх эрхийн зөрчлийг арилган шийдвэрлэв.	
136	3.1.6. Иргэдийг хямд үнэтэй орон сууц, амины орон сууцаар хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Иргэдийн санал санаачлагыг өрнүүлэн бүлгийн зохион байгуулалтанд оруулах замаар дахин төлөвлөлтөнд хамруулах, орон сууцжуулах ажлыг холбогдох байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулна.	Дүүргийн хэмжээнд 22 хорооны 1950 гаруй иргэдэд гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар сургалт, ярилцлагыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж мэдээлэл зөвлөгөө өгсөн. Тус дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, дүүргийн удирдлагууд оролцсон уулзалтыг 7, 8, 9, 10, 28-р хороодын 400 гаруй иргэдийн дунд зохион байгуулж, гэр хорооллын дахин төлөвлөлт, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц, цаашид хийгдэх ажлуудын талаар танилцуулсан. 4, 11, 22, 23-р хороодод 5 иргэдийн бүлэг шинээр байгуулагдаж тус бүлгүүдээс гарсан дахин төлөвлөлтөд хамрагдах хүсэлтийг Гэр хорооллын орон сууцжуулах төсөлд хүргүүлсэн. Иргэдийн бүлгээс гарсан саналыг үндэслэн тухайн байршилд нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудаар дүгнэлт гаргуулахаар ажилллаж байна.	70.0
137	3.1.7. Гэр хорооллын өрхийн усны хүрэлцээ, хангамжийг сайжруулна.	1, 2, 4, 6, 7, 21, 22, 23, 24, 25, 26, 31, 32-р хороодод худаг, усан сан барина.	21, 24, 25, 32-р хороодод 6 гүний худгийг “Ус Эрдэнэ” ХХК, “Солана” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 2, 6, 7, 22, 23, 24, 25, 26, 31-р хорооны 10 байршилд зөөврийн ус түгээх байрыг барьсан. Дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт “Хааны эрэл-2014” цэргийн сургуульд оролцож байгаа АНУ-ын Аляскийн цэргийн тойргийн хөрөнгөөр баригдсан ус түгээх байрыг улсын комисс хүлээн авч, хөрөнгийн бүртгэлд бүртгэж албажуулан баталгаажуулсан.	90.0
138	3.1.8. Гэр хорооллын эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг шинээр холбож, шаардлагатай газруудад хүчдлийг сайжруулна.	1, 2, 7, 10, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31, 32-р хороодын эрчим хүчгүй айл өрхийн судалгааг шинэчлэн гаргаж, шинээр холбох, хүчдэл сайжруулна.	“Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчгүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаанаар хангах” хөтөлбөрийн төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийн судалгааг нийслэлийн Инженерийн байгууламжийн хэлтэст 03-р сарын 20-ны өдрийн 3/523 дугаар албан бичгээр, 06-р сарын 20-ны өдрийн 1164 дугаар албан бичгээр УБЦТС ХК-д хүргүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 2, 5, 7, 8, 9, 10, 21, 22, 23, 24, 25, 28, 31, 32-р хороодын цахилгаангүй 2860 өрх, хүчдэлийн уналттай 3311 өрхийн цахилгааны хангамжийг сайжруулах 34 төрлийн ажлыг 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Инерци” ХХК, “Хүрд” ХХК, “Дархан	90.0

			парагон” ХХК, “Ханлиг элч” ХХК-иуд хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 90%. Цахилгаан дамжуулах кабелийн шугамыг шинэчлэх угсралтын ажлыг “Согриглун” ХХК компани гүйцэтгэж байгаа бөгөөд 17-р хорооны 33 дугаар байрны ар талд баригдах шинэ РП-ээс ХТП-741/ТП12/ хүртэлх 10Кв-ын, 18-р хорооны РП-4 ХБ-аас ХТП2922 хүртэлх 6Кв-ын кабелийн шугамыг шинэчлэх угсралтын ажил хийгдсэн.	
139	3.1.9. Баянхошуу, Орбит, Толгойтод орчимд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий дулааны станц, бохир усны гол шугамыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Мэдээлэл сургалт хийх, сурталчлах замаар дэд бүтэц байгуулах ажилд иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Гэр хорооллын шинэ дэд төвүүдийн байршлыг тогтоох тухай Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар дэмжигдсэн дүүргийн 7, 8, 9, 10, 28-р хороодыг хамарсан Баянхошуу дэд төвийг байгуулах ажлын хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдаж байна. - Баянхошуу, төвийн бохирын коллеторын хоолойг холбох зураг төслийн ажил хийгдэж байна. - Барилгын ажлын хяналт гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний компаний сонгон шалгаруулалт хийгдэж байна. - Хөтөлбөрийн Менежментийн албанд дэмжлэг үзүүлэх компаний сонгон шалгаруулалтыг хийж байна. . Уг төсөлд зориулж ойрын хугацаанд ажлыг эхлүүлэхээр АХБ-ны зөвлөх мэргэжилтнүүдтэй нягт хамтран ажиллаж байна. 2014 онд нийслэлийн төсөвт 16,5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.	90.0
140		Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох эхний ээлжийн байршлуудад оршин суугчдын санал авах ажлыг зохион байгуулна.	Гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдахаар хүсэлт гаргасан 2503 иргэнээс санал авахад 50 гаруй хувь нь эзэмшлийн газартаа инженерийн шугам сүлжээ татуулах хүсэлт гаргасан бөгөөд саналыг Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газарт хүргүүлэн ажиллав.	90.0
141	3.1.10. Гэр хороолол болон шинээр баригдах хороололд ахуйн үйлчилгээний цогцолбор барилга барина.	Гэр хороололд шинээр Ахуйн үйлчилгээний төв, халуун усны цэгүүдийг барих ажлыг судлан дэмжиж ажиллана. /9, 28 дугаар хороо/	Нийслэлийн 2014 оны төсвийн тодотголд суулгаж өгөх талаар нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч нарт 2014 оны 06-р сарын 24-ний өдрийн 1/1187, 1/1188 дугаараар хүргүүлэв. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй.	30.0
142	3.1.11. Иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.	Нийтийн тээврийн үйлчилгээний автобусын тоог нэмэгдүүлнэ.	Тахилтын чиглэлд том оврын 9 автобус /том оврын автобус үйлчилдэггүй байсан/, Баруун салаанаас Баянхошуу хойгуур ажлын өдөр 13 /урд нь 9 автобустай байсан/, урдуур 6, амралтын өдөр 4 том оврын автобус шугамаа уртасган Наран туул зах хүртэл үйлчилж байна. Зүүн салааны чиглэлд том оврын	100.0

			автобусны 1 ээлжийн үйлчилгээг 2 ээлж болгож нийтийн тээврийн том оврын автобусны тоог нэмэгдүүлсэн. 23-р хорооны Өндөр дэнж буюу Овоотын чиглэлд үйлчилгээ эрхэлж байсан “Сутайн буянт” компани гэрээ цуцалсан тул 05-р сарын 23-ны өдрөөс эхлэн “Эрийн хийморь” компани 11 бага оврын автобусаар үйлчилгээ үзүүлж байна.	
143	3.1.13. Толгойт Сонсголонгийн замын уулзварт барих гүүрэн гарц барих ажлыг эхлүүлнэ.	Сонсголонгийн авто зам, гүүрийн авто зам барих ажлыг үргэлжлүүлнэ.	“Гудамж төсөл”-ийн хүрээнд өргөтгөн, шинэчилж буй Сонсголон чиглэлийн 5,5 км авто замын ажлыг “Арц Суварга”ХХК, “Бадрах ойл” ХХКомпаниуд гүйцэтгэж байна. /23.0 тэрбум/	90.0
3.2 Төхижилт				
144	3.2.1. Иргэдийн ая тухтай амьдрах, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай газруудад бичил цэцэрлэг, усан оргилуур, тоглоомын талбай, нийтийн бие засах газар, явган хүний зам, гүүр, гарц барина.	1, 3, 14, 16, 17, 20, 29-р хороодод хүүхдийн тоглоомын талбай, 12, 18-р хороодод спортын талбай байгуулна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 16-р хороонд “Агаар салхивч” ХХК 71,3 сая төгрөгөөр, 14-р хороонд “Цамц” ХХК 51.1 сая төгрөгөөр, 17-р хороонд “НБНМДД” ХХК 49.4 сая төгрөгөөр, 20-р хороонд “Хустайн шил” ХХК 41.3 сая төгрөгөөр, 29-р хороонд “Ньюгранд технологи” ХХК 50.4 сая төгрөгөөр хүүхдийн тоглоомын талбайг шинээр тус тус байгуулсан. Мөн 12-р хороонд сагсан бөмбөг болон гар бөмбөгийн спорт талбай байгуулах ажлыг “Голден прогресс” ХХК 42.7 сая төгрөгөөр, 18-р хороонд спорт талбайг “Мон-Эрдэнэ групп” ХХК 63.4 сая төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтанд хүлээлгэн өгсөн. 12, 22, 23-р хороодын нутаг дэвсгэрт нийслэлийн хөрөнгө оруулалтаар он дамжин хийгдэж байгаа ажлуудыг улсын комисс хүлээн авсан. 1-р хороонд хийгдэхээр төлөвлөгдсөн хүүхдийн тоглоомын талбай барих ажил хөрөнгийн эх үүсвэр байхгүй тул хасагдсан.	90.0
145		20, 28-р хороодод сагсан бөмбөгийн талбай байгуулна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20-р хороо шинэ цэргийн хотхоны 73-р байрны баруун талд “ШЦХ” иргэдийн бүлэг 19.9 сая төгрөгөөр, 28-р хорооны 6-р гудамжны өргөн чөлөөнд “Хөлөг-Од” ХХК 42.9 сая төгрөгөөр сагсан бөмбөгийн талбай барих ажлыг тус тус гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн. “Хөлөг-Од” ХХК шалны резинэн будгийг хавар дулаан орохоор хийхээр болсон.	90.0

146		2, 15-р хороодод бичил цэцэрлэг байгуулж, тохижуулах замаар нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	2-р хорооны нутаг дэвсгэрт “Ган зосон констракшн” ХХК 34.0 сая төгрөгийн, 15-р хороонд “Ган-Үүд” ХХК 87.8 сая төгрөгийн, 19-р хорооны 8в байрны гадна талбайг тохижуулах, зүлэгжүүлэх мод тарих ажлыг “Ган зосон Констракшн” 40.0 сая төгрөгийн, 3-р хороонд “Хэрлэн хээ” ХХК 39.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр бичил цэцэрлэгүүдийн ажлыг тус тус хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн.	100.0
147		5, 9, 10, 15, 19, 26, 27, 30-р хороодод явган хүний зам, шат барьж, засварлана.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 210.3 сая төгрөгөөр хороодод явган хүний зам, шат барих ажлыг гүйцэтгэсэн болно. Үүнд: 1, 5, 9, 10, 16, 19, 27, 30-р хороодод явган хүний зам, 9, 31-р хороодод явган хүний шат тус тус барьж ашиглалтанд хүлээлгэн өгсөн.	90.0
148		9, 10, 21, 22, 24, 26, 31-р хороодод явган хүний гүүр барина.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 120.7 сая төгрөгөөр 9, 10, 24, 26, 31-р хороодод явган хүний гүүрийн ажлыг гүйцэтгэн ашиглалтанд оруулсан. 21, 22-р хороодод баригдах гүүрийн зураг стандарт хангаагүй тул баригдаагүй болно.	90.0
149		Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын газрын асуудлыг шийдвэрлэнэ.	Дүүргийн 32-р хороонд 2000 м2 газарт 100 ортой цэцэрлэгийн газрын асуудлыг шийдвэрлэсэн. Усан сангийн зориулалтаар 23 хорооны 26 байршилд дүүргийн Засаг даргын 2014 оны А/147 дугаар захирамжаар газар олгосон. 28-р хороо Сансарын 11-р гудамжинд хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар 0,24 га газрын дүүргийн Засаг даргын А/78, 16-р хорооны нутаг дэвсгэрт хорооны цогцолбор байр барих зориулалтаар 0,047 га газрын дүүргийн Засаг даргын 2014 оны А/417 дугаар захирамжаар тус тус шийдвэрлээд байна.	100.0
150	3.2.2. Дүүргийн томоохон гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийнэ.	1, 8, 13, 25, 27, 30-р хороодын гадна орчныг тохижуулж, 12-р хорооны цогцолборыг төвийн дулаанд, 28-р хорооны цогцолборыг цэвэр усны шугамд холбоно.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8-р хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбайг 47.1 сая, 13-р хорооны гадна тохижилтын ажлыг 36.6 сая, 27-р хорооны гадна тохижилтын ажлыг 21.8 сая, 25-р хорооны цогцолбор байрны гадна талын тохижилтын ажлыг 15.4 сая, 30-р хорооны гадна талын тохижилт, авто машины зогсоолын ажлыг 18.1 сая төгрөгөөр тус тус тохижуулан хүлээн авсан. 28-р хорооны цогцолбор байрыг цэвэр усны шугамд холбох ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр /20.0 сая төг/ гүйцэтгэхээр УСУГ-аас техникийн нөхцөл гаргуулсан боловч шугам татахад шаардагдах	70.0

			хөрөнгө хүрэлцэхгүй, газрын хувьд хад асга ихтэй тул нэмэлт ажлууд шаардлагатай болсон шалтгаанаар хойшлуулж 2015 оны нийслэлийн ОНХС-н хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр хандсан. 12-р хорооны байрны дулааны төвийн шугамд холбох талаар “Өнөр Энх Өргөө” ОНӨААТҮГ-т хандаж, “Мөнгөн гүүр” эмнэлгийн шугамаас татахаар техникийн нөхцөл боловсруулсан боловч “Мөнгөн гүүр” эмнэлгийн зүгээс өөрийн хөрөнгөөр татсан шугамнаас салаалах боломжгүй талаар мэдэгдсэн. Төвийн шугамаас татах зураг, төсөв гаргах ажил “Өнөр Энх Өргөө”, “Өнөр Тулга Өргөө” ОНӨААТҮГ-ууд нэгдэж, ОСНААҮҮГ-ын ХҮТ №15 болж өөрчлөгдсөнөөс хойшлогдсон.	
151		Хороодод жишиг гудамж байгуулна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 90.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3-р хороонд жишиг гудамж байгуулах ажлын зураг, төсөв хийх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог Засаг даргын А/58 дугаар захирамжаар байгуулан зураг, төсвийг “Нью Голден” ХХК-иар хийлгэсэн. Уг ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтыг боловсруулж дуусаад зарлах шатанд байсан боловч хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй.	50.0
152		170-р цэцэрлэг рүү явдаг гудамжинд авто болон явган хүний зам тавихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судална	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад багтаагүй тул хойшлогдсон ба дүүргийн 2015 оны нийгэм эдийн засгийн зорилтонд тусгах санал оруулсан.	10.0
153	3.2.3. Авто зам болон нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, дүүргийн нутаг дэвсгэр дэх рекламны байгууламжийг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан сайжруулан, орон сууц, гэр хорооллын	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11-р хорооны Хөтөл, 20-р хорооны Нефтийн уулзвараас Орбит хүртэлх, 13-р хорооны Залуус , 15-р хорооны Барилгачин гудамжны нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийг LED гэрэлтэй болгоно.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхошууны Хөтөлийн нийтийн эзэмшлийн авто замд 276 ЛЕД гэрэлтүүлэгчийг шинээр тавьсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13-р хорооны Залуус гудамжны гэрэлтүүлгийг 35.6 сая, Барилгачин гудамжны гэрэлтүүлгийг 32.1 сая төгрөгөөр тус тус шинээр тавьж ашиглалтанд оруулсан. Нефтийн уулзвараас Орбит хүртэлх гэрэлтүүлгийг 192.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хийж гүйцэтгэхээр гүйцэтгэгч компани шалгарсан боловч 2015-2016 онд тухайн газарт авто замын шинэчлэл хийхээр төлөвлөгдсөнтэй холбоотойгоор тендерийг хүчингүй болгосон.	90.0
154	гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар асалтыг 95 хувьд	1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31-р хороодод нийслэлийн төсөв, дүүргийн	Нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 21 хороонд 1.830.2 сая төгрөгөөр 44644 у/м газарт 1292 ширхэг гудамжны гэрэлтүүлэг тавьж ашиглалтанд хүлээн авсан. Замын	90.0

	хүргэнэ.	орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гэрэлтүүлэг шинээр тавина.	цагдаагийн тасаг, “Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮҮГ, Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран сард 1-2 удаа гэрэлтүүлгийн асалтын байдалд гэнэтийн болон хэсэгчилсэн шалгалт хийж ирсэн. Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг 91-97,3, орон сууцны дундах гэрэлтүүлэг 95-98, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг 79.2-94 хувийн асалттай байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 950 гэрэлтүүлэг хийгдсэн байна. Нарангийн голын авто замын дагуу 3300 метр СИП кабелийг шинэчлэн 20 ширхэг гэрэлтүүлгийн шон шинээр нэмж суурилуулсан.	
155		Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийг орчин үеийн шийдэл бүхий өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй болгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2014 оны 4 дүгээр албан даалгавар гаргаж, өмчийн харъяалал харгалзахгүйгээр аж ахуйн нэгж байгууллагуудыг орчноо тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гэрэлтүүлэг, хаягаа шинэчлэх талаар хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг нь хангуулан ажиллах зорилгоор нутаг дэвсгэрийн 144 аж ахуйн нэгж байгууллагуудад түүвэрчилсэн шалгалт хийхэд 124 ААНБ буюу 86 хувь нь гэрэлтүүлэг бүхий товгор үсгээр хаягжуулалтыг хийсэн, гадна талдаа камер бүхий гэрлэн чимэглэлтэй болсон байна. Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдэд ААНБ-ын гадна гэрэлтүүлэг реклам чимэглэлийг сайжруулахаар нэмэлт арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрийн төв зам болох Москвагийн болон ҮЭ-ийн гудамжинд үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ААНБ-уудын 95-аас дээшхи хувийн реклам гэрэлтүүлгийн асалт тогтмолжсон дүнтэй байна.	90.0
156		Орон сууцны хороолол, гэр хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, чимэглэлийн талаар мэдээллийн санг бүрдүүлэн, судалгааг баяжуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн зам талбайд 1575, орон сууцны хороололд 527, гэр хороололд 4186 ширхэг нийт 6288 ширхэг гэрэлтүүлэг байгааг бүртгэн Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газартай гэрээ байгуулан “ARC map” программыг авч мэдээллийн сан бүрдүүлсэн. Гэрэлтүүлгийн 75 хувь нь орчин үеийн шийдэл бүхий ЛЕД гэрэлтүүлэгчтэй болсон.	100.0
157		Гудамж талбайд байрлуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн реклам, зар сурталчилгааны самбар, байгууламжид тавих хяналтыг сайжруулж, стандартын шаардлага	Дүүргийн нутаг дэвсгэрт 2013 онд байгууламжаа байрлуулан гэрээ байгуулан ажилласан 24 аж ахуйн нэгж байгууллагын удирдлагатай 2014 онд гэрээг сунган хамтран ажилласан. Шинээр байгууламж байрлуулахаар хүсэлт ирүүлсэн 6 ААНБ-ын материалыг хүлээн авч дүүргийн Засаг даргын А/153, А/203, А/227	90.0

		хангасан хаягжилттай айл өрх, аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлнэ.	дугаар захирамжаар зөвшөөрөл олгон гэрээ байгуулсан. Байгууламжийн хураамж 105.6 сая төгрөгийг дүүргийн орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн. Шаардлага хангахгүй 3 байгууламжийг нийслэлийн хөрөнгөөр албадан буулгасан. Нийслэлийн Ерөнхий менежерийн баталсан гадна хаягжуулалтын журмыг ЗДТГ-ын даргын албан бичгээр хороодод хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.	
158	3.2.4. Автозам, орон сууцны доторхи зам, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд ахиц дэвшил гаргана.	Мэргэжлийн байгууллагын хүн, хүчийг нэмэгдүүлж, автозам болон орон сууцны хорооллын автозамуудыг арчилгаа, цэвэрлэгээнд бүрэн хамруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн 181350 м2 авто зам, 56120 м2 явган зам, хорооллын дундах 132269 м2 зам, 70770 м2 авто зогсоол, 537444 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээнд нийтийн эзэмшлийн зам талбайн 60 үйлчлэгч тогтмол ажиллаж байна. Цэвэрлэгээний байдалд 7-14 хоногт тогтмол хяналт тавин ажиллаа. Жолооч 1, ачигч 1, нийтийн зам талбайн үйлчлэгч 1 нийт 3 хүн ажлаараа шалгаран Гонкконг улсад аялсан.	100.0
159	3.2.5. Тусгай зориулалтын зам, шат, хаалга байгуулах ажлыг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Дүүрэгт шинээр баригдаж байгаа болон засварлаж байгаа зам, барилгын ажил, албан байгууллага, нийтийн үйлчилгээний барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх стандартыг мөрдүүлнэ.	“Иргэний барилга төлөвлөлт ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайг тооцож, хөгжлийн бэрхшээлтэй хүний явган зорчих стандарт”-ын дагуу чөлөөтэй бие даан зорчих, үйлчлүүлэх боломж нөхцлийг хангах үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг Дүүргийн Засаг даргын А/87 дугаар захирамжаар байгуулан, дүүргийн нутаг дэвсгэрт шинээр баригдаж буй барилгын үйл явцтай танилцан, зөвлөмж тараан ажиллаа. Дүүргийн Засаг даргын А/385 дугаар захирамжаар мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулж дүүргийн нутгийн захиргааны 52 байгууллага, хороодод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ээлтэй орчин бүрдүүлсэн байдалд үзлэг шалгалтыг хийхэд 51 нь шаардлага хангаагүй дүнтэй гарсан байна. Дүүргийн Засаг даргын А/333 дугаар захирамжаар дээрх 51 байгууллагад налуу шат хийлгэх ажлын зураг, төсөв хийлгэхээр худалдан авах ажиллагааг зарлаад байна.	90.0
160	3.2.6. Дүүргийн цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.	20-р хороо Сонгинохайрхан уулын зүүн бэл, 30-р хороо Хамбын овоонд тус тус цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлнэ.	2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 30-р хорооны нутаг дэвсгэр Хамбын овоонд 158 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар тусган нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт уламжилснаар хэсэгчилсэн зураг, төсвийн ажлыг “Эрчим Арт” ХХК хийж гүйцэтгэсэн. Төсөв хөрөнгийн асуудал шийдэгдвэл цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил шийдэгдэх боломжтой болсон. 20-р хорооны нутаг дэвсгэрт “Авто худалдааны	50.0

			цогцолбор ” байгуулах ажлын хүрээнд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил хамт хийгдэхээр төлөвлөгдсөн.	
161	3.2.7. Тодорхой байршлуудад газар доорх болон давхар граж, авто зогсоол барих чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	Иргэдийн санал хүсэлтийг судлан, байршлыг тогтооно.	17-р хорооны иргэдийн дунд 3-р сарын 2, 22-ны өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулан, санал хүсэлтийг үндэслэн тус хорооны нутаг дэвсгэр 32-33-р байрны голын талбайд тоглоомын талбай бүхий авто машины зогсоолыг “Дайчин Мугсу” ХХК хийж гүйцэтгэж байна.	70.0
Дөрөв. Экологи, байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана.				
162	4.1. Дулааны төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрээр хангах боломжгүй гэр хорооллын айл өрхүүдийг эрчим хүчний хэмнэлттэй зуух, боловсруулсан түлш болон утаа шүүгчээр хангаж халаалтын зуухнуудын тоног төхөөрөмжийг шинэчилнэ.	Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх замаар агаарын бохирдлын хэмжээг бууруулна.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эко орчин бүрдүүлэх чиглэлээр иргэдийн дунд бүсчилсэн сургалтыг 4 удаа зохион байгуулж 2800 иргэнийг хамруулан мод бут, сөөг, зүлэг хэрхэн тарьж ургуулах заавар зааварчилгаа өгсөн. Тайлангийн хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрийн айл өрхүүдийн хашаанд 3100 ширхэг, ААНБ-ын орчинд 2200 ширхэг, нийтийн эзэмшлийн талбайд 7000 ширхэг нийт 12300 ширхэг мод, бут, сөөг тарьж, 99.4 мянган м2 талбайг шинээр буюу нөхөн зүлэгжүүлсэн. Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар 2, 3, 7, 8, 9, 10, 11, 13, 15, 19, 22, 26, 27-р хороодод ногоон байгууламж, тохижилт бүхий бичил цэцэрлэг байгуулсан. Улаанбаатар–Цэвэр агаар төсөлтэй хамтран зуух аваагүй өрхийн бүртгэлийг цахим сүлжээнд оруулах сургалт, зааварчилгааг нийт 22 хороодын иргэдийг хамруулан зохион байгуулан, 9-р сарын 22-26-ны хооронд бүртгэлийн ажил явуулсан. Үүний үр дүнд хязгаарлалтын бүсэд орсон 4884 айл өрх хөнгөлттэй үнээр зуух авах эрх үүссэн. Дүүргийн хэмжээнд 1, 5, 22, 28, 31-р хороодод 5 борлуулалтын цэг ажиллаж, түгээлтийн ажил 10-р сарын 5-наас эхэлсэн. 11-р сарын 25-ны байдлаар 1314 айл өрх зуухаа захиалж авсан. “Хүрд” ХХК-ны Канад усан халаалтын зуухны борлуулалт 11-р сарын 25-ны байдлаар 581 өрхөд суурилуулаад байна. Цахилгааны үнийн хөнгөлтөнд 20427 айл өрх хамрагдлаа.	90.0

163	4.2. Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий талбайд нөхөн сэргээлт, арчилгаа цэвэрлэгээ хийнэ.	Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий тодорхой талбайг нөхөн сэргээх, ойн арчилгаа цэвэрлэгээг хийх талаар мэргэжлийн байгууллагад санал хүргүүлж хамтран ажиллана.	ЗДТГ-ын 3-р сарын 21-ний өдрийн 3/533 дугаар албан бичгээр ойн сан бүхий газрын тодорхой хэсгийг нөхөн сэргээх, ойн арчилгаа цэвэрлэгээг хийх талаар Нийслэлийн Байгаль орчин, Ногоон хөгжлийн газарт санал хүргүүлснээр 21-р хорооны Хөндлөнгийн аманд 50 га газарт "Мон таксаци" ХХК шинээр 2-3 настай нарс, шинэс модны суулгац тарьсан бөгөөд ойжуулалтын ажлын амьдралын хувийг тооцож хүлээн авсан.	90.0
164		Засгийн газрын "Ногоон хэрэм" Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон зурвас байгуулах ажлыг эхлүүлнэ.	Засгийн газрын "Ногоон хэрэм" Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хуучин 22 товчооны орчмын 2 талын аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил газарт 5000 ширхэг хайлаас модыг намрын мод тарилтын өдрүүдэд шинээр тарьж намрын цэнэг усалгааг 1 удаа хийсэн. Нийслэлийн 9.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Туул голын сав дагуу ногоон зурвас байгуулах ажил 4-р сарын 1-ний өдрөөс график хуваарийн дагуу хийгдэж байна.	90.0
165		Газар эзэмшигч, ашиглагч иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын эзэмшлээсээ 50 м хүртэл орчны нийтийн эзэмшлийн газрын тохижилт, цэвэрлэгээ, зам талбай, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг хариуцах үүргийг мөрдүүлнэ.	Дүүргийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр албан даалгаврыг нутаг дэвсгэрийн байгууллага аж ахуйн нэгжүүдэд хүргэн сурталчилж дүүргийн ЗДТГ-ын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс, хороо, аж ахуйн нэгж байгууллагын дарга эрхлэгч нарын гурвалсан гэрээг 1607 аж ахуйн нэгж байгууллагатай байгуулан үйлчилгээний болон тусгай зөвшөөрөл олгох гол үзүүлэлт болгосон. 192 ААНБ-ын тохижилтын ажилтай танилцаж хугацаатай үүрэг даалгавар өгч, тохижилт цэвэрлэгээг хариуцан хийх байршлын зураглалыг баталгаажуулан хүлээлгэн өгсөн.	90.0
166	4.3. Ногоон бүсийн хортон шавьж, өвчний тархалтын судалгаа хийж, хортон шавьж өвчний устгалыг 2000 га талбайд хийнэ.	21, 24, 25-р хороодын ойн сан бүхий газарт ойн хөнөөлт хортон шавьж, өвчний тархалтанд мэргэжлийн байгууллагатай хамтран судалгаа хийнэ.	Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт дүүргийн ЗДТГ-ын Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн даргын 2014 оны 3/532 дугаар албан тоотой ойн сан бүхий газарт хортон шавьжийн өвчний тархалтын талаар судалгаа хийлгүүлэх хүсэлт хүргүүлсэн. Судалгааны дүнд 2015 онд 21-р хорооны Халзангийн давааны орчинд 13 га газарт шавьжны устгал хийхээр болсон.	30.0
167	4.4. Нутаг дэвсгэрийн ногоон бүсийн тодорхой хэсгийг иргэдийн нөхөрлөлд хариуцуулах ажлыг судлан шийдвэрлэнэ.	Ногоон бүсийн тодорхой хэсгийг хамгаалахаар иргэдээс ирүүлсэн санал, санаачлагыг судлан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал оруулан шийдвэрлүүлж, хамтран ажиллана.	Иргэн Баатар, Доржсүрэн, Бямбасүрэн нараас ногоон бүсийн тодорхой хэсгийг хамгаалах зорилго бүхий нөхөрлөл байгуулах санал ирүүлсэн боловч дүүргийн ИТХ иргэдээр нөхөрлөл байгуулан ногоон бүсийг хамгаалуулах шаардлагагүй гэж үзэж шийдвэр гаргаагүй болно. Дүүргийн Засаг даргын 2014 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/120 дугаар захирамжаар Ойн сан	50.0

			бүхий 13 байршилд ногоон бүс хамгаалах зорилго бүхий морин эргүүл ажиллуулсан. Урамшууллыг дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс гэрээгээр олгож байна.	
168		Эзэмшил талбайдаа өөрийн хөрөнгөөр ногоон байгууламж хийж тохижуулсан аж ахуй нэгж байгууллагыг олон нийтэд сурталчлан урамшуулна.	Дүүргийн Засаг даргын 2014 оны А/236 дугаар захирамжаар “Шилдэг ногоон байгууламж”-тай ахмадын зөвлөл шалгаруулах болзолт уралдаан зарлаж 2014 оны 10-р сард дүгнэсэн. Болзлын үзүүлэлтүүдийн дагуу нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж байгууллагуудад ногоон байгууламж шинээр бий болгон арчилж ургуулсан 8 хорооны ахмадын зөвлөлийг шалгаруулан 2.9 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.	70.0
169		Хашаандаа мод бут, сөөг өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан иргэнд урамшил олгох тогтоцоог хэрэгжүүлэн ажиллана.	Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас гаргасан журмын дагуу хашаандаа мод бут, сөөг тарьж 3 жил арчлан тордож ургуулсан гэр хорооллын 74 айл өрхөд нийт 4.0 сая төгрөгийн урамшуулал олгосон.	100.0
170	4.5. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах булаг, шанд, нуурын орчныг тохижуулж,	8-р хорооны Гүнжийн нуур орчмыг сэргээн засварлаж ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэг байгуулна.	Нийслэлийн төсвийн 460, 0 сая төгрөгийн хөрөнгөөр “Гуулин тал” ХХК Гүнжийн нуурыг сэргээн засварлаж хүлээлгэн өгсөн.	100.0
171	хамгаалалтанд авах, ногоон бүс бүхий уулын амуудад байгаль орчны орон тооны бус байцаагчийн тоог нэмэгдүүлнэ	22-р хорооны Бөөрийн булаг орчныг тохижуулж, хамгаалалтанд авна.	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар “ЛХА-АМИР” ХХК Бөөр булгийг хашаа, хайс барьж тохижуулан ашиглалтанд хүлээлгэн өгсөн.	100.0
172		21-р хорооны Өндөрхааны рашаан, 24, 25 дугаар хороодын хилийн зааг Баянхошуу хайрхан, 21 дүгээр хороо Тарвагатайн амны зурвас газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авна.	Дүүргийн ИТХ-ын тогтоолоор Баян хошуу уул 554,1 га, Бумбатын рашаан орчмын 39,21 га, 32-р хороо шинэ товчооноос Эмээлтийн засмал замын урьд 23,0 га, 21-р хороо Өндөр хааны рашаан орчмын 16,3 га газрыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авч хяналт тавин ажиллаж байна.	100.0
173	4.6. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хайрга, шаврын орд ашигладаг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд жилбүр үзлэг, шалгалт явуулан, стандартад нийцэхгүй ордуудын үйл ажиллагааг зогсоох, нөхөн сэргээлийг	Нөхөн сэргээлийн ажлыг үргэлжлүүлэн хийж мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллах, уулын дайрга хууль бусаар ашиглах үйл ажиллагааг таслан зогсоож холбогдох арга хэмжээ авах	Нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэр дээр авто замын хайрга, дайрга, барилгын материал ашиглах явцад эвдэрсэн дараах газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгэсэн. Үүнд: 32-р хорооны нутаг дэвсгэрт “Тэгш плант” ХХК, “Эрдэнэ зам” ХХК, “Анандын зам” ХХК, “Хэрэмт цамхаг” ХХК-д 60,67 га газарт, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Баткубик” ХХК, “Төгс зам” ХХК-д 6,8 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн. “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар Тахилтын амнаас хар шороо авч ашигласан 2,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийлгэж хүлээн авсан. Дүүргийн нутаг	90.0

	тусгай төлөвлөгөөний дагуу хийлгэнэ		дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж байгууллага нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайгаа зориулалтын дагуу ашигласан эсэх, Ашигт малтмалын тухай хуулийн биелэлтийг хангуулах зорилгоор нийслэлийн Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох, тээвэрлэхийг түр хориглох, хүнд даацын автомашины тээвэрлэлтэд тавигдах хяналтыг эрчимжүүлэх тухай” захирамж гарсныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарим аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалтыг хийж дэлгэрэнгүй тайлан мэдээг дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулсан. Дүүргийн 6, 7, 11-р хороодын нутаг дэвсгэр “Найрамдал” шаврын ордод үйл ажиллагаа явуулж байгаа тоосгоны үйлдвэрүүдийн тусгай зөвшөөрлийг цуцалж, үйл ажиллагааг нь 2015 оноос зогсоон хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу ногоон байгууламж барьж эхлэх шийдвэр гараад байна.	
174	4.7. Хөрс, ус, орчны бохирдлыг багасгахад гадаадын төслийн дэмжлэг авч хамтран ажиллана.	“Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	“Эрүүл орчин-эрүүл дүүрэг” хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн А/64 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 33 зорилт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж 12-р сарын 01-ний байдлаар 59 заалт 65 хувьтай хэрэгжиж байна.	70.0
175		Иргэдийн ундны усны хэрэгцээнд ашиглаж байгаа булаг шанд, гүний худгийн усыг шинжилгээнд хамруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа 91 булаг шанд, гүний худгаас дээж авч шинжлүүлж, 15 дүгнэлт, 1 акт, 1 албан шаардлагаар үүрэг өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	90.0
176		Ус түгээх байрнуудын баталгаат байдлыг хангасан байдалд хяналт шалгалт хийж үзүүлэлтийг сайжруулна.	Нийт 52 ус түгээх байруудын уснаас болон савнаас нь дээж авч шинжлүүлж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	90.0
177		Гэр хорооллын хороодын бохирын цооног, 00-ыг ариутгах ажил хэрхэн зохион байгуулагдаж байгаад хяналт хийж, холбогдох арга хэмжээ авна.	Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Эрүүл орчин-эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг бохирын цооногтой болгох зорилгоор “Эрүүл цэвэр орчинд амьдарцгаая” сэдэвт 2.4 сая төгрөгийн шагналын сан бүхий болзолт уралдааныг хороодын хэсгийн ахлагчдын дунд 3 сарын хугацаатай зарлан дүгнэсэн. Энэ хугацаанд 629 өрхөд сурталчилгаа хийн гарын авлага материал тараах ажил	90.0

			хийгдсэнээс 437 өрхийг шинээр бохирын цооногтой болгосон байна. Нутаг дэвсгэрээс 10 цэг сонгон хөрснөөс дээж авч шинжлүүлэн үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Гэр хорооллын хороодын бохирын цооног, аж ахуйн нэгж байгууллагуудын ахуйн шавьж мэрэгч устгах, ариутгал халдваргүйтгэл хийлгэх ажлыг ариутгал халдваргүйтгэлийн байгууллагуудтай гэрээ хийн ажилласнаар 15200 өрхийн бохирын цооногт ариутгал халдваргүйтэл хийсэн байна.	
178		Зуслан, ногоон бүсийн айл өрхийн жорлон, муу усны нүхийг ариутган хөрсийг халдваргүйжүүлэх ажлыг хийнэ.	Зуслан, ногоон бүсийн хур болон үүсмэл хог хаягдлыг цэвэрлэх ажлыг Эко бүлгийн 20 гишүүн хийж гүйцэтгэн, хөрсийг ариутган халдваргүйжүүлэх, жорлон муу усны нүхийг ариутгах ажлын хүрээнд Толгойтын Зүүн салааны зуслангийн 723 өрхийн жорлон муу усны цооногт ариутгал халдваргүйтгэл хийгдсэн.	90.0
179		Зуслангийн хог хаягдлын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах зорилгоор “Өрх бүрт-ногоон карт, Ам бүрт-эко үйлчлэгч” менежментийг хэрэгжүүлж эхлүүлнэ.	Засгийн газрын “Эзэнтэй Монгол” хөтөлбөр, дүүргийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 24, 25-р хорооны нутаг дэвсгэрийн ойн сан бүхий зуслан, ногоон бүсийн хог хаягдлын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах зорилгоор Толгойтын Зүүн, Баруун салааны зусланд тус бүр 10 иргэнийг түр ажлын байраар ханган Эко бүлэг болгон 6-р сарын 15-наас 9-р сарын 15-ны хооронд 3 сарын хугацаатайгаар урамшуулал олгуулан хамтран ажилласан. Эко бүлгийн гишүүд ажиллах хугацаандаа 45 рейсээр 232.0 тн үүсмэл хог хаягдлыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулсан.	100.0
180	4.8. Хог хаягдлыг тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, Тээвэрлэлт	Тээвэрлэлт үйлчилгээний төвийн гражийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилт, улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2015-2017 онд хэрэгжүүлэх ажлын саналд /0.5 тэрбум төгрөг/тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1020, 1/1026 тоот албан бичгээр нийслэлийн Засаг дарга, НЗДТГ-т хүргүүлсэн болно.	30.0
181	үйлчилгээний төв, Нийтлэг үйлчилгээний төв, Тохжилт үйлчилгээний компанийн материаллаг баазыг нэмэгдүүлэн хур хогийн цэггүй дүүрэг болно.	Хог тээврийн болон авто зам цэвэрлэгээ арчилгааны тусгай зориулалтын техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлыг тээвэрлэх орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын автопаркын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зориулалтын Nissan hino маркын хог тээврийн автомашин 2, жижиг оврын трактор 1-ийг Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлээс, LG933L маркын ковш 1-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр авсан.	100.0
182		Гэр хорооллын айл өрхийн хогийг сард 2 удаа хашаанаас нь авах ажлыг	Гэр хорооллын 1, 2, 3, 4, 5, 6, 8, 9, 10, 11, 20, 22, 23, 24, 26, 27, 28, 30, 31-р хороодын айл өрхийн хог хаягдлыг сард 2 удаа, 7, 25-р	90.0

	хэвшүүлнэ. /21-р хороо Жаргалант тосгоныг хамруулна/	хороодын хог хаягдлыг сард 1 удаагийн давтамжтайгаар авч хэвшсэн. 21-р хороо Жаргалант тосгоны 361-р гарамын үүсмэл болон хур хог хаягдлыг цэвэрлэн 302 рейсээр 2697,7 тн хог хаягдлыг Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хүргэсэн. 361 гарамын өрхийн хог хаягдлыг ТЦҮ ОНӨААТҮГ авч байна.	
183	Хог хаягдал үүсдэг хогийн цэгүүдийг камержуулж эхлүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн зам талбайд нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийгдэх камержуулалтын ажлыг байршуулах холбогдох судалгааны ажил хийгдэж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Энэ ажлын хүрээнд хог хаягдал үүсдэг болон үүсч болзошгүй цэгүүдийн судалгаа гарган 20 хорооны 32 цэгийг камержуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.	70.0
184	Хог хаяхгүй байх ухамсрыг төлөвшүүлэх талаар иргэд олон нийт, хувийн хэвшлийнхэнд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион явуулна.	Хороодын Засаг дарга, хэсгийн ахлагчдын дунд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэстэй хамтран “Сонгинохайрхан дүүргийн хатуу хог хаягдлын менежмент” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтаар хог хаягдлын чиглэлээр нийслэлийн хэмжээнд баримталж буй бодлого, дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлыг хэрхэн ачиж тээвэрлэж байгаа байдал, хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд хороодын Засаг дарга, хэсгийн ахлагчдын оролцооны талаар мэдээлэл өгсөн. Дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр, дүүргийн Засаг даргын санаачлагаар хэрэгжүүлж буй “Хотын соёл” төслийг 2014 оны 5-р сараас эхлэн хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 1. Санаачлагын тугийг нийт 30 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжид аялуулсан. Санаачлагын тугийг авсан аж ахуйн нэгж байгууллагууд байгууллагын орчмын цэвэрлэгээ, тохижилтын ажил хийхээс гадна иргэд олон нийтэд хог хаяхгүй байх сургалт сурталчилгааг хийсэн. 2. Хотын соёл танаас эхтэй шторк бэлтгэн дүүргийн сурталчилгааны дэлгэцээр сурталчилгааг иргэдэд байнга хийж байна.	100.0

			<p>3. “Хогоо хаяна гэхдээ саванд”, “Үнс угаадсаа асгахгүй, орц гудамжинд шээхгүй” зэрэг хэвлэмэл хуудас 500 ширхгийг хэвлэн иргэдэд тараасан.</p> <p>4. Мандах, Чингэс СООСЭ дээд сургууль, ЕБС-ийн сурагчдад “Хотын соёл танаас эхэлнэ” сэдэвт илтгэл, хэлэлцүүлэг хийсэн. Нийт 8 удаагийн хэлэлцүүлэгт Ерөнхий боловсролын 23 сургуулийн 2200 гаруй сурагч, их дээд сургуулийн 600 гаруй оюутан залуус оролцсон.</p> <p>5. Оюутан залуучуудын дунд “Хоггүй наадацаа” сэдэвт нийтийг хамарсан ажлыг зохион байгуулан 300 гаруй залуус оролцон Туул голын сав газрыг цэвэрлэн 6 телевиз, 5 сайт, 2 сонингоор сурталчилгаа хийсэн.</p> <p>6. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Хотын соёл надаас эхэлнэ” эссэ бичлэгийн уралдаан зарлан дүгнэсэн</p> <p>7. 107-р сургуулийн 5-р ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, 67-р сургуулийн 3-р ангийн сурагчдын дунд “нэг чихэр-нэг хог” ярилцлага зохион байгуулсан.</p> <p>8. Хог хаяхгүй байх ухамсрыг төлөвшүүлэх сургалтыг цэцэрлэгүүдийн сургалтын хөтөлбөрт оруулан хүүхэд багачуудад заах ажил хийгдэж байна.</p>	
Тав. Нутгийн захиргааны байгууллагын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоно.				
185	5.1. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод байлган, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэн, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрт иргэдийн санал бодлыг тусган хэрэгжүүлж, төрийн боломжит зарим үйлчилгээг төрийн бус	2, 11, 13, 16, 20, 24, 25, 30-р хороодод иргэний танхим байгуулан тохижуулна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2, 11, 12, 14, 13, 16, 20, 24, 25, 30-р хороод 106.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр иргэний танхимаа тохижуулсан.	90.0
186		10.0 мянгаас дээш хүн амтай хороодын хилийн заагийг шинэчлэх, хороо хуваах эсэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран санал, дүгнэлт боловсруулж уламжилна.	1, 2, 3, 7, 23, 24, 25, 26-р хороодын хүн ам 10.0-15.0 мянгад хүрч иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээнд хүндрэл гарч байгаа тул ажлын ачааллыг багасгах талаар хороо хуваах тооцоо, судалгаа гаргаж, саналыг албан бичгээр дүүргийн ИТХ-ын Ажлын албанд хүргүүлсэн.	90.0
187		Эрүүл аюулгүй байдлын индексийг хороодын түвшинд гарган нэгтгэж, дүүргийн эрүүл аюулгүй байдлын индексийн түвшинг сайжруулна.	2013 оны ЭАБИ-ийн мэдээллийг хороо бүрээр гаргуулан нэгтгэж, мэдээллийг НЗДТГазарт хүргүүлэн ажиллаж байна. 2014 оны мэдээлэл 12-р сарын 05-ны өдрөөс 2015 оны 02-р сарын 20-ны хугацаанд бүрэн гарч дуусахаар байна. Эрүүл аюулгүй байдлын	90.0

	байгууллагуудаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлан ажиллана.		индексийн үзүүлэлтийг сайжруулах ажлыг Тамгын газрын хэлтэс, дэргэдэх хэлтэс албадын дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээ, хороодын Засаг дарга нарын “Батламж” гэрээнд тусган ажиллаж байна. Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох ажлын хүрээнд “Хариу арга хэмжээний төлөвлөлт хийх” сургалтыг 2-р сард 32 хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн 96 ажилтныг хамруулан зохион байгуулж үзүүлэлтийг сайжруулах төлөвлөгөөг хороо бүр гарган ажиллаж үй ажиллагаандаа тусган ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/633 дугаар захирамжаар батлагдсан “Шинэ маягт”-ын сургалтыг 9-р сард 64 ажилтанд, олон нийтийг идэвхжүүлэх, хороодын ажилтнуудыг чадваржуулах сургалтыг 11-р сарын 6-наас 12-р сарын 3-ны хугацаанд 12 удаа тус тус зохион байгуулж хороодын 109 ажилтнуудыг хамруулаад байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Мэдээлэл технологийн газартай хамтран мэдээллийн программын сургалтанд хороодын нийгмийн ажилтнуудыг хамруулан 2013 оны эрүүл аюулгүй байдлын мэдээллийг 80%-тай шивж оруулаад байна.	
188		Нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх, төр болон хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлно.	Дүүргийн хүн амд сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, түр байрлуулан асрамжлах үйлчилгээ, сургалтын үйлчилгээ, тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх, түр хоноглох үйлчилгээ, гэрийн асрамж, халамж үйлчилгээ, тэнэмэл иргэдэд халуун хоол, цайгаар үйлчлэх үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр 17 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж, 5302 иргэнийг хамруулан, 965.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Бүгд найрамдах Солонгос улсын хөрөнгө оруулалттай “Самдун интернеишнл” ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, амьжиргааны түвшин доогуур, ажил хөдөлмөр эрхлээгүй 80 иргэнийг суралцуулан мэргэжил эзэмшиж төгссөн. 2 дахь ээлжийн сургалтад 60 иргэн суралцаж байна. “Сэтгэлийн анир” ТББ-тай хамтран хороодын нийгмийн ажилтнуудад чадваржуулах сургалтыг 2014 оны 4-р сард, архи их хэмжээгээр хэрэглэдэг, архинд хамааралтай иргэдэд чиглэсэн сургалтыг 5-р сараас эхлэн 32 хороонд тус тус зохион байгууллаа.	90.0

189	Дүүргийн хөгжлийн талаарх иргэн, аж ахуйн нэгжийн үр ашигтай санал санаачлагыг дэмжин ажиллана	Дүүргийнхээ хөгжилд хувь нэмрээ оруулахаар иргэдийн бүлэг байгуулан тохижилт бүтээн байгуулалтын ажилд оролцохоор санал, хүсэлтээ ирүүлсэн иргэдийн 93 бүлгийг бүртгэн 346.1 сая төгрөгийн өртөгтэй 19 ажлыг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж 16 иргэдийн бүлэг 329.1 сая төгрөгөөр тохижилтын ажлын гүйцэтгэж 111 хүн түр ажлын байраар хангагдсан байна. 17-р хорооны иргэд далд авто зогсоол бариулах санал гаргасныг дэмжин иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, 32-33-р байрны голын талбайд тоглоомын талбай бүхий авто машины зогсоолыг “Дайчин Мугсу” ХХК хийж гүйцэтгэж байна.	100.0
190	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх хөдөлгөөнт машинаар алслагдсан байршлын иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлнэ.	Хөдөлгөөнт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зориулалтаар тоногдсон автомашин хөрөнгийн асуудлаар “Швейцарийн хөгжлийн агентлаг”, “Хүний аюулгүй байдлын судалгааны төв”-д албан тоотоор хүсэлт тавьсан боловч тус байгууллагаас боломжгүй гэсэн хариу ирсэн.	30.0
191	Хороодод төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинтай болох асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилна	2013 оны байдлаар дүүргийн хэмжээнд 4 ширхэг ТҮЦ машин ажиллаж байсан бөгөөд 2014 онд холбогдох байгууллагуудад уламжилснаар нэмж 6 байршилд суурилуулан одоогоор нийт 10 ТҮЦ машин дүүргийн хэмжээнд байршаад байна.	100.0
192	2, 3, 4, 6, 7, 8, 9, 10, 19, 20, 21 дугаар хороодын иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цонхны хэлбэрт бүрэн шилжүүлнэ.	2, 3, 4, 6, 8, 9, 10, 13, 14, 16, 23, 25, 26, 27, 28, 31, 32-р хороодыг нэг цонхны үйлчилгээний хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна. 5, 8, 19, 20, 21, 22-р хороодод тавилга шинэчлэхэд 22,1 сая төгрөг, 7, 19, 20, 21-р хороодод үйлчилгээний заалны багтаамж нэмэх, барилгын засвар хийхэд 25,6 сая төгрөг, 32 хороог урсдаг мэдээллийн самбартай болгоход 18,9 сая төгрөг, бүх хороог скайнертай болгоход 4,2 сая төгрөг нийт 70,8 сая төгрөгийн санхүүжилтийн асуудал шийдэгдэж тендер нь зарлагдсан.	90.0
193	Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын хүрээнд дүүргийн мэдээллийн суваг бий болгоно.	Тоног төхөөрөмжийн судалгаа, үнийн саналыг гарган, шаардагдах төсвийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 52.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар дэмжигдсэн.	50.0

194	5.2. Шинээр дүүрэг байгуулах асуудлыг боловсруулан саналыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.	Дүүрэг хуваах замаар төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай, ил тод, хүртээмжтэй хүргэх боломжийг судлан, дүгнэлт гаргаж дээд байгууллагад хүргүүлнэ.	Дүүрэг хуваах асуудлыг дэмжих эсэх талаар 32 хорооны 31.4 мянга орчим иргэдийн дунд асуулга зохион байгуулахад 74.8 % нь тийм, 25.2 хувь нь үгүй гэсэн санал өгсөн байна. Шинээр дүүрэг байгуулахад шаардагдах төсөв зардлын тооцоо, өрх, хүн амын тоог харгалзан 2 хувилбар боловсруулан дүүргийн ИТХ-ын Ажлын албанд хүргүүлсэн.	90.0
195	5.3. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ.	Төрийн үйлчилгээний нэг цонхны цахим мэдээллийн систем суурилуулна.	Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль болон бусад холбогдох хууль журмуудыг хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг шуурхай хялбар авахад чиглэгдсэн төрийн үйлчилгээний нэг цонхны цахим мэдээллийн систем бүхий ухаалаг дэлгэцийг ЗДТГ-ын үүдний танхимд байршуулсан. Тус самбараас иргэд дүүргийн ЗДТГ болон дэргэдэх хэлтэс албадын хаяг, утасны дугаар, үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын жагсаалт зэрэг бүхий л мэдээллийг авахаас гадна, өргөдөл гомдол санал хүсэлтээ тус дэлгэцийг ашиглан илгээх боломжтой юм.	100.0
196		Хороодыг өндөр хурдны шилэн кабельд холбох ажлыг үргэлжлүүлнэ.	1, 2, 3, 5, 7, 8, 9, 10, 11, 22, 23, 25, 28, 29-р хороодын шилэн кабелийн засварын, 21, 24,26,32-р хороодын шинээр шилэн кабель татах судалгаануудыг нэгтгэн нийслэлийн Мэдээллийн технологийн газарт хүргүүлснээр дээрх 14 хорооны шилэн кабелийн сүлжээний засварын ажлын зардалд 25.0 сая, 24, 26, 32-р хороодод шинээр сүлжээ татах ажлын зардалд 84.0 сая төгрөгийг нийслэлийн Засаг даргын 2014 оны А/133 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Шинээр шилэн кабель татах ажлыг “Юнител ком” ХХК шалгаран хийж гүйцэтгэсэн бөгөөд 11-р сард хүлээлгэн өгсөн байна. Засварлах тендерт “МТМК” ХХК шалгаран 11-р сарын 25-ны байдлаар нийт 14 хорооноос 10 хороог хүлээлгэн өгсөн байна. 4 хороо буюу 9, 10, 11, 28-р хороод нь Баянхошууны зам засварын ажил болон гэрэлтүүлгийн ажил дууссаны дараа шилэн кабель татах ажлыг хийж гүйцэтгэнэ. Одоогийн байдлаар шилэн кабельд холбогдоогүй 3, 9, 10, 11-р хороо нь Жи мобайл компанийн ADU 310 модемоор, 2-р хороо нь скайнет модемоор, 28-р хороо нь газар нутгийн бүсээс шалтгаалан Улуснет компанийн модемыг тус тус ашиглан интернэтийн сүлжээнд холбогдож байна.	70.0

			Нийт 32 хорооноос : Шилэн кабельтай : 23 Шилэн кабельтай боловч ашиглалтанд ороогүй байгаа: 2 /2,3 дугаар хороод шинэ байр руу нь шилэн кабель татагдсан байна/ Шилэн кабельгүй: 7 /9, 10, 11, 21, 28, 30, 31/ Wireless хүлээн авагчаар интернэтэд холбогддог : 2 /30, 31/ тус тус байна.	
197	21-р хороо Жаргалант тосгоныг интернетийн сүлжээнд холбох асуудлыг судлан холбогдох арга хэмжээг авна	21-р хороо буюу Жаргалант тосгоныг нэгдсэн сүлжээнд холбох, шинээр шилэн кабель татах судалгааг нэгтгэн Нийслэлийн мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Тус хороо хэт алслагдсан бөгөөд хамгийн ойр орших 32-р хорооны байрнаас 40 километр бөгөөд 120.0 орчим сая төгрөг шаардлагатай нь нийслэлийн Мэдээллийн технологийн газрын 2014, 2015 оны төсөвт тусгагдаагүй. Улаанбаатар төмөр замын холбоо дамжуулахын 2-р ангийн шугамнаас интернэт авах боломжийг судалсан. Тус ангиас шилэн кабель татахад мөн 80.0 гаруй сая төгрөг төсөв шаардлагатай байна.	30.0	
198	Мобайл технологид суурилсан "Ухаалаг СХД" программ хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлнэ	Монголд мобайл технологи хөгжүүлдэг албан байгууллагын судалгааг гарган 4 компанитай уулзалт хийсэн. Эдгээр 4 компани дотроос урьд хийж байсан ажлын туршлага, үнийн санал зэргийг харгалзан "ЭнБиЭмБи" компаниар хийлгэхээр болсон. Тус портал системийг Андроид үйлдлийн системд суурилан хийх бөгөөд программ бичилтийн ажил явагдаж байна. Тус компанитай хийсэн ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэж өгнө.	90.0	
199	Засаг даргын Тамгын газрын дотоод сүлжээг бүрэн шинэчилнэ.	ЗДТГ-ын байрны дотоод сүлжээний бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх ажлын хүрээнд дотоод сүлжээний план зураг, техник хэрэгсэл, материалын бүрдэл зэргийн судалгааг гаргаад байна.	50.0	
200	Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч утасгүй интернэтийн бүсүүдийг бий болгоно.	Утасгүй интернэтийн үйлчилгээ явуулдаг "Кевико" ХХК-д 2014 онд дүүргийн нутаг дэвсгэрт суурилуулах утасгүй интернетийн бүсийг нэмэгдүүлэх талаар санал тавин 12 байршилд суурилуулах судалгааг гаргаж өгсөнөөр тус компаниас 8 бүсэд WIFI төхөөрөмж суурилуулсан байна. Түүнчлэн нийслэлийн Мэдээллийн технологийн газар Канадын компанитай хамтарч утасгүй интернэтийн бүс үүсгэх төслийг хэрэгжүүлэхээр болсон ба дүүрэгт 2014 онд 4 бүс, цаашдаа жил бүр 2-3 бүс шинээр үүсгэж,	90.0	

			ашиглалт үйлчилгээг дүүргээс хариуцан ажиллахаар болсон. Утасгүй интернэтийн бүс үүсгэх байршлын саналыг 32 хороодод санал асуулга явуулан хариуг албан бичгээр хүлээн авсан бөгөөд саналыг нэгтгэн нийслэлийн Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. 14-р хорооны Соёмбо кинотеатрын гадна талбай, 29-р хорооны Драгон авто вокзал, 27-р хорооны ЗДТГ-ын гадна талбай, 6-р хорооны эцсийн буудал зэрэг 4 бүс сонгогдсон байна. Төслийн эхний шат буюу судалгааны ажил 2014 оны турш хийгдэхээр болж хойшилсон бөгөөд 2-р шат буюу суурилуулах ажил 2015 оны эхний улирлаас эхлэн хийгдэнэ.	
201	Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг цахим хэлбэрээр хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч, шуурхай хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр явуулна.	Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг цахим хэлбэрээр хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авахад Тамгын газрын эд хогшлийн зардалын сангаас 3.4 сая төгрөгийг зарцуулсан. Жи Мобайл компанийн MF-70 өндөр хурдны модем-150.0 мян төгрөг , С920 суурин хөлийн хамт, С310, С270 зэрэг камеруудыг 3.3 сая төгрөгөөр худалдан авсан. 4-р сарын 24-нд гамшгаас хамгаалах сургалтын үеэр 32 хороо болон дэргэдэх хэлтсүүдтэй цахимаар видео хурал хийсэн. Тоног төхөөрөмж болон программ нь хэвийн ажиллагаатай байна.	100.0	
202	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахимжуулж дуусган, лавлагааг ТҮЦ машинаас олгож эхэлнэ.	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 61.0 мян хувийн хэргийг бүрэн цахимжуулж лавлагааг 10 ТҮЦ машинаар олгож байна.	100.0	

203	5.4. Дүүргийн нутгийн захиргааны ордон барина.	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авна	Нутгийн захиргааны ордон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр дүүргийн Засаг даргын 2014 оны 1/1047, 2015-2017 оны хөрөнгө оруулалтын ажлын саналд тусгуулахаар дүүргийн Засаг даргын 1/1029 тоотуудыг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/406 дугаар захирамжаар Цагдаагийн 1-р хэлтсийн түр саатуулах байр байгаа 0,1 га газрыг дүүргийн нутгийн захиргааны ордон барих зориулалтаар Тамгын газарт эзэмшүүлсэн байна. Уг байрны зураг, төсөв хийлгэх зардал 200.0 сая төгрөгийг нийслэлийн төсвийн тодотголоор батлуулан, зураг, төсвийг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын 2014 оны А/207 дугаар захирамжаар байгуулан тендер зарласан байна.	90.0
204	5.5. Бүх хороодыг цогцолбор байртай болгоно.	6, 8, 16, 21-р хороонд шинээр цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.	6, 8, 16-р хороодын цогцолбор байр барих саналыг нийслэлийн 2015 оны эдийн засаг, нийгмийн зорилтод тусгуулахаар Засаг даргын 1/1020 албан тоотуудыг нийслэлийн ЗДТГ-т хүргүүлсэн. 8-р хорооны хашаанд Баянхошуу дэд төв төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр цогцолбор байрыг барихаар шийдвэрлэсэн.	50.0
205		2, 3, 9, 10, 11 дүгээр хорооны цогцолборыг ашиглалтад оруулна.	3, 9, 11-р хороодын байрны барилгын гүйцэтгэл 70-90 хувьтай, гаднах тохижилтын ажил хийгдэж байна. 2,10-р хороодын байр 12-р сард ашиглалтанд орно.	70.0
206	5.6. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх талаар сургалт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Албан хаагчдыг мэргэшүүлэх, урт, богино хугацааны гадаад, дотоодын сургалтанд хамруулна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 5 мэргэжилтэнг гадаадад мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтанд, дотоодын богино хугацааны сургалтанд 40 төрийн албан хаагчдыг тус тус хамруулсан. Давхардсан тоогоор 150 төрийн албан хаагчдыг богино хугацааны болон мэргэшүүлэх сургалтанд сургасан байна.	90.0
207		Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх ажлыг зохион байгуулна.	Нийт 146 төрийн жинхэнэ албан хаагчдын хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч бүртгэн www.meduuleg.iaac.mn сайтад байршуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 96 албан хаагчаас хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөөний дагуу албан хаагчдыг 6 удаагийн сургалтанд хамруулсан.	100,0

208		Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх дүүргийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 17 албан хаагчдад буцалтгүй тусламж олгосон, Засаг даргын Тамгын газрын болон хороодын 162 албан хаагчдыг түлээ нүүрсний хөнгөлөлт хамруулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 65 албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцжуулах гэрээг “Номтын ам” ХХК-тай байгуулж, барилгын гүйцэтгэлийн ажил 70%-тай явагдаж байна.	70.0
209		Дүүргийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж ажилтан, албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрмэлзэх 9 зүйлийг Тамгын газар, хороодын албан хаагчдын ажлын өрөөнд болон дүүргийн цахим хуудсанд тус тус байршуулсан. Ёс зүйн зөрчил гаргасан гэх 8 төрийн албан хаагчтай холбоотой асуудлыг дүүргийн ёс зүйн зөвлөл болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын орон тооны бус ёс зүйн хорооны 3 удаагийн хурлаар авч хэлэлцэн холбогдох арга хэмжээ авч ажилласан. Албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэдийн 42 өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн холбогдох арга хэмжээ авч, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 12 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан. 2014 оны 1-р улиралд Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн манлайлал, үр дүнгийн гэрээ байгуулах” сэдвээр сургалт зохион байгуулсан.	100.0
210	5.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, дээрх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэмт хэрэг ихээр гардаг гэр хорооллыг телекамерын системд хамруулна.	1.6 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвтэй камержуулалтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын А/141, камерын байршлыг нягтлан тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийг А/168 дугаар захирамжаар тус тус байгуулан ажиллаа. Ажлын хэсэг мэргэжлийн байгууллагатай хамтран нийт 84 байршилд чиглэлийн 165, үүнээс 16 нь автомашины улсын дугаар илрүүлэгчтэй, эргэдэг 20 камерыг суурилуулахаар тогтсон байна. “Миротек” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулагдсан.	70.0
211		Авлига, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор улс, дүүрэгтэй хамтын ажиллагаатай гадаад	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг “Нээлттэй Улаанбаатар-2014” авлигын эсрэг олон улсын форум, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Авлигатай	30.0

	орнуудын туршлага судлах сургалтанд албан хаагчдыг хамруулна.	тэмцэх газар, Азийн сантай хамтарсан “Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” сэдэвт онол-практикийн хурал, “Хар тамхи мансууруулах бодисын эсрэг бидний оролцоо”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил ба ил тод байдал”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, сонирхлын зөрчил, авлигын эсрэг хууль тогтоомж” зэрэг сэдэвт гадаад орны туршлага судлах сургалтанд хамруулсан. Авлига, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр, туршлага судлах сургалтанд албан хаагчдыг хамруулах талаар Японы Шизүока мужийн Изүнокүни хоттой хамтын ажиллагаа тогтоох санамж бичигт тусган ажиллаж байна.	
212	Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, оюутан залуусын дунд “Бид мансуурлын эсрэг” аяныг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилна.	Ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах, төгсөх ангийн нийт 500 сурагчид болон “Ирээдүй цогцолбор”, 42-р дунд сургуулийн 120 өсвөр насны хөвгүүдэд “Мансууралгүй ирээдүй” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. “Хар тамхи, мансууруулах бодис түүний хор уршиг” сэдэвт сургалтыг 9, 67, 76, 105-р сургуулийн 9-11-р ангийн 11 бүлгийн 520 сурагчдад зохион байгуулсан. Сургалтаар архи тамхи, мансууруулах эм, бодисын зүй бус хэрэглээ, түүний хор уршгаас урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдээлэл өгсөн. Мансууруулах бодис, газ, цавуу зэрэг үнэрт бодисыг хэрэглэн мансуурахаас сэргийлэх, хор нөлөөг таниулах зорилго бүхий сургалтыг нийт 8 сургуулийн 1860 өсвөр насныханд явуулж, 3200 сурталчилгааны материал тараасан.	90.0
213	Архины хамааралтай иргэдэд зориулсан эмчилгээ, сувилгааны төв байгуулах төсөл боловсруулж донор байгууллагуудад илгээнэ	Архины хамааралтай иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны төслийг боловсруулж “Ерөөгдсөн гэр бүл” ТББ төвтэй хамтран архинд хамааралтай иргэдэд вакумжуулсан сургалтыг зохион байгуулж байна. ТББ-ын үйл ажиллгааг дэмжин ЗДТГ-аас гэр олгосон.	70.0
214	Хорихоос өөр төрлийн ялтай болон хугацаанаас өмнө суллагдсан, тэнсэн харгалзах ялтай иргэдийн нийгэмших, хөдөлмөр эрхлэх явцад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.	Хорих газраас суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 256 иргэдийн судалгааг гарган дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлсэн. Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгөх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, нийгэмшүүлэх, ажил хөдөлмөрт зуучлах зорилгоор хорих газраас суллагдсан, хяналтанд байдаг 123 иргэнд “Хорих газраас суллагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжье” “Иргэн-нийгэмшил” зэрэг уулзалт өдөрлөгүүдийг зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулгын ажлыг	90.0

			хийсэн. 2014 оны 1-р улиралд орон нутгийн онцлогт нийцсэн “Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй иргэдийг хөдөлмөр, сургалтаар төлөвшүүлэх нь” сэдэвт шинэ төсөл хөтөлбөрийг хэлэлцүүлэн баталсан. 2014 онд хорихоос суллагдсан 65 иргэнийг хөдөлмөр эрхлүүлэх сургалтанд оролцуулж 9 иргэнийг ажлын байраар хангасан.	
215	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахиулах эргүүл, хяналтын ажилд иргэд, олон нийтийн оролцоог ханган, гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, илрүүлэлтийн түвшинг дээшлүүнэ.	Дүүргийн хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтнуудын дунд “Цагдаагийн албаны хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг дүүргийн ИТХ-ын Ажлын алба, хууль, хяналтын байгууллага, хороодын Засаг дарга нарыг оролцуулан зохион байгууллаа. Дүүргийн гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээг удирдах ажилтнуудад шуурхай зөвлөгөөний үеэр 14 хоног тутам мэдээлж, гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах талаар хийсэн ажил болон хийх ажлын саналаа танилцуулан ажилласан. Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны А/11 дүгээр тогтоол, Засаг даргын 2014 оны 374 дүгээр захирамжийн дагуу 32 хорооны 83 чиглэлд 258 төрийн албан хаагчдыг нийтийн эргүүлд 2014 оны 10,11-р сард гарган, нийт 108 зөрчил илрүүлэн, зөрчил гаргасан 5 аж ахуйн нэгж, 87 иргэнийг холбогдох хуулийн дагуу 580.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. “Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хамтдаа” уралдааныг нийт 13 хороонд зохион байгууллаа. Дүүргийн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд 25 удаа үнэлэлт дүгнэлт хийн, холбогдох газарт танилцуулж, “Гэр бүлийн хохирогчдод өгөх зөвлөмж” 1000 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, хороод, олон нийтийн газар байршуулан ажиллав. Үер ус, галын аюул, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэрэмжлүүлэг”, “Зөвлөмж”, “Орон байр” “Сэргийлцгээе”, “Хараа хяналт” зэрэг 28 хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулав.	90.0	
216	Цагдаагийн хэлтсийн барилгын өргөтгөлийг дуусгана.	Цагдаагийн 1-р хэлтсийн өргөтгөлийн барилгын ажлыг “ЭЭН” ХХК нь 2014 оны 08-р сарын 15-нд дуусгаж, хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулан ажилласан боловч хугацаандаа өгөөгүйгээс ЦЕГ-аас тус компанитай байгуулсан гэрээг цуцалж, гэрээний хугацаа хэтрүүлсэн алдангид 83.5 сая төгрөгийн торгууль тавьсан. ЦЕГ-аас дахин зарласан тендерт “Зоригдархан” ХХК шалгаран гэрээ	90.0	

			хийж, гэрээнд заасны дагуу барилгын өргөтгөлийг 2014 оны 4-р улиралд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Тус компани улсын төсвөөс 175.0 сая төгрөгийн санхүүжилт авсан ба барилгын ажлын явц 90 хувьтай байна.	
217	12, 21-р хороонд Цагдаагийн кабон шинээр байгуулах асуудлаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлнэ.	Саппоро” үйлчилгээний төв, Толгойтын автобусны эцсийн буудал, 21-р хороо 361 гарам, Эмээлт түүхий эдийн захын ойр орчимд иргэдэд үйлчлэх төв бариулах саналыг нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12, 21-р хороонд баригдах тус бүр нь 61.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 цагдаагийн кабоныг цагдаагийн газраас ирүүлсэн зургийн дагуу дүүргийн Засаг даргын А/152 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулан зөвлөх үйлчилгээний тендер зарласан. Нийслэлийн ЗДТГ-ын 05/2848 тоот албан бичгийн дагуу 12-р хороонд баригдахаар төлөвлөгдөж байсан кабоны худалдан авах ажиллагааг зогсоосон бөгөөд 21-р хорооны кабоны зураг шаардлага хангаагүй тул зогсоосон.	70.0	
218	Саппоро үйлчилгээний төв орчимд хууль бус ажил үйлчилгээ эрхлэгчдийн асуудлыг таслан зогсооно.	Дүүргийн Засаг даргын Тамгын газраас мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2 удаа шалгалт явуулж арга хэмжээ авч ажиллаж байна. Биеэ үнэлэгч 20 эмэгтэйд “Сэтгэл амар” төв “Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг”-тэй хамтран, “Охид эмэгтэйчүүдийн дотно сэдэв” өдөрлөг, сургалтыг зохион байгуулж, 13 төрлийн зөвлөмжийг тараав. 12-р сарын 01-ний өдрөөс дүүргийн Засаг даргын 436 дугаар захирамжийн дагуу удирдамж төлөвлөгөө боловсруулан НЦГ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран Саппоро төв орчмоор Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийг зөрчин биеэ үнэлдэг иргэд, зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, гар дээрээс наймаа эрхэлдэг иргэдийг журамлах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулаад байна.	70.0	
219	1-р хорооллын арын зам дагуух зочид буудлуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/448 дугаар захирамжийн хүрээнд 13-р хорооны нутаг дэвсгэр 1-р хорооллын арын зам дагуу үйл ажиллагаа явуулдаг 14 зочид /дэн/ буудалд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, стандартын шаардлага хангаагүй 9 дэн буудлын ус, тогны хязгаарлалтыг тавьж үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан.	90.0	

220		Гэмт хэрэг ихээр гардаг орон сууцны болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж талбайг телекамерын системд хамруулна.	1.6 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвтэй камержуулалтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын А/141, камерын байршлыг нягтлан тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийг А/168 дугаар захирамжаар тус тус байгуулан ажиллаа. Ажлын хэсэг мэргэжлийн байгууллагатай хамтран нийт 84 байршилд чиглэлийн 165, үүнээс 16 нь автомашины улсын дугаар илрүүлэгчтэй, эргэдэг 20 камерыг суурилуулахаар тогтсон байна. “Миротек” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулагдсан.	70.0
221	5.8. “Архигүй баасан гараг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	“Архигүй Баасан гариг” хөтөлбөрийн 1-р үе шатыг хэрэгжүүлнэ.	“Архигүй баасан гараг” дэд хөтөлбөрийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2014 оны А/95 дугаар захирамжаар томилж 2014 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг 5 бүлэг, 25 заалттайгаар боловсруулж, батлуулсан. Дүүргийн хэмжээнд архинд хамааралтай 857 иргэдийн судалгааг гаргаж нэгтгэсэн. “Архигүй баасан гараг” дэд хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран 2-р сард нутаг дэвсгэрийн 300 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан сургалт зохион байгуулж, эмхэтгэл 500 ширхэгийг хэвлүүлэн тараасан. Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд архи, тамхины хор хөнөөлийг ойлгуулан таниулах, эрүүл зөв хооллолт, аюулгүй хүнсний хэрэглээг төлөвшүүлэх, залуучуудын чөлөөт цагийг зөв, боловсон өнгөрүүлэх зорилгоор “Сүүтэй бялуутай үдэш” аяны нээлтийн ажиллагааг 10-р сарын 22-нд Цамбагаравын Рокси диско бааранд зохион байгууллаа. Уг ажиллагаанд дүүргийн удирдлагууд, Мандах бүртгэл дээд сургуулийн 63 оюутан, багш нар оролцлоо Аяны нэрэмжит шилжин явах тугийг аж ахуйн нэгжүүдээр аялуулж байна. “Согтууруулах ундааны хяналтын тухай хууль”-ийн нээлттэй хэлэлцүүлгийг 130 аж ахуйн нэгжийн удирдлагууд, нийт 14 хорооны 210 иргэнийг хамруулан 2 удаа зохион байгуулав.	90.0
222	5.9. Замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, автын осол, түүнээс	Зам тээврийн осол хэргийн гаралтыг бууруулах үе шаттай арга хэмжээ авч ажиллана	Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай дүүргийн Засаг даргын 2014 оны А/50 дугаар захирамжийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж үр дүнг тухай бүр илтгэх хуудсаар хүргүүлж ажилласан. “Цахилгаан тээвэр” ХХК-ны 43 жолоочид “Замын	90.0

	учрах хохирлыг бууруулна.		хөдөлгөөний дүрэм"-ийн холбогдох заалтууд болон нийтийн тээврийн хэрэслийн жолооч нарын гаргаж буй нийтлэг зөрчил, зам тээврийн гэмт хэргийн шалтгаан, эрүүгийн хэргийн холбогдох заалтаар сургалт зохион байгууллаа. Дүүргийн нутаг дэвсгэрийн "Мандах бүртгэл", "Ач", "Монос" дээд сургууль, "Чингис соосэ" цогцолбор их сургуулийн нэгдүгээр курсийн нийт 828 оюутан сурагчдад "Замын хөдөлгөөний аюулгүй байдал" сэдэвт сургалт явуулж, сургалтын албыг сургалтын программ, гарын авлага материалаар хангасан. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн хэрэг, ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо 2013 оны мөн үетэй харьцуулахад гэмтсэн хүний тоо 58, нас барсан хүний тоо 1-ээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.	
223		Энхтайваны өргөн чөлөө 32-р байрны баруун урд талын замыг уулзвар болгон зохион байгуулахаар судалгаа, дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.	Энхтайваны өргөн чөлөө 32-р байрны баруун урд талын замыг уулзвар болгон зохион байгуулахаар судалгаа, тооцоо, дүгнэлт гарган, нийслэлийн Авто замын газар, нийслэлийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэст тус тус хүргүүлсэн.	70.0
224		Шаардлагатай байршлуудад авто замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохиог шинээр суурилуулна. /1-р хорооллын 34-р байрны хойно гэрлэн дохио, 22-р хороо Хилчин, Тахилт хэсгийн шинээр тавигдсан замд явган хүний гарцуудыг тавиулах/	2014 онд дүүргийн нутаг дэвсгэрийн шаардлагатай 10 байршилд анхааруулах тэмдэг 32, 5 байршилд заах тэмдэг 10, 3 байршилд мэдээлэх тэмдэг 6, 5 байршилд хурд сааруулагч 5, 2 байршилд, явган хүний гарц, замын тэмдэглэлийг тус тус хийсэн байна.	90.0
225		Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдийг замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна.	Сургуулийн өмнөх насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдэнд замын хөдөлгөөний мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор дүүргийн цэцэрлэгүүдийн дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2014" уламжлалт тэмцээнийг 4-р сард зохион байгуулж, нийт 144 хүүхэд оролцлоо. 5-р сард "АСА" циркд зохион байгуулагдсан нийслэлийн "Замын хөдөлгөөний цагаан толгой-2014" тэмцээнд 110-р цэцэрлэгийн "Гарц" баг тэргүүн байранд, шалгарсан байна. Ерөнхий боловсролын 16 сургуулийн 3-5-р ангийн 192 сурагчдыг хамруулан "Ногоон гэрэл-Цагаан шугам-2014" тэмцээнийг зохион байгуулсан.	90.0

226	5.10. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учрах хохирлыг бууруулна.	Гамшгаас хамгаалах албад, Онцгой комиссын гишүүд, хороодын Засаг дарга нар, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан штабын дадлага, гамшгийн эрсдлийг бууруулах, сургалт зохион байгуулна.	2014 онд батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу дүүргийн төрийн болон хувийн хэвшлийн нийт 177 байгууллагын 5227 ажилтан, албан хаагчид, оюутнуудын дунд 231 удаагийн 476 цагийн сургалт зохион байгуулж, нийт 13051 иргэнд 5 төрлийн 31620 ширхэг гарын авлага, сэрэмжлүүлэх материал тарааж ажилласан. Дүүргийн Засаг даргын А/71 дүгээр захирамжаар дүүргийн гамшгаас хамгаалах албадыг байгууллаа. А/72 дугаар захирамжийн хүрээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтыг 2014.04.24-25-ны хооронд зохион байгуулж сургалтанд дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүн, 38 байгууллагын 566 албан хаагч, 32 хорооноос 320 иргэн хамрагдлаа. Сургалтыг нийслэлийн Онцгой байдлын газраас бүрэн хангалттай гэж дүгнэсэн.	100.0
227		Гамшгаас хамгаалах техник хэрэгслийн хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	Дүүргийн Засаг даргын нөөц сангаас гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх ажилд нийт 9.9 сая төгрөгийн техник, хэрэгслийг хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.	100.0
228		Онцгой байдлын алба саадгүй хүрч ажиллах орчинг бий болгох зорилгоор дүүргийн гэр хорооллын айл өрхүүдийн мухар гудамж болон яаралтай дуудлагын автомашин хүрэлцэн очих боломжгүй зам гарцын судалгааг тодотгон зам гарц чөлөөтэй болгох арга хэмжээг зохион байгуулна.	Онцгой байдлын алба саадгүй хүрч ажиллах орчинг бий болгох зорилгоор дүүргийн гэр хорооллын айл өрхүүдийн мухар гудамж болон яаралтай дуудлагын автомашин хүрэлцэн очих боломжгүй зам гарцын судалгааг тодотгон зам гарц чөлөөтэй болгох арга хэмжээг зохион байгуулна.	100.0
229		1, 2, 3, 20-р хорооны дунд заагт байрлах хуучин цэргийн хотхоны хойгуурх шороон үерийн даланг инженерийн байгууламж бүхий үерийн далантай болгох талаар холбогдох байгууллагуудад уламжилна.	Үерийн далан байгуулах саналыг нийслэлийн Өмчийн харилцааны газар, нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ, зөвлөх компаниудад хүргүүлж дээрх байгууллагуудаас 1-2-р сард хамгаалалтын барилга байгууламжийн трассаар явж иргэдтэй зөвшилцөх ажлыг зохион байгуулсан.	100.0
230		Нарангийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг шинээр барих ажлыг эхлүүлнэ.	Нарангийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн шинэчилсэн трассыг зургийн зохиогч зөвлөх компаниар гаргуулсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас “Нарангийн үерийн хамгаалалтын суваг” нээлттэй тендер зарласан боловч хүчингүй болсон. Дахин зарлахад “Боорчи” ХХК	30.0

			шалгарсан ба Сангийн яаманд маргаан гарсны дагуу тендерийг хүчингүй болгосон. Иймд шууд гэрээ байгуулахаар ажиллаж байна.	
231	5.11. Аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтыг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.	Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавих мэргэжлийн хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд явуулан, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавих мэргэжлийн хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд явуулан шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор хяналт шалгалт хийх зарлагдсан 100 гаруй ААНБ-д “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, тогтоомжийн биелэлтийг шалгасан байна. Шалгалтанд барилга угсралтын 34 ААНБ, барилгын материалын үйлдвэр 25, хүнсний үйлдвэр 12, зам барилгын 3, бусад орон сууцны үйлчилгээний 6 салбар хамрагдсан байна. Дүүргийн Засаг даргын 2014 оны 3-р сарын 31-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/87 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Барилга угсралтын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах асуудлыг зохицуулах нийтлэг журам”-ыг хэрэгжилтийг хангуулахаар 22 барилгын нэгж объектод хяналт шалгалтыг хийсэн байна. Шалгалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахтай холбогдсан нийт 300 гаруй зөрчил илрүүлж, 22 албан шаардлага бичиж, 7 ААНБ-ын үйл ажиллагааг түр хугацаагаар хэсэгчлэн зогсоож, 18 ААНБ-д 7190.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч, нийт 44 ААНБ-д зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.	90.0
232		Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөр, аюулгүй ажиллагааны зохион байгуулалтын талаар хууль дүрмийн хүрээнд сургалт зохион байгуулна.	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор “Автобус”-тай зөөврийн танхимаар нийт 5 удаагийн сургалтаар 14 ААНБ-ын 300 гаруй ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны анхан шатны сургалт мэдээллээр хангаж, 36 ААНБ-ын 200 гаруй ажилтнуудад “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах нь” сэдэвт сургалтыг бие даан зохион байгуулсан. Эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд нийтийн эзэмшлийн зам, талбайд болон барилгын объектод ажиллаж байгаа ажилтан, иргэний аюулгүй байдлыг зайлшгүй хангах зориулалт бүхий хаалт хашлага, хамгаалалтын байгууламжийг 16 ААНБ-д шинээр барьж ашигласан байна. 11-р сарын 15-ны байдлаар 20 осол бүртгэгдсэнээс нас барсан 2, хөнгөн буюу	90.0

			хөдөлмөрийн чадвараа түр алдсан 4, хүнд буюу хэсэгчлэн алдсан 13 хүн бүртгэгдсэн нь 2013 оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Үйлдвэрлэлийн ослыг салбараар нь авч үзвэл: Барилга угсралт 1, барилгын материалын үйлдвэрт 4, хөнгөн хүнсний үйлдвэрт 5, уул уурхай 1, төрийн байгууллагад 1, боловсрол 1, эрүүл мэнд 1, эрчим хүч 1, зам тээвэр 4, худалдаа үйлчилгээнд 1 осол тус тус бүртгэгдсэн байна.	
233	5.12. Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавин иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.	Цэргийн тоо бүртгэлийн мэдээлийн санг төгөлдөржүүлж, цэргийн үүрэгтнүүдийн цэргийн мэргэжлийн дугаарыг шинэ зааврын дагуу сольж өөрчлөнө.	2014 оны цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын тоо бүртгэлээр мэдээллийн сангийн программыг боловсронгуй болгож, цэргийн үүрэгтний мэдээллийг олон сонголтоор ашиглах боломж бүрдсэн. 2014 оны бүртгэлийн дүнг үндэслэн оногдуулан данслагдсан болон нөөцөд байгаа бэлтгэл офицер, цэргийн үүрэгтний цэргийн мэргэжлийн дугаарыг шинэ зааврын дагуу мэдээллийн санд бүрэн солих ажлыг зохион байгуулсан. Энэхүү ажлууд хийгдснээр дайчилгааны бэлэн байдлыг хангах, даалгаврыг богино хугацаанд биелүүлж, мэдээ судалгааг шуурхай гаргах боломж бүрдсэн.	100.0
234		Бүх шатны сургалтыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, албан тушаалтнуудын мэдлэг, дадлага, чадварыг нэмэгдүүлнэ.	Дайчилгааны бэлтгэл нөөц, цэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн бага “Химичин цэвэрлэгч”, “Дозиметрчин” мэргэжил олгох сургалтыг 04-р сарын 07-17-ныг хүртэл хугацаанд Зэвсэгт хүчний 119-р ангийн хээрийн сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулагдаж явуулсан. Дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтанд тус дүүргийн хилийн болон дотоодын цэрэгт алба хаасан 30 иргэн хамрагдлаа. Батлан хамгаалах их сургуулийн Цэргийн командын сургуулийн сургалтын материаллаг баазыг түшиглэн бэлтгэл офицерын сургалтыг 04-р сарын 04-23-ныг хүртэл хугацаанд зохион байгуулан даалгавраар тогтоогдсон мэргэжлээр иргэний их дээд сургууль төгсөж, цэргийн үүргээ биелүүлсэн 7 цэргийн үүрэгтнийг судлан суралцуулж, эзэмшсэн цэргийн мэргэжлээр нь оногдуулан данслав. Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу цугларах, шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнтэй мэдлэг, дадлага олгох сургалтыг зохион байгуулж явуулсан. Дүүргийн Засаг даргын 2014 оны А/41 дүгээр захирамжаар хорооны Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалт” 03-р сарын 20, 21-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 311-р ангийн байрлалд зохион байгуулагдаж явагдав. Дүүргийн Засаг даргын “Сургалт зохион байгуулах тухай” А/178 дугаар	100.0

			захирамжийн дагуу Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын анхан шатны сургалт Зэвсэгт хүчний 326-р ангийн байрлалд 06-р сарын 03-17-ныг хүртэл хугацаанд зохион байгуулж 2014 онд цэргийн дүйцүүлэх албанд элссэн 8 алба хаагчийг хамруулан онол, дадлагын 114 цагийн хичээлийг удирдан явуулсан. Дүүргийн Засаг даргын А/332 дугаар захирамжийн дагуу цэргийн дүйцүүлэх алба хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг, дадлагыг гүнзгийрүүлэх сургалтыг 2014 оны 09 дүгээр сарын 19-нөөс 10 дугаар сарын 03-ныг хүртэл хугацаанд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангийн байрлалд зохион байгуулж явуулсан. Дайчилгаа удирдах бүлгийн гишүүдтэй явуулах сургалтыг 09-р сарын 04-ний өдөр дүүргийн Иргэний танхимд зохион байгуулж мэдлэг, дадлагыг эзэмшүүлсэн.	
235		Дайчилгаатай тусгай тактикийн хээрийн сургуульд бэлтгэл хангаж оролцоно.	Зэвсэгт хүчний дугаар ангид явагдсан дайчилгаатай команд-штабын болон тусгай тактикийн хээрийн сургуульд дайчилгааны даалгаварын дагуу бэлтгэл офицер, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, авто техникийг осол зөрчилгүй бүрэн татан нийлүүлж, дайчилгаатай команд штабын болон тусгай тактикийн хээрийн сургуулийн зорилгыг ханган биелүүлэхэд өгөгдсөн үүргээ амжилттай биелүүлж оролцов.	100.0
236		Цэргийн насны залуучуудын эрүүлжүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.	Цэргийн насны залуучуудын эрүүлжилтийн талаар “Эрүүл хүн-эрүүл дүүрэг” хөтөлбөрт холбогдох зохицуулалтыг тусгасан. “Хааны эрэлд” олон улсын хээрийн сургуулийн цэргийн багийн эмч нарын “Эмнэлэг хүмүүнлэгийн ажиллагаа” эрүүл мэндийн үзлэг оношилгоонд 32 хорооны эрүүл мэндээр тэнцдэггүй 2140 цэргийн насны залуучуудын нэрийн жагсаалт гарган хамруулж, хөнгөн эмчлэгдэх боломжтой 84 иргэнд эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн.	100.0
237	5.13. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлж, өндөр хөгжилтэй орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоон, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг татаж ажиллана.	Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргүүдтэй үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хөгжингүй орны хот, дүүргүүдтэй шинээр хамтын ажиллагаа тогтооно.	Харилцаа, хамтын ажиллагаатай БНХАУ-ын ӨМӨЗО-ын Хөлөнбуйр аймгийн Хайлаар дүүргийн төлөөлөгчдийг хүлээн авч талууд 2014 оны 2 дахь хагаст хамтран ажиллах төлөвлөгөөг хэлэлцсэн. Мөн 6-р сарын 29-өөс 7-р сарын 04-ний өдрүүдэд Хайлаарт болсон Хятад, Монгол, Орос 3 улсын Эдийн засгийн форум, Үзэсгэлэн яармаг худалдаанд дүүргийн нутгийн захиргааны болон жижиг дунд үйлдвэрлэлийн төлөөлөгчид оролцлоо. Аж үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал хослуулан хөгжүүлсэн өвөрмөц онцлогтой Японы	100.0

			<p>Шизүока мужийн Изүнокүни хотын талаар судалгаа хийж, хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг үзүүлэх талаар Засаг даргын 1/2017 дугаартай албан бичгийг Монгол Улсаас Японы Осака хотод суугаа Ерөнхий консулд илгээсний дагуу Изүнокүни хотын захиргааны Стратегийн хэлтсийн дарга Хироши Моришимагаар ахлуулсан төлөөлөгчид дүүрэгтэй танилцах, хамтын ажиллагааны төлөвлөгөө хэлэлцэх зорилгоор 9, 11-р сард 2 удаа ажлын айлчлал хийсэн бөгөөд 2015 оны 8-р сард тус хотын дарга Оно Тошико хүрэлцэн хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар болсон. Дүүргийн зүгээс БНХАУ-ын Хянган аймгийн Рашаан хоттой хамтын ажиллагаа тогтоох хүсэлт тавьсныг Хятадын тал нааштайгаар хүлээн авч, хоёр тал найрсаг харилцаа тогтоох, хамтын ажиллагааны гэрээ байгуулах ажлуудыг шат дараатайгаар хийсэн. 9-р сарын 06-ны өдөр Рашаан хотын төлөөлөгчид хүрэлцэн ирж хамтын ажиллагааны чиглэлийг хэлэлцэж тохирсоны үндсэн дээр 9-р сарын 27-ны өдөр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.</p>	
238	<p>5.14. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ХЭАХН, ШӨХТГ-тай хамтран ажиллана.</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Олон улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагаас 2014 оны Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг “Утсан харилцаагаар үйлчлүүлэгчдийн эрхийг хангая” уриан дор тэмдэглэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн үүрэн холбооны салбар байгууллагуудад хамтарч ажиллах чиглэлийг албан бичиг, сурталчилгааны самбар хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна. Дүүргийн ХЭАХН хэрэглэгчийн эрх зөрчигдсөн асуудлаар 120 санал гомдол хүлээн авч, 15473,0 мянган төгрөгний хохирлыг шүүхэд шийдвэрлүүлэн, санал гомдол үүсгэсэн байгууллага, иргэдэд “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, тухайн зөрчилтэй холбогдсон шийдвэр, журмуудыг сурталчлан, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас дэлхийн улс орнуудын Засгийн газрын анхаарлыг хандуулан тунхагласан хэрэглэгчийн үндсэн 8 эрхийн тухай мэдээллийн самбарыг дүүргийн ЗДТГ-т байрлуулсан. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт гоо сайхан, хими цэвэрлэгээний чиглэлээр үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг явуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Шалгалтанд гоо</p>	70.0

			сайхны 9, хими цэвэрлэгээний 1, захиалга хүлээн авах 10 цэг хамрагдан, бүтээгдэхүүний шинжилгээний бичиг баталгаагүй, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангахгүй, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй зэрэг нийтлэг зөрчил илэрснийг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад уламжилсан.	
--	--	--	---	--

---000---